



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# **“БАГШ, БАГА БОЛОВСРОЛ” ХӨТӨЛБӨРӨӨР ТӨГСӨГЧДИЙН ЧАДАМЖИЙН ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар  
2022 он

## **АГУУЛГА**

<b>Хүснэгтийн жагсаалт.....</b>	<b>3</b>
<b>Зургийн жагсаалт.....</b>	<b>4</b>
<b>Товчилсон үгийн жагсаалт.....</b>	<b>5</b>
<b>НЭГ. БАГШИЙН ЦОГЦ ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ.....</b>	<b>6</b>
<b>1.1. Удиртгал.....</b>	<b>6</b>
<b>1.2. Багшийн цогц чадамжийн талаарх ойлголт.....</b>	<b>9</b>
<b>1.3. Монгол Улсын бодлого, эрх зүйн баримт бичгүүд.....</b>	<b>10</b>
<b>1.4. Багшийн цогц чадамжийн хүрээ: Олон улсын туршлага.....</b>	<b>15</b>
1.4.1. Олон улсын хэмжээний багшийн цогц чадамжийн хүрээ.....	15
1.4.2. Гадаадын зарим орны багшийн цогц чадамжийн хүрээ.....	23
<b>1.5. Багшийн цогц чадамжийн хүрээнд хийсэн харьцуулсан шинжилгээ, түүний үр дүн</b>	<b>26</b>
<b>ХОЁР. БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ МЭРГЭЖЛИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН СУДАЛГАА.....</b>	<b>33</b>
<b>2.1. Монгол Улсын бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн</b>	<b>33</b>
<b>2.2. Гадаад улсын бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн ..</b>	<b>37</b>
<b>ГУРАВ. “БАГШ, БАГА БОЛОВСРОЛ” ХӨТӨЛБӨРӨӨР ТӨГСӨГЧИЙН ХӨГЖИХ ХЭРЭГЦЭЭНИЙ БОЛОН АЖИЛ ОЛГОГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА.....</b>	<b>57</b>
<b>3.1. Судалгааны товч танилцуулга.....</b>	<b>57</b>
<b>3.2. Судалгааны үр дүнд хийсэн хүчин зүйлийн шинжилгээ.....</b>	<b>60</b>
<b>3.3. “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчийн хөгжих хэрэгцээний судалгааны үр дүн 63</b>	
3.3.1. Ерөнхий мэдээлэл.....	63
3.2.2. Үндсэн асуулга.....	66
<b>3.4. Ажил олгогчийн (сургалтын менежер) сэтгэл ханамжийн судалгааны үр дүн.....</b>	<b>75</b>
3.4.1.Ерөнхий мэдээлэл.....	75
3.4.2.Үндсэн асуулга.....	76
<b>3.5. “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгч (багш) болон ажил олгогч (сургалтын менежер)-ийн асуулга судалгааны харьцуулсан үр дүн.....</b>	<b>87</b>
<b>ХАВСРАЛТУУД.....</b>	<b>99</b>

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Монгол багшийн загвар .....	12
Хүснэгт 2. . Зүүн Өмнөд Азийн Багшийн цогц чадамжийн хүрээ.....	16
Хүснэгт 3. 21-р зууны Багшийн цогц чадамжууд .....	17
Хүснэгт 4. Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээний бүрдэл .....	18
Хүснэгт 5. Мэргэжлийн стандартын дэлхийн дахины хүрээний бүрдэл.....	19
Хүснэгт 6. Мэргэжлийн чадамжийн рубрик.....	21
Хүснэгт 7. Багшийн мэдээлэл харилцаа, технологийн чадамжийн хүрээ.....	23
Хүснэгт 8. Австрали Улсын багшийн цогц чадамжийн хүрээ.....	24
Хүснэгт 9. 21-р зууны багшийн шинж чанарууд.....	25
Хүснэгт 10. Сингапур Улсын шинэ төгсөгчийн чадамжийн хүрээ .....	25
Хүснэгт 11. Хонгконгийн багшийн цогц чадамжийн хүрээ.....	26
Хүснэгт 12. Сонгогдсон эх сурвалжуудын жагсаалт .....	27
Хүснэгт 13. Багшийн цогц чадамжийн хүрээний ай буюу бүрэлдэхүүн .....	28
<i>Хүснэгт 14. Олон улсын хэмжээний баримт бичигт хийсэн харьцуулсан шинжилгээний үр дүн...</i>	<i>30</i>
Хүснэгт 15. Монгол Улсын Бага боловсролын багш мэргэжлээр төгсөгчдийн хувь хүний болон мэргэжлийн ур чадвар дадал төлөвшлийн нэгтгэл .....	33
Хүснэгт 16. ОХУ-ын Москвагийн Улсын Сэтгэл Судлал Сурган Хүмүүжүүлэх Ухааны Их Сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн .....	37
Хүснэгт 17. Шинэ Зеланд улсын Аукландын Их Сургуулийн сургалтын .....	47
Хүснэгт 18. Финлянд Улсын Оулугийн Их Сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн.....	49
Хүснэгт 19. Филиппины бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн.....	50
Хүснэгт 20. Филиппины бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд.....	51
Хүснэгт 21. Солонгосын бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн.....	54
Хүснэгт 22. Түүвэрт сонгогдсон сургуулийн мэдээлэл (бүс, багшийн тоо).....	58
Хүснэгт 23 Түүвэр (сургуулийн нэрээр) .....	59
Хүснэгт 24. Найдвартай байдал (Reliability Statistics) .....	61
Хүснэгт 25. Түүврийн хүрэлцээтэй байдлын шинжилгээ .....	61
Хүснэгт 26. Судалгаанд хамрагдсан багш нарын сургуулийн байршил ба өмчийн хэлбэр .....	63
Хүснэгт 27. Сурагчдын тоо (ангиар багшийн эзлэх хувь).....	66
Хүснэгт 28. Сургалтын хөтөлбөрийн агуулгын өөрчлөлт (эрэмбэ, хувь).....	68
Хүснэгт 29. Бага боловсролын багшийн чадамжид өгсөн сургалтын менежерийн үнэлгээ (ажилласан жилээр).....	77
Хүснэгт 30. Багш, бага боловсрол мэргэжлийн чадамж.....	79
Хүснэгт 31. Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээл.....	92
Хүснэгт 32. Заахад хүндрэлтэй хичээл (хувь) .....	94

## Зургийн жагсаалт

Зураг 1. Сайн багш, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хүрээ.....	6
Зураг 2. “Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрийн төгсөгчийн чадамжийн хүрээ боловсруулах үе шат, хүлээгдэж буй үр дүн .....	9
Зураг 3. 21-р зууны Монгол багш загвар .....	11
Зураг 4. Зүүн Өмнөд Азийн Багшийн цогц чадамжийн хүрээ .....	15
Зураг 5. ЭЗХАХБ Сургалтын луужин 2030 .....	20
Зураг 6. ЭЗХАХБ гол цогц чадамжууд.....	22
Зураг 7. Багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээ .....	31
Зураг 8. Судалгаанд хамрагдсан багшийн бүсийн төлөөлөл.....	63
Зураг 9. Судалгаанд хамрагдсан багш нарын насны бүлэг (багшийн тоо, эзлэх хувь) .....	64
Зураг 10. Боловсролын түвшин.....	64
Зураг 11. Багшийн мэргэжлийн зэрэг ба боловсролын түвшин (хувь) .....	64
Зураг 12. Ажилласан жил .....	65
Зураг 13. Багшийн мэргэшсэн чиглэл (давхардсан тоо ба судлагдахуунаар).....	65
Зураг 14. Хичээл заадаг анги.....	65
Зураг 15. Багш мэргэжлээр төгсөгчийн сэтгэл ханамж (хувь).....	66
Зураг 16. Хичээлүүдээр олгосон мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ .....	67
Зураг 17. Хөтөлбөрийн агуулын өөрчлөлт (дан тоолол) .....	68
Зураг 18. Заахад хүндрэлтэй хичээл (хувь).....	69
Зураг 19. Багшийн ажлын байранд тулгамдаж буй бэрхшээл (хувь) .....	70
Зураг 20. Хичээл сургалт зохион байгуулахад тулгардаг бэрхшээл .....	71
Зураг 21. Хувь хүний чадвар ба хандлага .....	72
Зураг 22. Мэргэжлийн чадвар ба хандлага .....	72
Зураг 23. Багшийн хөгжих хэрэгцээ .....	73
Зураг 24. Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа .....	74
Зураг 25. Мэргэшсэн чиглэл.....	76
Зураг 26. Бага ангийн багш нараа сонгож авдаг арга, хэрэгсэл.....	76
Зураг 27. Бага ангийн багш бэлтгэж байгаа сургалтын хөтөлбөрт хийх шаардлагатай агуулгын өөрчлөлт .....	78
Зураг 28. Бага ангийн багш бэлтгэж буй дээд боловсролын сургалтын хөтөлбөр болон “Бага боловсролын сургалтын хөтөлбөр”-ийн хоорондын холбоо хамаарал.....	79
Зураг 29. Бага ангийн багшийн ажлын байран дээр тулгамдаж бэрхшээл .....	80
Зураг 30. Бага ангийн багшийн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээл .....	81
Зураг 31. Бага ангийн багш нарын заахад хүндрэлтэй хичээл .....	81
Зураг 32. Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа .....	81
Зураг 33. Бага ангийн багш нарын хөгжих нийтлэг хэрэгцээ .....	82
Зураг 34. Бага ангийн багш нарт үүссэн хөгжих хэрэгцээг шийдвэрлэдэг арга зам.....	82
Зураг 35. Эх хэл, онол ба математик, онол хичээлүүдийн харьцуулалт .....	87
Зураг 36. Байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн онол хичээлүүдийн харьцуулалт.....	88
Зураг 37. Эх хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн арга зүйн хичээлүүдийн харьцуулалт (давхар тоолол) .....	88
Зураг 38. Танилцах, туршин заах, багшлах дадлагуудын харьцуулалт .....	89
Зураг 39. Мэргэжлийн хөгжил, үнэт зүйл айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн.....	90
Зураг 40. Мэдлэг, ойлголт айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн .....	91
Зураг 41. Багшлахуй ба суралцахуй айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн .....	91
Зураг 42. Хамтын ажиллагаа айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн.....	92
Зураг 43. Мэргэжлийн хөгжил, үнэт зүйл айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн.....	92
Зураг 44. Бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээ .....	93
Зураг 45. Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа .....	95

## Товчилсон үгийн жагсаалт

<b>Товчилсон нэр</b>	<b>Тайлбар</b>
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
МХТ	Мэдээлэл харилцаа, технологи
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
СХУ	Сурган хүмүүжүүлэх ухаан
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага


# НЭГ. БАГШИЙН ЦОГЦ ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ

## 1.1. Удиртгал

Дэлхий нийтэд улс орны хөгжил боловсролын чанараас хамаарч байгааг онцолж, 2015 онд НҮБ-ын гишүүн улсууд 2030 он гэхэд Тогтвортой хөгжлийн зорилго 4 “Чанартай боловсрол”-д хүрнэ гэсэн зорилго тавьсан байдаг. Энэ зорилгод хүрэхийн тулд багшийн үүрэг, оролцоо чухал болохыг дэлхий нийт хүлээн зөвшөөрч, улсынхаа боловсролын чанарыг сайжруулах нэг арга зам нь багшийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх хэмээн үзэж тэдэнтэй холбоотой бодлогод илүүтэй анхаарах боллоо.

ЮНЕСКО-оос 2019 онд гаргасан “Багшийн бодлогыг боловсруулах удирдамж”, 2021 онд гаргасан “Бидний ирээдүйг хамтдаа дахин төсөөлөх нь: боловсролын шинэ нийгмийн гэрээ” зэрэг баримт бичгүүдэд дурдсанаар сайн багшийг бий болгоход макро түвшиндээ багшийг дэмжсэн, уялдаа бүхий бодлого, эрх зүй чухал болохыг тэмдэглэжээ. Үүнээс гадна сургуулийн орчин болон багшийн мэргэжлийн хөгжил нь сайн багшийг бий болгоход дэмжлэг үзүүлдэг хүчин зүйлс болохыг тодотгосон байна.

Зураг 1. Сайн багш, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хүрээ



Эх сурвалж: (UNESCO, 2019)

Тухайлбал, багшийн мэргэжлийн хөгжил нь багш бэлтгэх сургалт, боловсролын зэрэг ахиулах сургалт, мэргэжил дээшлүүлэх төрөл бүрийн үйл ажиллагааг хамардаг өргөн ойлголт бүхий хүчин зүйл юм. Сургалтын сайн боловсруулсан хөтөлбөрөөр оюутан багшийг бэлтгэж, багшийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа нь багшийн цогц чадамж, багшлах туршлагыг дээшлүүлэх юм. Ингэснээр сайн багш болоход нь дэмжлэг үзүүлж, суралцагчийн хөгжилд хувь нэмэр оруулах боломж бүрдэх юм. Тиймээс багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн хөтөлбөр зэрэг нь багшийн чадамжийг бий болгох, сайжруулахад чиглэсэн байх нь чухал байдаг.

Монгол Улсын хувьд багшийн цогц чадамжийн хүрээ байхгүй байгаа нь энэхүү хүрээг боловсруулах хэрэгцээг бий болгож байна. Багшийн цогц чадамжийн хүрээ нь багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхой болгож, багш нар мэргэжлийн хөгжлийн хэрэгцээгээ оношлох, хөтөлбөр боловсруулагч, сургалт зохион байгуулагч нар хөтөлбөр, сургалтын агуулга, хүрэх үр дүнгээ тодорхойлоход ач холбогдолтой төдийгүй багшийн мэргэжлийн стандарт, хөгжлийн хөтөлбөр боловсруулахад баримтлах чиглэл болох юм.

### **Судалгааны зорилго, зорилт**

Энэхүү судалгааны зорилго нь олон улсын хэмжээний болон тухайлсан улс орны багшийн цогц чадамжуудыг харьцуулан шинжилж, “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчдийн чадамжийн хүрээ боловсруулахад оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

1. Багшийн цогц чадамжийн талаарх ойлголт, нэр томъёог тодруулах;
2. Монгол Улсын бодлого, эрх зүйн баримт бичиг болон олон улсын баримт бичгүүдэд багшийн чадамжтай холбоотой асуудлыг судлан шинжлэх;
3. Олон улсын болон дэлхийн хэмжээний багшийн цогц чадамжуудын хүрээнд харьцуулсан шинжилгээ хийх;
4. Монгол Улсын багшийн загвар болон гадаад улс орны багшийн цогц чадамжуудын хүрээнд харьцуулсан шинжилгээ хийх;
5. Харьцуулсан шинжилгээний үр дүнд үндэслэн “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчдийн чадамжийн хүрээ боловсруулах.

### **Судалгааны арга, аргачлал**

1990 онд судлаач Страус “Grounded theory”-ийг үндэслэсэн бөгөөд энэхүү бүтээл нь өнөөдрийг хүртэлх хугацаанд 83,609 удаа эшлэгдсэн байна. “Grounded theory”- д үндэслэн 2009 онд судлаач Жабарээн чанарын судалгааны суурь аргачлал болох “Үзэл баримтлалын бүтэцлэгдсэн хүрээ боловсруулах аргачлал”-ыг гаргасан бөгөөд энэ аргачлалыг одоогийн байдлаар 1782 удаа эшилж, ашигласан байна. Энэхүү аргачлалыг БСҮХ-ийн эрдэмтэн, судлаачид, Эрдмийн зөвлөл, МУБИС-ийн захиргааны зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэн сайжруулж, улмаар БСҮХ хэд хэдэн судалгаануудад ашиглаж байна. Тодруулбал, “Сургалтын хөтөлбөрт тусгах үнэт зүйлийн хүрээг тодорхойлох”, “Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох” судалгаануудад энэхүү аргачлалыг ашиглаж, амжилттай туршсан билээ. Иймд “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчдийн чадамжийн хүрээг тодорхойлох судалгаанд энэхүү аргачлалыг ашиглах нь тохиромжтой гэж судалгааны баг үзэж, сонгон ашигласан болно.

“Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрийн төгсөгчийн чадамжийн хүрээг дараах 7 үе шатын дагуу боловсруулна. Үүнд:

*Үе шат 1: Холбогдох эх сурвалжуудыг сонгох, төлөвлөх, зураглах*

Энэ үе шатны хүрээнд холбогдох эх сурвалжуудыг сонгох, төлөвлөх, зураглах ажлууд хийгдэнэ. Эх сурвалж гэдэгт олон чиглэлийг хамарсан эмпирик болон бүтээлийн тойм судалгаанууд багтана. Эдгээрээс гадна шаардлагатай тохиолдолд тухайн чиглэлийн мэргэжлийн бүлгийн хүрээнд фокус ярилцлага зохион байгуулж болно.

*Үе шат 2: Өргөтгөсөн шинжилгээ хийх, сонгосон эх сурвалжуудыг ангилах*

Энэ үе шатанд сонгосон эх сурвалжуудыг шинжлэх, судлагдахууны чиглэлээр болон тухайн судлагдахууны хүрээн дэх ач холбогдол, төлөөлөх чадамжаар ангилах ажлууд хийгдэнэ. Энэ үйл явц нь шинжилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, тухайн судлагдахууны хамгийн боломжит төлөөллийг тодорхойлох боломжийг нэмэгдүүлнэ.

*Үе шат 3: Чадамжийн хүрээг тодорхойлох, нэришл өгөх*

Энэ үе шатанд сонгож, ангилсан эх сурвалжуудад дахин уншилт, шинжилгээ хийж тодорхой чадамжийн айг нээх, илрүүлэх, тодорхойлох ажил хийгдэнэ. Сонгогдсон эх сурвалжуудад хийсэн шинжилгээний үр дүнд нь ижил төстэй болон эсрэгцсэн чадамжийн айн жагсаалт гарна.

*Үе шат 4: Чадамжийн айг задлах, ангилах*

Энэ үе шатны хүрээнд чадамжийн ай нэг бүрийн онцлог, шинж чанар, ухагдахуун, үүргийг танин мэдэх зорилгоор задлах, онцлог, шинж чанаруудад нь үндэслэн ангилах (тухайлбал, онтологи болон танин мэдэхүйн онолын үүднээс, арга зүйн үүргийн үүднээс гэх мэт шинж чанаруудаар ангилж болно)

*Үе шат 5: Чадамжийн айнуудыг интеграцчилах*

Энэ үе шатанд ижил төстэй чанаруудаас тогтсон чадамжийн айнуудыг бүлэглэж, нэгтгэн нэг шинэ концепц гаргаж авна. Энэ үйл явц нь концепцуудын тоог багасгаж, утга учиртай цөөн тооны чадамжийн ай гаргаж авахад тусална.

*Үе шат 6: Нэгтгэх, дахин нэгтгэх, хооронд нь ойлгомжтойгоор уялдуулах, онолжуулах*

Энэ үе шатны хүрээнд чадамжийн айнуудыг нэгтгэх замаар онолын хүрээ гаргана. Энэхүү шинэ гэж хэлж болохуйц онолын хүрээ гаргах үйл явц судлаачаас нээлттэй, тэвчээртэй, уян хатан байхыг шаарддаг бөгөөд онолжуулах үйл явцын хүрээнд ерөнхий онолын хүрээг тодорхойлж гаргах хүртэл нэгтгэх үйл явцыг олон давтамжтайгаар хийх шаардлагатай болно.

*Үе шат 7. Чадамжийн хүрээг баталгаажуулах*

Энэ үе шатанд тодорхойлсон чадамжийн бүтэцчилсэн хүрээг баталгаажуулах бөгөөд ингэхдээ тухайн санал болгож буй шинэ чадамжийн бүтэцчилсэн хүрээ нь зөвхөн судлаачдын тухайд төдийгүй бусад эрдэмтэд, мэргэжилтнүүдэд ойлгомжтой эсэхэд хариулт өгнө. Энэхүү баталгаажуулах үйл явц нь судлаачдаас эхлээд бусад мэргэжлийн бүлгүүдийн хүрээнд хийгдэнэ. Тухайлбал, шинээр танилцуулж буй концепцийн бүтэцчилсэн хүрээгээ эрдэм шинжилгээний хурал, семинараар хэлэлцүүлж, мэргэжлийн санал, шүүмжүүдийг тусган сайжруулж болно.



Судалгааны аргачлалын үе шат бүрийн үйл явц, хүрэх үр дүнг Зураг 2-г харуулав.

Зураг 2. “Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрийн төгсөгчийн чадамжийн хүрээ боловсруулах үе шат, хүлээгдэж буй үр дүн



Эх сурвалж: БСҮХ-ээс боловсруулсан үзэл баримтлалын бүтэцчилсэн хүрээ боловсруулах аргачлалд суурилав.

## 1.2. Багшийн цогц чадамжийн талаарх ойлголт

Юуны өмнө энэхүү судалгаанд “чадамж”, “багшийн цогц чадамж”, “хүрээ” гэсэн нэр томъёонуудыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар тодорхойлох шаардлагатай. Монгол хэлний их тайлбар тольд “чадамж” гэсэн үгийг “чадах боломж, хэмжээ”, “цогц” гэсэн үгийг “иж бүрдэл, нэгдмэл зүйл” гэж тайлбарласан бол “хүрээ” гэсэн үгийн утгыг “зах ирмэг, гадуур тойрсон зүйл, хэмжээ хязгаар” гэж тайлбарлажээ. Үүнээс гадна Европын Холбоо (2013) “цогц чадамж” гэдэг нь “Тодорхой газар нутагт хүний үйлдэлд шингэсэн, үр нөлөөтэй байхад чиглүүлэх мэдлэг, чадвар, ойлголт, үнэт зүйлс, хандлага болон хүсэл тэмүүллийн цогц нэгдэл юм” гэж тодорхойлсон байна (хууд. 7). Энэ тодорхойлолттой мөн нэгэн адил ЭЗХАХБ (2017) “цогц чадамж” бол “Тодорхой газрын төрөл бүрийн эрэлт хэрэгцээг сэтгэц-нийгмийн цогц нөөц (танин мэдэхүйн, үйл ажиллагааны, хувь хүний болон ёс суртахууны)-ийг дайчлах замаар тэдгээр хэрэгцээг хангах тасралтгүй, дэвшилттэй чадамж юм” гэжээ (хууд. 77).

Харин “багшийн цогц чадамж”-ийг Европын Холбоо (2013) “Танин мэдэхүйн болон мета танин мэдэхүйн динамик нэгдэл бөгөөд багш шиг сэтгэж, мэдэж, ойлгож, үйлдэж суралцах гэсэн 4 суурь бүрдэлтэй” гэж тодорхойлсон (хууд. 12) бол Берт Кримерс нар (2013) “Багшийн цогц чадамж гэдэг нь хүүхдийн оюуны, нийгэм, сэтгэл хөдлөл, биеийн хөгжлийг дэмжих мэдлэг, чадвар, хандлага болон зан үйлийг илэрхийлнэ” гэжээ. Эдгээр тодорхойлолтоос үзвэл багшийн цогц чадамж гэдгийг суралцагчийн хөгжлийг дэмжихийн тулд тодорхой нөхцөлд багшаас дайчлан гаргаж буй мэдлэг, чадвар, хандлага болон зан үйлийн нэгдэл гэж тодорхойлж болохоор байна.

Дээрх нэр томъёонуудаас гадна “багшийн мэргэжлийн стандарт” гэсэн нэр томъёог мөн энд тодорхойлох шаардлага гарна. Учир нь дэлхийн улс орнуудын хувьд “багшийн цогц

чадамж” болон “багшийн мэргэжлийн стандарт” гэсэн нэр томъёонуудыг ойролцоо утгаар ашиглаж ирсэн бөгөөд энэ хоёр ойлголтын ялгаа юунд оршиж байгааг тодорхойлсноор “багшийн цогц чадамжийн хүрээ”-г зөв ойлгож боловсруулахад чухал ач холбогдолтой юм. Тэгвэл “багшийн мэргэжлийн стандарт” гэдгийг “багш мэргэжлийнхээ хувьд юуг мэдэж, юуг чадаж байхыг тогтоодог шалгуур бүхий гүйцэтгэлийн түвшин” гэж тайлбарласан (Commission, 2013; OECD, 2017) нь түүнийг илүү хариуцлагатай холбосон, тухайн шалгуур түвшнийг хангахыг шаардсан шинжтэй, хэм хэмжээ тогтоосон баримт бичиг болохыг илтгэж байна. Багшийн мэргэжлийн стандартыг хэрэглэдэг улс орнуудад АНУ, Англи, Австрали зэрэг улс орж байгаа бөгөөд харин багшийн цогц чадамжийн хүрээг ихэвчлэн Европын улс орнууд болох Франц, Португал, Белги, Недерланд, мөн түүнчлэн Хонконг, Сингапур зэрэг улс орнуудад ашиглаж байна. Энэ ялгаатай байдал нь улс орнууд багш бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэхдээ стандартад суурилах уу, эсвэл чадамжид суурилах уу гэсэн багш бэлтгэх, хөгжүүлэх бодлоготой холбоотой байдаг. Гэсэн хэдий ч багшийн мэргэжлийн стандарт нь багшийн мэдлэг, чадвар, хандлага зэргийн нэгдэл болох багшийн цогц чадамжид суурилж гардаг. Өөрөөр хэлбэл, тухайн чадамжийн хүрээнд багш яг ямар зүйлийг мэддэг байх, ямар зүйлийг чаддаг байхыг шаардахыг стандартаар тогтоож өгдөг гэсэн үг. Иймээс энэ хоёр нэр томъёог ижил утга илэрхийлдэг гэж үзсээр иржээ.

Багшийн цогц чадамжийн хүрээг багш бэлтгэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, багш өөрөө хөгжих хэрэгцээгээ тодорхойлоход ашигладаг бөгөөд улс орнуудын хувьд багш мэргэжлээр төгсөгчийн цогц чадамжийн хүрээ болон багшаар ажиллаж буй багшийн цогц чадамжийн хүрээ гэж ялгаатай тогтоох үзэгдэл байдаг. Гэхдээ багшийн боловсрол нь дэлхий нийтэд насан туршийн, тасралтгүй байх зарчмыг баримталж байгаа учир энэхүү судалгаагаар зөвхөн багш мэргэжлээр төгсөгч төдийгүй багшаар ажиллаж буй багшид хамаарах нийтлэг багшийн цогц чадамжийн хүрээг тодорхойлно.

### **1.3. Монгол Улсын бодлого, эрх зүйн баримт бичгүүд**

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалжуудыг тайлцуулахаас өмнө багшийн цогц чадамжтай холбоотой гэж үзэж болох Монгол Улсын бодлого, эрх зүйн баримт бичгүүд болон Монгол багшийн загварын талаарх судалгааны эх сурвалжуудыг энэ бүлэгт товч танилцуулна.

#### ***Монгол Улсын бодлого, эрх зүйн баримт бичигт багшийн цогц чадамжийн талаар тусгасан заалтууд***

Монгол Улсын хувьд 2018 онд батлагдсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Багшийн мэдлэг, боловсрол, хандлага, ёс зүй, эрүүл мэнд, нийгмийн баталгаа, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй байна” гэж заасан байна. Мөн Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын Зорилт 2.1.-д “Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн боловсролын зорилгын хүрээнд “Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана” гэжээ. Энэхүү зорилгод хүрэхийн тулд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд:

- “2.1.34. Багшийн стандартыг *мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, мэдээлэл, харилцаа, холбооны технологийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар* ялган тодорхойлж, *багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана*”,
- “2.1.44. Багш нарын *мэдээлэл, харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, цахим, зайн сургалт хөтлөх, англи хэлний чадварыг дээшлүүлэх* ..... сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, сургалт явуулдаг бүх төрлийн байгууллагын оролцоог хангана” гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтуудыг тавьжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 сарын 29-ний өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын багшийн ажлыг үнэлэхэд баримтлах шалгуур, үзүүлэлтийг баталсан байна. Үүнд:

1. Суралцагчид боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн
2. Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн
3. Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн
4. Сургуулийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, оруулсан хувь нэмэр гэсэн 4 шалгуур, эдгээрт холбогдох 13 үзүүлэлтийг баталсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт багшийг бэлтгэх, хөгжүүлэхдээ багшийн чадамжийг дараах байдлаар томъёолсон гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

- 1) мэдээлэл, харилцаа, холбооны технологийн мэдлэг, чадвар;
- 2) гадаад хэл, тэр дундаа англи хэлний чадвар;
- 3) Мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны мэдлэг, чадвар орж байна. Үүнээс гадна *багшийн хандлага, ёс зүй, мэргэжлийн хөгжил, олон нийттэй хамтран ажиллах, суралцагчид үзүүлэх дэмжлэгийг* чухалчилсан байна.

### Монгол Улсын 21-р зууны Монгол багшийн загвар

Зураг 3. 21-р зууны Монгол багш загвар



МУБИС-ийн “Багшийн загвар боловсруулах” ажлын хэсгээс боловсруулсан “Монгол багш загвар” нь академик чадамж, мэргэжлийн чадамж, суурь чадамж, эрхэмлэх зүйл гэсэн 4 үндсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд энэхүү загварын чадамж бүрийн элементийг харуулсан тайлбарыг хүснэгт 1-д харуулав.

Эх сурвалж: Ерөнхий боловсролын бодлогын зөвлөх багийн “Багшийн загвар боловсруулах” ажлын хэсгийн тайлан, х.19

Хүснэгт 1. Монгол багшийн загвар

<i>ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛ</i>	
Хүүхдэд ээлтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийг ойлгодог, хайрладаг</li> <li>• Суралцагчийн онцлог, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг</li> <li>• Хүүхэд бүрийг амжилттай сурч чадна гэдэгт итгэдэг</li> <li>• Хүүхэд бүрийн чадавхийг бүрэн дайчлахыг эрмэлздэг</li> <li>• Хүүхдийн хөгжил, төлөвшилд цогц ханддаг</li> </ul>
Ёс зүйтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Багшийн нэр хүнд ёс зүйг эрхэмлэдэг</li> <li>• Төрийн хууль, дүрэм, журмыг сахин мөрддөг</li> <li>• Зөв үлгэр дуурайлтай</li> <li>• Үндэсний ёс заншлаа дээдэлдэг</li> </ul>
Нийцтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжил нэгт нөхдөө дэмжиж, тусалдаг</li> <li>• Хамтран ажиллагсдын үүрэг, хувь нэмрийг үнэлдэг, ололт амжилтад нь баярладаг</li> <li>• Шинэчлэл, шинэ санааг соргог мэдэрдэг</li> <li>• Баг, нийтийн эрх ашгийг дээдэлдэг</li> <li>• Эцэг эх, хүүхдийн итгэлийг даадаг</li> </ul>
Хичээнгүй	<ul style="list-style-type: none"> <li>• Багшлах ажилдаа элэгтэй, чин сэтгэлээсээ ханддаг</li> <li>• Судлан шинжлэх ажилд сэтгэл, зүтгэлтэй</li> <li>• Ажил хэрэгч, хариуцлагатай</li> <li>• Тууштай</li> </ul>
<i>СУУРЬ ЧАДАМЖ</i>	
Хувийн	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний ёс заншлын дэвшилт уламжлалаа сахих, хөгжүүлэх</li> <li>• Эх хэлээрээ яруу, утга төгс ярих, бичих</li> <li>• Түгээмэл гадаад хэл дээр унших, ойлгох</li> <li>• МХТ-ийг хэрэглэх, харилцах</li> <li>• Өөрийгөө таних, илэрхийлэх, хянах, залах, хөгжүүлэх</li> <li>• Бүтээлчээр сэтгэх</li> <li>• Бие даан ажиллах</li> </ul>
Нийгмийн	<ul style="list-style-type: none"> <li>• Идэвхтэй сонсох, хэлэлцэх</li> <li>• Бусдыг ойлгох</li> <li>• Нийгмийн амьдралд оролцох</li> <li>• Зохицон өөрчлөгдөх</li> <li>• Манлайлах, зохион байгуулах</li> </ul>
<i>МЭРГЭЖЛИЙН ЧАДАМЖ</i>	
Сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлал, дидактикийн нэгдмэл мэдлэг, ойлголт	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний хөгжил, төлөвшил, нийгэмшихүйн зүй тогтол</li> <li>• Хүүхэд-суралцагчийн хөгжил, төлөвшил, түүнд цогц хандах нь</li> <li>• Багш мэргэжилтэн (өөрийн тухай)</li> <li>• Боловсролын онол, үзэл баримтлал, бодлого, тэдгээрийн хэрэгжилт</li> <li>• Боловсролын эрх зүйн орчин</li> <li>• Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр</li> <li>• Суралцахуй (Суралцагчдын хувийн ялгаа, хэрэгцээ, сонирхол, суралцах хэв шинж; суралцахуйн зонхилох онол, үзэл баримтлал; суралцахуйд үзүүлэх нийгэм, соёлын нөлөө ба өмнөх туршлага; суралцагчийн өөртөө итгэх итгэл, сурах сэдэл; суралцах чадамж)</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Сургахуй/багшлахуй (суралцах тав тухтай орчин, түүнийг хэрхэн бүрдүүлэх тухай; тухайн хичээлээр эзэмших мэдлэгийг хэрхэн бүтээх, бүтэцлэх, бусад хичээлийн агуулгатай холбох, амьдралд хэрэглэх тухай; тухайн агуулгыг судлахад тулгардаг нийтлэг ташаа ойлголт, гаргадаг түгээмэл алдаа, тэдгээрийг залруулах арга зам; сургалтын төлөвлөлт, сургалтын аргууд, сонголт, тэдгээрийн хэрэглээ; суралцагчдын бүлэг, анги хамт олонтой ажиллах нь)</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээ (сургалтын явцын, үр дүнгийн; багшийн өөрийн үйл ажиллагааны)</li> <li>• Сургууль (Сургууль - хүүхэд бүрийн хөгжин төлөвших, суралцаж, амьдрах орчин)</li> </ul>
Мэргэжлийн ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Судлах, шинжлэх</li> <li>• Суралцах (төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, шүүмжлэлтэйгээр үнэлэх, сонгох, шинэ санаа гаргахад бүтээлчээр ашиглах; оюуны үйлийн ерөнхий ба тусгай арга барилыг хэрэглэх )</li> <li>• Суралцах орчин бүрдүүлэх (суралцагчдын хамтарч ажиллах, харилцан суралцах үйлийг дэмжсэн бодит болон цахим орчин)</li> <li>• Тухайн хичээлээр эзэмших мэдлэгийг бүтэцлэх, бусад хичээлийн агуулгатай холбох</li> <li>• Хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх,</li> <li>• зохион байгуулах, баримт нотолгоонд тулгуурлан үнэлэх, үр дүнг танилцуулах</li> <li>• Суралцах үйл ажиллагааг чиглүүлэх, зөвлөх</li> <li>• Тухайн агуулгыг судлахад тулгардаг нийтлэг ташаа ойлголт, гаргадаг түгээмэл алдааг таних, илрүүлэх, тэдгээрийг залруулах</li> <li>• Шинийг сэдэх, хуваалцах, бүтээх</li> <li>• Харилцах (амаар, бичгээр)</li> <li>• Хамтарч ажиллах (суралцагчтай ганцаарчлан</li> <li>• болон суралцагчдын бүлэг, анги хамт олонтой)</li> <li>• Мэргэжлийн хамт олны үйл ажиллагаанд оролцох, манлайлах</li> </ul>
<i>АКАДЕМИК ЧАДАМЖ</i>	
Академик мэдлэг	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн шинжлэх ухааны тулгуур онол, үзэл баримтлал, зарчим, хууль, зүй тогтол</li> <li>• Үндсэн ухагдахуун, нэр томъёо, шинжлэх ухааны хэл, шинжлэн судлах арга, хэрэгсэл</li> <li>• Судлагдахууны үндсэн ухагдахуун, сэдвүүдийг суралцагч хэрхэн ойлгодог туршлага (нийтлэг дүр төрх, нийтлэг жишээ)</li> <li>• Монгол хэл, түүх, соёл, сэтгэлгээний уламжлал</li> </ul>
Академик чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэшиж буй шинжлэх ухааны хэлийг хэрэглэх, харилцах;</li> <li>• Тухайн шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглэх;</li> <li>• Судлах, шинжлэх;</li> <li>• Даяаршил, дангааршил, тогтвортой хөгжил, эрүүл мэндийн боловсрол, иргэний боловсролын асуудлыг үндсэн хичээлийн агуулгатай холбох, интеграцчилах;</li> <li>• Салбар дундын шинжлэх ухааны ололт амжилтаас суралцах, хэрэглэх;</li> </ul>

Эх сурвалж: Ерөнхий боловсролын бодлогын зөвлөх багийн “Багшийн загвар боловсруулах” ажлын хэсгийн тайлан, (хуудсд. 20-22)

## *Монгол Улсын багшийн бусад загвар*

21-р зууны Монгол багшийн загвараас гадна Монгол Улсын эрдэмтэн судлаачдын хувьд “Эрдэм чанартай багшийн динамик загвар”, “Бага ангийн багшийн загвар” зэрэг багшийн загваруудтай холбогдох судалгаануудыг<sup>1</sup> БШУЯ болон ЭЗХҮБЧХСТ-с хамтран зохион байгуулсан “Монгол багшийн загвар ба багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэлийн хэлэлцүүлэг”-т хэлэлцүүлсэн байна.

“Эрдэм чанартай багшийн динамик загвар”-ын хувьд багш нь багш чанар, эрдэм чанар, хүн чанартай байх бөгөөд багш чанар нь мэдлэг, эрдэм, чадвараас бүрдэх бол эрдэм чанар нь журамлах, үйл, дагах зэргээс бүрдсэн байна. Харин хүн чанар нь үнэт зүйл, хүний мөс, төлөвлөөс бүрдэхээр загварчилжээ.

“Бага ангийн багшийн загвар” нь төвдөө насан туршдаа тасралтгүй хөгжих чадвартай багшийг тавьж, оюунлаг нүнжигтэй, энэрэнгүй жудагтай, хөгжүүлэгч бүтээгч гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүнтэй юм.

*Оюунлаг нүнжигтэй гэсэн бүрэлдэхүүнд:*

- Багшлахуйн онол, арга зүйн мэдлэг
- Хүний хөгжил болон хүүхэд судлалын мэдлэг
- Хууль, эрх зүйн мэдлэг
- Гадаад хэлний мэдлэг
- Түүх, уламжлал ёс заншлаа мэддэг байх

*Энэрэнгүй жудагтай гэсэн бүрэлдэхүүнд:*

- Багш мэргэжилдээ дуртай байх
- Хүүхдэд хайртай байх
- Өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй байх
- Байгальд ээлтэй байх
- Шударга, зарчимч, ёс зүйтэй бах

*Хөгжүүлэгч бүтээгч гэсэн бүрэлдэхүүнд:*

- Харилцааны чадвар
- МХТ-ийг ашиглах чадвар
- Багаар ажиллах чадвар
- Судалгаа хийх чадвар
- Дасан зохицох чадвар зэргээс тус тус бүрдэхээр загварчилсан байна.

---

<sup>1</sup> 2022 оны 10 сарын 22-ны өдөр БШУЯ болон ЭЗХҮБЧХСТ-с хамтран зохион байгуулсан “Монгол багшийн загвар ба багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэлийн хэлэлцүүлэг”-т хэлэлцүүлсэн танилцуулгаас эх сурвалжийг авав.

## 1.4. Багшийн цогц чадамжийн хүрээ: Олон улсын туршлага

### 1.4.1. Олон улсын хэмжээний багшийн цогц чадамжийн хүрээ

Өмнөх хэсэгт дурдсан давтамж өндөртэй айнуудыг судалгааны аргачлалын дагуу IV үе шатанд илүү задлан ангилах шаардлагатай тул сонгогдсон эх сурвалжуудаас дараах шалгуурыг үндэслэн дараагийн шатны шинжилгээнд баримт бичгүүдийг сонгов.

- 1) Багшийн цогц чадамжийн бүрэлдэхүүнийг илүү нарийвчлан задалж ангилсан байх;
- 2) Олон улсын хэмжээний буюу олон улс орныг хамарсан багшийн цогц чадамжийн хүрээ байх.

Дээрх шалгуур үндэслэлийн дагуу Зүүн өмнөд Азийн багшийн цогц чадамжийн хүрээ, Европын Холбооноос гаргасан Багшийн цогц чадамжууд, Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээ болон Багшийн мэргэжлийн стандартын дэлхий дахины хүрээ гэсэн 4 баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийлээ. Эхний хэсэгт хүрээ бүрийн товч танилцуулга, цогц чадамжийн бүрэлдэхүүн зэргийг тус тус танилцуулж, дараагаар нь харьцуулсан шинжилгээний үр дүнг өгүүлэх болно.

### Зүүн Өмнөд Азийн багшийн цогц чадамжийн хүрээ

Бруней, Вьетнам, Зүүн Тимор, Индонез, Камбож, Лаос, Малайз, Мьянмар, Сингапур, Филиппин, Тайланд зэрэг 11 улсын хувьд багшийн боловсролын асуудлыг сэргээн сайжруулах 2015 оноос 2035 он хүртэлх хугацааны тэргүүлэх зорилт тавьсан бөгөөд эдгээр улс орнууд хамтран 21 дүгээр зууны Зүүн Өмнөд Азийн улс орнуудын багшийн цогц чадамжийн хүрээг хамтран 2017 онд боловсруулсан байна.

Зураг 4. Зүүн Өмнөд Азийн Багшийн цогц чадамжийн хүрээ



Эх сурвалж: Teachers Council of Thailand, 2018, x.7

Зүүн Өмнөд Азийн багшийн цогц чадамжийн хүрээ нь 4 ай бүхий 12 ерөнхий цогц чадамж, 31 дэд чадамжаас бүрдсэн бөгөөд багш өөрийн үнэлгээ хийж, цаашдын хөгжлийн

хэрэгцээгээ тодорхойлох аргачлал болон чадамжуудыг хэмжих 136 амжилтын тодорхойлогчдыг гаргасан байна. Зураг 3 нь Зүүн Өмнөд Азийн Багшийн цогц чадамжийн хүрээг тойргоор зурагласан зураглал бөгөөд цөмд нь аз жаргалтай суралцагч байхаар томьёолжээ. Хүснэгт 3-т энэхүү хүрээний бүрдлүүдийг нарийвчлан харуулав.

Хүснэгт 2. . Зүүн Өмнөд Азийн Багшийн цогц чадамжийн хүрээ

№	Ай	Ерөнхий цогц чадамж	Дэд чадамж
1	Юу зааж байгаагаа мэддэг, ойлгодог байх	1.1. Өөрийн заадаг хичээлийн чиглэлээр мэдлэгээ тэлж, гүнзгийрүүлдэг.	1.1.1. Хичээлийнхээ агуулгыг бүрэн эзэмшсэн. 1.1.2. Судалгаанд суурилсан мэдлэгийг ашигладаг.
		1.2. Боловсролын чиг хандлага, бодлого, хөтөлбөрийг ойлгодог.	1.2.1.Боловсролын шинэ чиг хандлагын талаар мэдээлэлтэй байдаг. 1.2.2.Боловсролын талаарх бодлогыг болон тэдгээр бодлого нь өөрийн хичээл сургалтад хэрхэн нөлөөлөхийг судалдаг. 1.2.3.Сургалтын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэхээ ойлгодог.
		1.3. Нутаг орны, үндэсний, бүс нутгийн болон олон улсын сүүлийн үеийн хөгжлийн талаар байнга мэдээлэлтэй байдаг.	1.3.1.Боловсролын хүрээн дэх шинэ өөрчлөлтүүдийг тусган хэрэгжүүлдэг.
2	Сурагчдынхаа суралцахуйд туслах	2.1. Сурагчдаа мэддэг.	2.1.1. Сурагчдаа амжилттай сурахад нь дэмжлэг үзүүлэх үүднээс тэдний хэрэгцээ, давуу талыг илрүүлдэг. 2.1.2. Сурагчид маань яавал амжилттай суралцаж чаддагийг ойлгодог. 2.1.3. Сурагчдын онцлогийг чухалчилдаг.
		2.2. Сургалтын хамгийн үр дүнтэй аргыг хэрэглэдэг	2.2.1. Сурагчдад ойлгогдохоор тодорхой, үр дүнтэй байхаар хичээлээ төлөвлөдөг. 2.2.2. Сургалтын оновчтой арга зүйг сонгодог байна. 2.2.3. Эерэг, сурагчдаа анхаарсан орчин бий болгодог.
		2.3. Сурагчид хэрхэн суралцаж байгааг үнэлж, тайлбар өгдөг.	2.3.1. Үнэлгээний үйл явц, арга хэрэгслийг боловсруулдаг. 2.3.2. Сурагчдынхаа ахицыг хянаж, шаардлагатай дэмжлэгийг үзүүлдэг. 2.3.3.Сургалтаа сайжруулахын тулд үнэлгээний дүнг ашигладаг.
3	Олон нийтийн ажилд оролцох	3.1. Эцэг эх асран хамгаалагчидтай хамтардаг.	3.1.1. Дэмжих сүлжээг бий болгодог. 3.1.2. Таатай/халуун дулаан/ дотно уур амьсгал бүрдүүлдэг. 3.1.3. Түншлэлийг тогтвортой байлгадаг.
		3.2. Сурагчдыг илүү амжилттай суралцуулахын тулд иргэдийг хамруулдаг.	3.2.1. Эцэг эх, асран хамгаалагчдыг хүүхдийн сурах үйл явцад оролцуулдаг. 3.2.2. Орон нутгийн нөхцөл байдал, ардын мэргэн ухаан, өв уламжлал, мэдлэгийг ашиглан суралцахуйн үйл ажиллагааг боловсруулна.
		3.3. Бусдыг хүндлэх, олон төрлийн хүмүүсийг хамруулахыг дэмждэг.	3.3.1. Хүмүүс ялгаатай байдгийг хүлээн зөвшөөрнө. 3.3.2.Ангид бүгдийг тэгш хамруулж, хүндэтгэлтэй хандахыг хэвшүүлнэ.



4	Өдөр бүр илүү сайн багш болох	4.1. Өөрийгөө болон бусдыг мэддэг.	4.1.1. Өөрийгөө илүү ихээр танин мэдсэнээр илүү хөгждөг. 4.1.2. Өөрийн сэтгэл хөдлөл, эрүүл мэндийн төлөө илүү ухамсартай, хариуцлагатай байна. 4.1.3. Өөрийн харилцах чадварыг халамж, хүндэтгэлтэйгээр хөгжүүлнэ.
		4.2. Ажилдаа болон амьдралдаа хүний сайн сайхныг эрхэмлэдэг.	4.2.1. Сайхан сэтгэлтэй, энэрэнгүй байна. 4.2.2. Өөрөө үлгэр жишээ байж сурагчид, хамт олондоо урам зориг хайрлана. 4.2.3. Сурагчдынхаа үүнийг хийнэ, чадна гэдэгтээ итгэх итгэлийг нь нэмэгдүүлнэ.
		4.3. Багшлах ур чадварыг сайн эзэмшсэн.	4.3.1. Өөрийн багшлах хүсэл тэмүүллийг хадгална. 4.3.2. Хувийнхаа болон мэргэжлийнхээ өсөлт хөгжилд хариуцлага хүлээнэ. 4.3.3. Хамгийн сайн үлгэр жишээг үзүүлж бусад багш нартаа урам зориг өгнө.

Тайлбар: Эх сурвалжаас судалгааны баг орчуулав.

### **Европын Холбооноос гаргасан Багшийн цогц чадамжууд**

Европын Холбооноос 2012 онд “Боловсролыг дахин эргэцүүлэх нь” илтгэлд дурдсанаар боловсролын шинэчлэлийн нэг чухал зүйл нь өндөр бүтээмжтэй, чадварлаг хүний нөөцөөр боловсролын салбарыг хангах явдал юм. Тиймээс 2013 онд Европын Холбооны гишүүн улсууд багш бэлтгэх хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлох, багшийн мэргэжилд элсүүлэх, түүнийг ажилд авах шалгуурыг тогтоох, багшийн хөгжих хэрэгцээг тодорхойлох, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг зохион байгуулахын тулд багшийн цогц чадамжийн хүрээг гаргах шаардлагатай болсон байна. Улмаар Европын Холбооны гишүүн 26 улс орны судлаач болон оролцогчид боловсролын бодлого, холбогдох судалгаануудад шинжилгээ хийж, гишүүн улсууд өөрийн орны онцлогт тохируулан багшийн цогц чадамжийн хүрээг боловсруулахад удирдлага болгох 3 бүрэлдэхүүнтэй багшийн цогц чадамжийг тодорхойлсон.

Хүснэгт 3. 21-р зууны Багшийн цогц чадамжууд

№	Бүрэлдэхүүн	Чадамж
1	Мэдлэг ба ойлголт	1. Судлагдахууны мэдлэг 2. Заах арга зүйн агуулгын мэдлэг 3. Заах арга зүйн мэдлэг (багшлахуйн, суралцахуйн үйл явцын мэдлэг) 4. Сургалтын хөтөлбөрийн мэдлэг (судлагдахууны сургалтын хөтөлбөрийн мэдлэг ....) 5. Боловсролын шинжлэх ухаан .... (соёл хоорондын, түүхийн, философийн, сэтгэл судлалын, социологийн мэдлэг) 6. Боловсролын бодлогын үндэсний, институцийн, байгууллагын аспект 7. Тэгш хамруулалтын асуудлууд 8. Технологийн үр дүнтэй хэргэлээ 9. Хөгжлийн сэтгэл судлал 10. Бүлгийн үйл явц ба динамик, суралцахуйн онол, мотивацийн асуудлууд 11. Үнэлгээний явц, арга
2	Ур чадвар	1. Багшлах үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохион байгуулах 2. Сургалтын хэрэглэгдэхүүн болон технологи ашиглах 3. Суралцагч болон бүлгийг удирдах 4. Багшлахуйн, суралцахуйн зорилт, үйл явцыг үнэлэх, мониторинг хийх, тохируулах

		5. Багшлахуйн, суралцахуйн хөгжил, мэргэжлийн шийдвэр гаргахын тулд дата, нотолгоо (сургалтын үр дүн, хөндлөнгийн үнэлгээний үр дүн) цуглуулах, шинжлэх, тайлагнах 6. Практикт ашиглахдаа судалгаанд суурилсан мэдлэг бий болгох, хөгжүүлэх, ашиглах 7. Хамт олон, эцэг эх, нийгмийн үйлчилгээтэй хамтран ажиллах 8. Хэлэлцээрийн ур чадварууд (боловсролын хэд хэдэн оролцогчтой хийх нийгэм улс төрийн харилцаа) 9. Суралцахдаа бие даан ажиллах, мэргэжлийн бүлгүүдтэйгээ харилцах ур чадварууд 10. Эргэцүүлэх, мета танин мэдэхүйн, хүн хоорондын ур чадварууд 11. Дасан зохицох .....
3	Зан чанар: итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлс, оролцоо	1. Эпистемологи 2. Багшлах ур чадвар 3. Дамжуулах боломжтой ур чадварууд 4. Өөрчлөгдөх, уян хатан байх, тасралтгүй суралцах болон мэргэжлийн хөгжих (судалгаа хийх) чанар 5. Бүх суралцагчаа суралцахад нь урамшуулах оролцоо 6. Суралцагчийнхаа Европын иргэний хувьд ардчилсан хандлага, туршлагыг урамшуулах чанар 7. Өөрийн багшлахуйдаа шүүмжлэлтэй хандах хандлага (хэлэлцэх, асуух, ухаж олох) 8. Багаар, хамтран ажиллах, танилын сүлжээтэй болох чанар 9. Өөртөө итгэх итгэл

Тайлбар: Эх сурвалжаас орчуулав.

### Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээ

ТКСОМ төслийн баг 2018 онд бага боловсролын багшийн дэлхийн дахины үндсэн цогц чадамжийн хүрээг боловсруулсан. Энэхүү төслийн зорилго нь Хятадын бага боловсролд чадамжид суурилсан багш бэлтгэх, багшийн мэргэжлийг дээшлүүлэх хандлагыг бий болгож хэрэгжүүлэхэд оршиж байсан. Төслийн багт Испани улсын Барселонагийн Их Сургууль, Португал улсын Коимбрагийн Их Сургууль, Английн Ноттингем Трентийн Их Сургууль, БНХАУ-ын Бээжингийн Багшийн Их Сургууль, Баруун хойд болон Баруун өмнөд Багшийн Их Сургуулийн багш, эрдэмтэд хамтран ажиллажээ. Төслийн багийн тодорхойлсноор “цогц чадамж” гэдэгт багш нь мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгардаг асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд тухайн нөхцөл байдалд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлага, үнэт зүйлсийг зохих ёсоор, хурдан нэгтгэх, дайчлах чадамжийг ойлгоно гэжээ. Цаашилбал, Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээ нь тусгай болон дэд хөтөлбөрийн чадамж гэсэн 2 үндсэн чадамжаас бүрдэнэ. Тусгай чадамжид багш мэргэжлийн онцлог чадамжүүдыг бүлэглэсэн бол дэд хөтөлбөрийн чадамжид хувь хүний болоод бүх мэргэжлийн хүнд хамаарах нийтлэг чадамжуудыг нэгтгэжээ.

Хүснэгт 4. Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээний бүрдэл

№	Бүрэлдэхүүн	Чадамж
1	Төлөвлөлт	Багшлахуй-суралцахуйн үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, шинэчлэх, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүний хэрэглээг үнэлэх чадамж
2	Ангийн менежмент	Ангиа зохион байгуулах, сургалтыг дэмжих олон төрлийн стратегийг ашиглах чадамж
3	Үнэлгээ	Суралцахуйг нотлох, суралцахуй болон заах арга зүйг сайжруулах зорилгоор үнэлгээ хийх чадамж

4	Тэгш хамруулалт	Бүх суралцагчдыг тэгш хамруулах боломжийг бүрдүүлэхийн тулд олон талт байдал, тэгш байдалд анхаарлаа хандуулах чадамж
5	Олон нийтийн үйл ажиллагаа	Эцэг эх (гэр бүл)-тэй үр нөлөөтэй харилцаа тогтоох, хамт олон болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах чадамж
6	Өөрийгөө эргэцүүлэх ба мэргэжлийн хөгжил	Өөрийн багшлах туршлага, мэргэжлийн тасралтгүй хөгжил, суралцахдаа эргэцүүлэл хийх чадамж
7	Мэдээлэл, харилцаа холбооны технологи	Багшлах, бусадтай харилцах, мэдлэгээ хуваалцахад зохих Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ) болон нийгмийн сүлжээг ашиглах дижитал чадамж
8	Харилцаа	Суралцагч, түүний гэр бүл, хамт олон, удирдлагын баг болон бусад боловсролын нийгэмлэгүүдтэй харилцах чадамж
9	Ёс зүйн үүрэг хариуцлага	Суралцагчийн суралцахуй, багшлахуйн чанараа сайжруулахтай холбоотой ёс суртахуунтай байдал болон мэргэжлийн хариуцлагатай холбоотой чадамж

Тайлбар: Эх сурвалжаас орчуулав.

### **Багшийн мэргэжлийн стандартын дэлхий дахины хүрээ**

2019 онд ЮНЕСКО болон Боловсрол Олон улсын нэгдсэн холбоо (Education International)-оос хамтран Тогтвортой хөгжлийн зорилго 4 “Чанартай боловсрол”-ын хүрээнд бүх нийтэд тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээг дэмжихийн тулд дэлхийн хэмжээний багшийн мэргэжлийн нийтлэг чухал стандартуудын хүрээг тогтоож, улс орнуудын бодлого боловсруулагчид улс орныхоо багшийн мэргэжлийн стандартыг боловсруулахдаа удирдлага болгох баримт бичгийг боловсруулж гаргасан. Энэхүү хүрээ нь 12 зарчимд тулгуурласан 3 айгаас бүрдсэн 10 стандартаас бүрддэг байна.

Хүснэгт 5. Мэргэжлийн стандартын дэлхийн дахины хүрээний бүрдэл

№	Ай	Стандарт
1	Багшийн мэдлэг ба ойлголт	<i>Дараахыг мэдэж, ойлгоход багшийг дадлагажуулах</i>
		1 Яаж сурагчид сурдаг, мөн тодорхой сургалт, нийгэм, хөгжлийн хэрэгцээг
		2 Заах хичээлийнхээ агуулга, арга зүйг
		3 Сурагчдын үнэлгээг багтаасан багшлахуйд ашиглагдах судалгааны арга зүйг
2	Багшлах туршлага	<i>Дараахыг багшийн туршлага тууштай харуулж байх</i>
		4 Суралцахуйн зорилгод хүрэхийн тулд төлөвлөх, бэлтгэл хангах
		5 Зааж буй хичээлийн агуулгын мөн чанар, суралцагчийн суралцах, дэмжих, хөгжүүлэх хэрэгцээг хоёуланг нь тусгаж, уялдуулсан багшлахуй
		6 Сурагчдын үйл ажиллагааг зохион байгуулах, чиглүүлэх
7 Сурагчдыг үнэлэх, үнэлгээндээ дүн шинжилгээ хийх		
3	Багшийн харилцаа	<i>Дараах багшийн мэргэжлийн харилцаанд идэвхтэй оролцох</i>
		8 Хамт олон болон сурагчдынхаа суралцахуй, хөгжлийг дэмжихийн тулд хамтран ажиллах
		9 Эцэг эх, асран хамгаалагчид, олон нийт, иргэдийн бүлгийн гишүүдтэй харилцах харилцаа
		10 Мэргэжлийн тасралтгүй хөгжил

Тайлбар: Эх сурвалжаас орчуулав.

Багшийн цогц чадамжийн талаарх эдгээр эх сурвалжуудаас гадна багш ямар суралцагчийг хөгжүүлэх гэж байна, бусад мэргэжлийн ямар чадамжууд байдаг талаар судалгааны баг шинжилсэн бөгөөд шинжилгээний үр дүнг багшийн цогц чадамжийн хүрээтэй харьцуулан дүгнэсэн болно. Түүнчлэн ЮНЕСКО-оос гаргасан багшийн мэдээлэл харилцаа, технологийн чадамжийн хүрээний талаар товч дурдав.

### **ЭЗХАХБ-ын Сургалтын луужин 2030**

ЭЗХАХБ-ын сургалтын луужин 2030 нь боловсролын ирээдүйн талаарх алсын харааг тодорхойлсон хүрээ юм. Энэ хүрээ нь улс орнуудын хүсэж буй ирээдүй болох хувь хүн болоод хамтын сайн сайхан байдалд хүрэхэд чиглүүлэх бөгөөд луужин нь суралцагч танил бус нөхцөл байдалд өөрийгөө бие даан жолоодож суралцах гэсэн санааг илэрхийлж, зүйрлэдэг байна. Мөн суралцагчийн хувьд ганцаараа бус, түүнийг хүрээлж буй үеийнхэн, багш, эцэг эх, олон нийт тэдэнтэй хамт байдаг, тэдний дунд сурч, хөгжиж туршлагажна гэсэн санааг агуулдаг.

Зураг 5. ЭЗХАХБ Сургалтын луужин 2030



Эх сурвалж: <https://www.oecd.org/education/2030-project/teaching-and-learning/learning/>

Сургалтын луужин 2030 хүрээнд илэрхийлснээр “суралцагч олж авсан мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагаа үр нөлөөтэй ашиглах байдлаар сайн сайхан байдалд хүрнэ” гэжээ. Мэдлэг гэдэгт сахилга бат, салбар хоорондын, танин мэдэхүйн болон процедурын гэсэн 4 төрлийн мэдлэгийг онцолсон бол ур чадваруудад танин мэдэхүйн болон мета танин мэдэхүйн, нийгмийн болон сэтгэл хөдлөлийн, туршлага болон бие бялдрын ур чадваруудыг дурджээ. Харин үнэт зүйлс, хандлага гэдгийг хувь хүн, нийгэм, хүрээлэн буй орчны сайн сайхны

төлөөх тухайн хүний сонголт, дүгнэлт, зан үйл, үйлдэлд нөлөөлдөг зарчим, итгэл үнэмшлийг хэлнэ гэжээ.

Суралцагч цаашид суралцахад, мөн хувьсан өөрчлөгдөх чадамжаа хөгжүүлэхэд нь суурь үндэс болох мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- бичиг үсэг, тоо бодох чадварыг багтаасан танин мэдэхүйн үндэс, түүнд суурилсан дижитал болон өгөгдлийн бичиг үсгийн чадварыг бий болгох боломжтой
- бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдал бүхий эрүүл мэндийн үндэс
- ёс суртахуун, ёс зүйг багтаасан нийгэм, сэтгэл хөдлөлийн үндэс.

Сургалтын луужин 2030-д харуулсан хувьсан өөрчлөгдөх чадамжуудад ЭЗХАХБ-аас шинэ үнэт зүйлийг бий болгох, хурцадмал байдал, бэрхшээлийг эвлэрүүлэх, хариуцлага хүлээх гэсэн 3 үндсэн чадамжуудыг онцолжээ.

### **Мэргэжлийн чадамжийн рубрик**

АНУ-ын Америкийн коллежийн боловсон хүчний холбоо болон Оюутны боловсон хүчний удирдах ажилтны үндэсний холбоо хамтран “Мэргэжлийн чадамжийн рубрик”-ийг 2016 онд гаргажээ. “Мэргэжлийн чадамжийн рубрик”-ийг мэргэжилтнүүд өөрсдийн мэдлэг, чадвар, зан байдлаа үнэлэхэд ашиглах боломжтой бөгөөд туршлагаасаа хамаараад суурь, дунд, ахисан гэсэн 3 түвшинтэй. Энэхүү рубрикийг ямарваа мэргэжилд бэлтгэх, мэргэжлийн хөгжил, ажил эрхлэлт болон мэргэжлийн холбоо зэрэг төрөл бүрийн салбарт ашиглах боломжтой болохыг зохиогчид онцолжээ.

#### *Хүснэгт 6. Мэргэжлийн чадамжийн рубрик*

№	Бүрэлдэхүүн	Чадамжууд
1	Зөвлөх, дэмжлэг үзүүлэх	Хүн хоорондын харилцааны ур чадвар
		Мэргэжлийн хөгжил
		Бүлгийн динамик
		Бусадтай хамтран ажиллах, түншлэх
		Зөрчилдөөн ба хямралын нөхцөл байдлыг зохицуулах
2	Үнэлгээ, судалгаа	Нэр томъёо болон үзэл санаа
		Үнэт зүйлс/ёс зүй/улс төр
		Үнэлгээ, судалгааг дизайнчлах
		Судалгааны арга зүй, өгөгдөл цуглуулах, өгөгдөлд боловсруулалт хийх
		Үр дүнг тайлбарлах, тайлагнах, хэрэглэх
3	Хууль, бодлого, засаглал	Хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоо
		Засаглал
		Бодлогын ёс суртахуунтай, хүртээмжтэй хэрэглээ
		Иргэний оролцоо
4	Манлайлал	Манлайллын үндэс, онолын зарчим
		Өөрийгөө танин мэдэхүй, эргэцүүлэхүй
		Багаар ажиллах, хүн хоорондын харилцааны чадварууд
		Өөрчлөлтийн менежмент ба инновац
		Үнэлгээ, нөлөөллийн ажил, танилын сүлжээ тогтоох (networking)
5	Байгууллага болон хүний нөөц	Чадварын хөгжүүлэлт
		Ажилд авах, ажиллуулах
		Удирдлага, харилцаа холбоо, зөрчилдөөнийг шийдвэрлэх
		Эрсдэлийн удирдлага


		Нөөцийн удирдлага, өөриймсөг хандах, тогтвортой байдал
		Технологи
		Эрүүл мэнд, эрүүл амьдрал
		Ёс зүйн дүрэм, мэргэжлийн стандарт
6	Хувь хүний болон ёс суртахууны үндэс	Өөрийгөө үнэлэхүй, эргэцүүлэхүй Өөрийгөө ойлгох, эрх мэдлийн тогтолцоог залуурдах Шүүмжлэлт үнэлгээ, бие даан суралцах
7	Нийгмийн шударга, тэгш байдал	Нийгмийн харилцаанд оролцох - Шударга байдлын туршлага Байгууллагын тогтолцооны нөлөөлөл Онолын ойлголт
8	Суралцагчийн суралцахуй ба хөгжил	Дизайн ба хэрэглээ Үнэлгээ ба интеграци Техник хэрэгсэл болон програм хангамжууд
9	Технологи	Өгөгдлийн ашиглалт ба дагаж мөрдөх Дижитал үнэмлэх ба иргэний харьяалал Онлайн суралцах орчин
10	Үнэт зүйлс, философи, түүх	Түүхэн үндэс Онолын үндэс Нийгэм/соёлын нөхцөл байдал Мэргэжлийн үйлчилгээ Сургуулийн орчин ба иргэний оролцоо

Эх сурвалж: (АСРА/NASPA, 2016)

### ЭЗХАХБ-ын чадамжийн хүрээ

ЭЗХАХБ-аас суралц, гүйцэтгэ, амжилт гарга гэсэн уриатай байгууллагын дотоодын ажилтан, мэргэжилтнүүдийн чадамжийн хүрээг 2014 онд боловсруулж гаргажээ. Тухайн баримт бичигт мэргэжилтнүүдийг гүйцэтгэх удирдлага, бодлогын судалгаа, шинжилгээ болон зөвлөгөө, байгууллагын менежмент, удирдлага гэсэн 3 бүлэгт хувааж авч үзсэн ба эдгээр бүлгийн мэргэжилтний хувьд нийтлэг байх цогц чадамжийн хүрээг ЭЗХАХБ-аас тодорхойлжээ. Энэ хүрээ нь амжилтын үр дүн (түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой), ирээдүйнхээ төлөөх төлөвлөгөө (стратегий), харилцаа тогтоох (хүн хоорондын) гэсэн 3 айтай, 15 чадамжаас бүрдсэн байна.

Зураг 6. ЭЗХАХБ гол цогц чадамжууд



Эх сурвалж: (ЭЗХАХБ, 2014, р. 3)

Амжилтын үр дүн (түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой) айд дүн шинжилгээ хийх сэтгэлгээ, амжилт руу тэмүүлэх, төслийг бэлтгэх, ноороглох ур чадварууд, уян хатан сэтгэлгээ, нөөцийн удирдлага, багаар ажиллах болон багаа манлайлах чадамжууд; ирээдүйнхээ төлөөх төлөвлөгөө (стратегий) айд авьяасаа хөгжүүлэх, зохион байгуулалтын уялдаа холбоо, стратегийн сүлжээ, стратегийн

сэтгэлгээ гэсэн чадамжууд; харилцаа тогтоох (хүн хоорондын) айд үйлчлүүлэгчид төвлөрсөн, дипломат мэдрэмж, бусдад нөлөөлөх, хэлэлцээ хийх, зохион байгуулалтын мэдлэг гэсэн чадамжууд тус тус ордог байна.

### **ЮНЕСКО: Багшийн мэдээлэл харилцаа, технологийн чадамжийн хүрээ**

ЮНЕСКО-оос 2018 онд гаргасан “Багшийн мэдээлэл харилцаа технологийн чадамжийн хүрээ” нь 6 гол бүрэлдэхүүнтэй, 3 түвшин бүхий 18 чадамжаас бүрдсэн. Энэхүү хүрээ нь багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад ашиглахад зориулагдсан бөгөөд багш болон боловсролын салбарын бусад хүний нөөц мэдээлэл харилцаа, технологийг боловсролын үйл ажиллагаанд үр дүнтэй хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлэх 3 дахь хувилбар юм. Хүснэгт 7-д Багшийн мэдээлэл харилцаа, технологийн хүрээний бүрэлдэхүүнийг үзүүлэв.

*Хүснэгт 7. Багшийн мэдээлэл харилцаа, технологийн чадамжийн хүрээ*

Чадамжууд	Мэдлэг олж авах	Мэдлэгээ гүнзгийрүүлэх	Мэдлэг бүтээх
Боловсрол дахь МХТ-ийн ойлголт	Бодлогыг ойлгох	Бодлого хэрэгжүүлэлт	Бодлогыг шинэчлэгч
Сургалтын хөтөлбөр болон үнэлгээ	Суурь мэдлэг	Мэдлэгийн хэрэглээ	Мэдлэгийн нийгэмшүүлэх ур чадвар
Заах арга зүй	МХТ-иор сайжруулсан сургалт	Цогц асуудал шийдвэрлэлт	Хувийн менежмент
Дижитал ур чадварын хэрэглээ	Хэрэглээ	Шинэ зүйлсийг нэвтрүүлэх	Хувирган өөрчлөлт
Удирдлага, зохион байгуулалт	Стандарт анги танхим	Хамтын бүлэг	Сургалтын байгууллага
Багшийн мэргэжлийн сургалт	Дижитал бичиг үсгийн мэдлэг	Сүлжээ үүсгэх (networking)	Шинийг санаачлагч багш

*Эх сурвалж. (ЮНЕСКО, 2018)*

#### **1.4.2. Гадаадын зарим орны багшийн цогц чадамжийн хүрээ**

Олон улсын хэмжээний багшийн чадамжийн хүрээ, чадамжийн бусад хүрээнээс гадна Австрали, Сингапур, Хятад улсын жишээгээр багшийн цогц чадамжийн хүрээг энэ хэсэгт танилцуулж, харьцуулсан шинжилгээний үр дүнд ашиглах болно.

##### ***Австрали Улсын багшийн цогц чадамжийн хүрээ***

Баруун Австралийн Засгийн газрын Боловсрол, сургалтын хэлтсээс 2004 онд багшийн цогц чадамжийн хүрээг боловсруулж гаргасан бөгөөд энэхүү хүрээ нь стандарт тогтоосон 3 түвшинтэй. Энэхүү баримт бичигт дурдсанаар багш карьерынхаа хугацаанд аль ч түвшнээс эхлэх боломжтой бөгөөд энэ хүрээ нь багшид аль чадамжаа хөгжүүлэх шаардлагатай байгаагаар тодорхойлох хөтөч болдог. Австрали улсын багшийн мэргэжлийн стандарт нь 1) мэргэжлийн мэдлэг, 2) мэргэжлийн туршлага 3) мэргэжлийн оролцоо гэсэн 3 айгаас бүрддэг (UNESCO, 2019).

Багшийн цогц чадамж нь багшийн стандарттай уялдаатай байх бөгөөд мэргэжлийн мэдлэгийн хувьд сургалтын хөтөлбөр, боловсролын бодлого, багш нарын ажилд хамаарах хууль тогтоомж, суралцагч, үнэлгээ, сургалтын хөтөлбөр боловсруулахтай холбоотой мэдлэг хамаардаг байна. Харин мэргэжлийн туршлагын хувьд багшийн гүйцэтгэдэг ажил,

үүрэгт үндэслэсэн 5 ай бүхий цогц чадамжийн хүрээнээс бүрддэг. Тухайлбал, суралцагчийн суралцахуйг чиглүүлэх, сурлагын үр дүнг үнэлэх, тайлагнах, мэргэжлийн сургалтад хамрагдах, сургалтын хөтөлбөрийн бодлого, бусад хөтөлбөрийн шинэчлэлд оролцох, сургуулийн нийгэмлэгийн хүрээнд хамтран ажиллах гэсэн 5 айтай. Эдгээрээс гадна хамтын ажиллагаа, оролцоотой байдал, үр нөлөөтэй харилцагч, ёс зүйтэй, шинийг санаачлагч, тэгш хамрагдалт, эерэг, эргэцүүлэгч гэсэн мэргэжлийн шинж чанарыг манлайлж байх шаардлагатай байна. Хүснэгт 8-д багш мэргэжлийн туршлагын хүрээнд ямар чадамжуудтай байхыг товч байдлаар нэгтгэн харуулав.

*Хүснэгт 8. Австрали Улсын багшийн цогц чадамжийн хүрээ*

Чадамжийн бүрэлдэхүүн	I түвшний багшийн чадамж	II түвшний багшийн чадамж	III түвшний багшийн чадамж
Суралцагчийн суралцахуйг чиглүүлэх	Суралцагчдыг зорилготой, зохистой суралцах туршлагад татан оролцуулах	Өргөн хүрээний багшлах стратегийг тууштай хэрэгжүүлэх замаар суралцагчийн ялгаатай сурах арга барил, хэрэгцээг хангах	Суралцагч, бүлэг эсвэл ангийн хэрэгцээнд нийцсэн үлгэр жишээ багшлах стратеги, арга техникийг өндөр мэдрэмжтэй, хүртээмжтэй байдлаар ашиглах
Сурлагын үр дүнг үнэлэх, тайлагнах	Суралцагчийн суралцахуйн үр дүнг хянах, үнэлэх, бүртгэх, тайлагнах	Суралцахуйн үр дүнтэй холбоотойгоор үнэлгээ, тайлангийн стратегийн цогц системийг ашиглах	Өндөр мэдрэмжтэй, хүртээмжтэй үлгэр жишээ үнэлгээ, тайлангийн стратегийг тууштай ашиглах
Мэргэжлийн сургалтад хамрагдах	Мэргэжлийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд мэргэжлийн туршлага, сургамжид шүүмжлэлтэй хандах	Бүлгийн хөгжилд хувь нэмэр оруулах	Өөрийгөө эргэцүүлэх, бүлгийн хөгжилд дэмжлэг болох олон төрлийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцох
Сургалтын хөтөлбөрийн бодлого, бусад хөтөлбөрийн шинэчлэлд оролцох	Сургалтын хөтөлбөр болон бусад хөтөлбөрийг боловсруулахад багаар хамтран оролцох	Сургалтын хөтөлбөр болон бусад хөтөлбөрийг боловсруулахад багтаа дэмжлэг үзүүлэх	Сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах зэрэг сургуулийн хөгжлийн үйл явцад гол үүрэг гүйцэтгэж, манлайлах
Сургуулийн хамт олонтой хамтран ажиллах	Суралцагч, хамт олон, эцэг эх болон асран хамгаалагчидтай түншлэлийн харилцаа тогтоох	Сургуулийн хамт олонтой хамтран баг болох, түншлэх замаар суралцагчийн суралцахуйд дэмждэг үзүүлэх	Сургуулийн хамт олонд багаар ажиллахад дэмжлэг үзүүлэх

*Эх сурвалж: Багшийн цогц чадамжийн хүрээ (2004) баримт бичгээс орчуулан эмхэтгэв.*

### **Сингапур Улсын шинэ төгсөгчийн чадамжийн хүрээ**

Сингапурын Боловсролын Үндэсний Институтээс 21-р зууны багшид байвал зохих Үнэт зүйлс<sup>3</sup>, Мэдлэг, Ур чадвар болон төгсөгч багшийн цогц чадамжийн хүрээг гаргасан. Хүснэгт 9-д үнэт зүйлс, мэдлэг, чадвар нь оюутан багш буюу тухайн багш бэлтгэх хөтөлбөрийн суралцахуйн хүрэх үр дүнг харуулсан ба хүснэгт 10 нь шинэ төгсөгч багшийн цогц чадамжийн хүрээ юм.



Хүснэгт 9. 21-р зууны багшийн шинж чанарууд

Y1-Суралцагч төвтэй байхтай холбоотой үнэт зүйлс	Y2- Багшийн нэр хүнд, ялгарах байдалтай холбоотой үнэт зүйлс	Y3- Мэргэжил болон олон нийтэд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой үнэт зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>Нинжин сэтгэл</li> <li>Хүүхэд бүр сурч чадна гэсэн итгэл</li> <li>Хүүхэд бүрийн чадамжийг хөгжүүлэхэд оролцох оролцоо</li> <li>Ялгаатай байдлыг хүндэтгэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өндөр стандартыг хангах эрмэлзэл</li> <li>Байгаль дэлхийгээ судлах</li> <li>Суралцахын тулд эрэл хайгуул хийх</li> <li>Хөгжихийг эрмэлзэх</li> <li>Хүсэл тэмүүлэл</li> <li>Дасан зохицол</li> <li>Ёс зүйтэй</li> <li>Мэргэшсэн байдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хамтран суралцаж, туршлагажих</li> <li>Дагалдан сурах болон зөвлөн туслах (mentoring)</li> <li>Нийгмийн хариуцлага, оролцоо</li> <li>Өөриймсөг, хариуцлагатай хандах</li> </ul>
<b>Ур чадвар</b>		<b>Мэдлэг</b>
<ul style="list-style-type: none"> <li>Эргэцүүлэх сэтгэн бодох чадвар</li> <li>Заах арга зүйн чадвар</li> <li>Хүмүүсийг удирдан зохион байгуулах чадвар</li> <li>Хувийн зохион байгуулалтын чадвар</li> <li>Удирдлага, зохион байгуулалтын чадвар</li> <li>Харилцааны чадвар</li> <li>Хөнгөвчлөх чадвар</li> <li>Технологийн чадвар</li> <li>Инновац ба бизнес сэтгэлгээний чадвар</li> <li>Нийгэм, сэтгэл судлалын ухаан</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>Өөрийгөө</li> <li>Сурагч</li> <li>Олон нийт</li> <li>Судлагдахууны агуулга</li> <li>Заах арга зүй</li> <li>Боловсролын суурь, бодлого</li> <li>Сургалтын хөтөлбөр</li> <li>Олон соёлын бичиг үсэг</li> <li>Дэлхийн глобалчлалыг ойлгох ухамсар</li> <li>Хүрээлэн буй орчноо ойлгох ухамсар</li> </ul>

Эх сурвалж: (Z.Nazeer-Ikeda, 2022)

Хүснэгт 10. Сингапур Улсын шинэ төгсөгчийн чадамжийн хүрээ

№	Гүйцэтгэлийн хэмжээс	Гол цогц чадамжууд
1	Мэргэжлийн практик	<ol style="list-style-type: none"> <li>Хүүхдийг бүхэлд нь хүмүүжүүлэх</li> <li>Хүүхдийг чанартай сургах</li> <li>Хүүхдийг хамтарсан сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагаагаар чанартай сургах</li> <li>Мэдлэгийг хөгжүүлэх: <ol style="list-style-type: none"> <li>судлагдахууныг эзэмших</li> <li>эргэцүүлэх</li> <li>дүн шинжилгээ хийх</li> <li>санаачилгатай</li> <li>бүтээлчээр багшлах</li> <li>ирээдүйд чиглэсэн</li> </ol> </li> </ol>
2	Манлайлал ба менежмент	<ol style="list-style-type: none"> <li>Зүрх сэтгэл, оюун ухааныг байлдан дагуулах <ol style="list-style-type: none"> <li>Байгаль орчны тухай ойлголт</li> <li>Бусдыг хөгжүүлэх</li> </ol> </li> <li>Бусадтай ажиллах <ol style="list-style-type: none"> <li>Эцэг эхчүүдтэй хамтрах</li> <li>Багаар ажиллах</li> </ol> </li> </ol>
3	Хувь хүний үр нөлөөтэй байдал	<ol style="list-style-type: none"> <li>Өөрийгөө болон бусдыг таньж мэдэх <ol style="list-style-type: none"> <li>Өөрийгөө өөрчлөх</li> <li>Хувийн шударга байдал, хууль зүйн үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэх</li> <li>Бусдыг хүндэтгэх, ойлгох</li> <li>Дасан зохицол</li> </ol> </li> </ol>

Тайлбар: Эх сурвалжаас судалгааны баг орчуулав.

## **БНХАУ-ын тусгай захиргааны бүс Хонконгийн багийн цогц чадамжийн хүрээ**

2003 онд Багшийн боловсрол, мэргэшлийн зөвлөх хорооноос багшийн цогц чадамжийн хүрээг боловсруулж гаргасан. Энэхүү хүрээ нь багш болон сургуулийн хувьд багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлохдоо ашиглах зөвлөмж юм. Энэ хүрээг ерөнхий хүрээ гэж тооцдог бөгөөд сургуулиуд өөрийн онцлогт тохируулан өөрчлөх боломжтой байдаг. Хонконгийн багийн цогц чадамжийн хүрээ нь үндсэн 4 айгаас бүрддэг бөгөөд хүснэгт 11-д дэлгэрэнгүй харуулав. Энэ хүрээний онцлог нь багшийн мэргэжлийн хөгжлийн өсөлтийн ахиц дэвшлийг харуулахын тулд 3 үе шатанд (гарааны багш, чадварлаг, чадваржсан) түвшинчилсэн байдаг.

*Хүснэгт 11. Хонконгийн багийн цогц чадамжийн хүрээ*

<b>№</b>	<b>Ай</b>	<b>Бүрэлдэхүүн</b>
<b>1</b>	Багшлахуй ба суралцахуй	1. Судлагдахууны мэдлэг
		2. Сургалтын хөтөлбөр болон багшлах арга зүйн агуулгын мэдлэг
		3. Багшлах стратеги болон ур чадвар, хэл болон мультимедиагийн хэрэглээ
		4. Үнэлгээ
<b>2</b>	Суралцагчийн хөгжил	1. Сургуулийн орчин дахь суралцагчийн ялгаатай хэрэгцээ
		2. Суралцагчтайгаа харилцах харилцаа
		3. Уламжлалт хүмүүжлийн халамж
		4. Суралцагчийн ялгаатай суралцах арга барил
<b>3</b>	Сургуулийн хөгжил	1. Сургуулийн алсын хараа, зорилго, соёл, ёс зүй
		2. Бодлого, зохицуулалт, туршлага
		3. Гэр болон сургуулийн хамтын ажиллагаа
		4. Нийгмийн үнэт зүйлс болон өөрчлөлтийн талаарх хариуцлага
<b>4</b>	Мэргэжлийн харилцаа болон үйлчилгээ	1. Сургууль доторх хамтын ажиллагаа
		2. Багшийн мэргэжлийн хөгжил
		3. Боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох оролцоо
		4. Боловсролтой холбоотой сайн дурын болон олон нийтийн ажил

*Тайлбар: Эх сурвалжаас орчуулж эмхэтгэв.*

Дээрх хүрээ нь суурь 6 үнэт зүйлс дээр тулгуурлана. Тэдгээр үнэт зүйлсэд бүх суралцагчаа сурч чадна гэсэн итгэл, суралцагчаа хайрлаж, халамжлах сэтгэл, олон талт байдлыг хүндэтгэх, мэргэжилдээ өөрийгөө зориулж, тууштай байх, багийн хамтын ажиллагаа, бие биеэ мэдлэг, мэдээллээ хуваалцах, нөхөрсөг байх боломжийг бүрдүүлэх, тасралтгүй суралцах, сайн сайхан оршин байх эрмэлзэл гэсэн үнэт зүйлс ордог байна.

### **1.5. Багшийн цогц чадамжийн хүрээнд хийсэн харьцуулсан шинжилгээ, түүний үр дүн**

Судалгааны аргачлалын дагуу олон улсын хэмжээний тайлан, баримт бичгүүдээс хайлт хийж, судалгааны багийн хүрээнд харилцан тохиролцсоны үндсэн дээр гадаадын 12 баримт бичгийг, Монгол Улсаас 4 баримт бичгийг эх сурвалжаар сонгосон ба эдгээр эх сурвалжийг бодлогын баримт бичиг, судалгааны төрлөөр хүснэгт 12-т харуулав.

Хүснэгт 12. Сонгогдсон эх сурвалжуудын жагсаалт

Эх сурвалж	Монгол Улсын	Олон Улсын	Хэсгийн дүн
Судалгааны өгүүлэл		4	4
Судалгааны тайлан	1		1
Бодлогын болон бусад баримт бичиг	3	8	11
<b>Нийт</b>	<b>4</b>	<b>12</b>	<b>16</b>

1. Сонгогдсон эх сурвалжуудад эхний байдлаар шинжилгээ хийж Багшийн цогц чадамжийн хүрээ нь ямар ай болон бүрэлдэхүүнүүдээс бүрдсэн болохыг илрүүлж гаргав (үр дүнг хүснэгт 13-т үзүүлэв).
2. Сонгон авсан эх сурвалжийн чадамжийн хүрээ 3-4 айгаас бүрдэж байгаа нь нийтлэг байна (хүснэгт 13). Тэдгээрээс давтамж хамгийн ихтэй айн хүрээг тодорхойлбол,
  - 1) багшийн мэдлэг, ойлголт,
  - 2) багшлахуйн ур чадвар,
  - 3) үнэт зүйл, хандлага,
  - 4) олон нийт болон бусадтай хамтран ажиллах,
  - 5) мэргэжлийн хөгжилтэй холбоотой цогц чадамжууд байна.
3. Эдгээр айд ямар чадамжууд хамаардаг болохыг олон улсын хэмжээний багшийн цогц чадамжийн хүрээнүүд, зарим улс орны багшийн цогц чадамжийн хүрээ, өөрийн орны багш загварыг сонгон авч, агуулгын (контент) дүн шинжилгээ хийх аргаар чадамжуудын давтамжийг нэгтгэн гаргаж харьцуулсан ба ингэхдээ давтамж ихтэйгээс бага руу эрэмбэлсэн болно (хүснэгт 14).
4. Монгол Улсын бодлого, эрх зүйн баримт бичиг болон багшийн загвар, мөн зарим улсын багшийн цогц чадамжийн хүрээнүүдийг харьцуулж үзвэл;
  - Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд багшийн мэдээлэл, харилцаа, холбооны технологи, гадаад хэлнээс англи хэл, мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны мэдлэг, чадвар, мэргэжлийн хөгжил, олон нийттэй хамтран ажиллах, суралцагчид үзүүлэх дэмжлэгтэй холбоотой чадамжийг онцолжээ. Мөн багшийн хандлага, ёс зүйн асуудлыг Монгол Улс чухалчилсан нь гадаад орны, тухайлбал, Сингапурын 21-р зууны багшийн шинж чанарууд болон Хонконгийн багшийн цогц чадамжийн хүрээнд багшийн үнэт зүйлс гэж тусгагджээ.
5. Тухайлсан улс орнуудын туршлагатай харьцуулахад тэдгээрийн багшийн цогц чадамжийн хүрээ нь олон улсын хэмжээний багшийн цогц чадамжийн элементүүдтэй төсөөтэй байна. Тухайлбал, Австрали улсын хувьд суралцагчийн суралцахуйг чиглүүлэх, сурлагын үр дүнг үнэлэх, тайлагнах, мэргэжлийн сургалтад хамрагдах, сургуулийн хамт олонтой хамтран ажиллах чадамжууд, харин Сингапурын хувьд багшийн мэдлэг, ойлголтоос гадна технологийн чадвар болон зөөлөн ур чадварууд болох харилцаа, удирдлага, зохион байгуулалтын чадваруудыг чадамжийн хүрээндээ багтаажээ. Хонконгийн хувьд мөн судлагдахуун, заах арга зүйн мэдлэгээс гадна суралцагчийг хөгжүүлэх, бусадтай хамтран ажиллах, өөрийгөө болон бусдыг таньж мэдэх зэрэг чадамжуудыг хамаарсан байгаа нь багшийн нийтлэг цогц чадамжуудын элементийг агуулсан болохыг харуулж байна.

Хүснэгт 13. Багшийн цогц чадамжийн хүрээний ай буюу бүрэлдэхүүн

<b>Эх сурвалж</b>	<i>Teachers' Council of Thailand (2018)</i>	<i>Ерөнхий боловсролын бодлогын зөвлөх багийн “Багшийн загвар боловсруулах” ажлын хэсгийн тайлан</i>	<i>European Commission (2013) Supporting teacher competence development for better learning outcomes</i>	<i>European Commission (2010) Common European principles for teacher competences and qualifications</i>	<i>OECD (2017) Pedagogical Knowledge and the Changing Nature of the Teaching Profession</i>	<i>UNESCO (2019) Teacher Policy Development Guide</i>
<b>Хүрээ нэр</b>	<b>Зүүн Өмнөд Азийн багшийн цогц чадамжийн хүрээ</b>	<b>Монгол багш загвар</b>	<b>Багшийн цогц чадамж</b>	<b>Багшийн цогц чадамж</b>	<b>Багш мэргэжлийн цогц чадамж</b>	<b>Дэлхий дахины багш мэргэжлийн стандартын хүрээ</b>
<b>Чадамжийн бүрэлдэхүүн</b>	Юу зааж байгаагаа мэддэг, ойлгодог байх	Академик чадамж Мэргэшиж буй шинжлэх ухааны салбарын, салбар дундын	Мэдлэг, ойлголт	Мэдлэг, мэдээллийн технологитой ажиллах	Мэргэжлийн мэдлэг	Судлагдахууны мэдлэг Суралцагчийн талаарх мэдлэг
	Сурагчдынхаа суралцахуйд туслах	Мэргэжлийн чадамж “Багш” мэргэжлийн	Ур чадвар	Бусадтай ажиллах		Багшлах арга зүйн чадвар Суралцагчийн суралцахуйг үнэлэх Сургалтын орчныг удирдах
	Олон нийтийн ажилд оролцох	Суурь чадамж Нийгмийн болон хувийн	Зан чанар: итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлс, оролцоо	Нийгэмдээ болон нийгэмтэйгээ ажиллах		
	Өдөр бүр илүү сайн багш болох	Эрхэмлэх зүйл Үнэт зүйл, хандлага			Сэтгэл хөдлөл, урам зоригийн шинж чанарууд	Тасралтгүй хөгжих чадамж

Тайлбар: Судалгааны баг түүвэрлэн нэгтгэв.

Хүснэгт 13. Багшийн цогц чадамжийн хүрээний ай буюу бүрэлдэхүүн (үргэлжлэл)

<b>Эх сурвалж</b>	<i>Educational International and UNESCO (2019) Global Framework of professional standards</i>	<i>TKCOM (2018) Global Teachers' Key Competences Framework</i>	<i>Yuefeng Zhang (2019) Learning to teach in Hong-Kong (book chapter)</i>	<i>Kiyomet Selvi (2010) Teacher's competencies</i>	<i>Abdulghani Alnoor and Ma Hong Yu (2010) Yemenis Primary School Teacher Competency</i>	<i>Jürgen Baumert and Mareike Kunter (2006)</i>
<b>Хүрээ нэр</b>	<b>Багшийн мэргэжлийн стандартын хүрээ</b>	<b>Бага ангийн багшийн цогц чадамж</b>	<b>Багшийн чадамжийн ерөнхий хүрээ (Хонконг)</b>	<b>Багш мэргэжлийн цогц чадамж</b>	<b>Бага ангийн багшид шаардлагатай цогц чадамж</b>	<b>Багшийн мэргэжлийн цогц чадамжийн COACTIV загвар</b>
<b>Чадамжийн бүрэлдэхүүн</b>	Багшийн мэдлэг ба ойлголт	Мэдлэг	Багшлахуй болон суралцахуй	Сургалтын хөтөлбөрийн	Мэдлэг	Мэдлэг
	Багшлах туршлага	Чадвар	Суралцагчийн хөгжил	Нийгэм-соёлын	Багшлах чадвар	
	Багшийн харилцаа		Сургуулийн хөгжил	Сэтгэл хөдлөлийн	Үнэлгээ	Итгэл үнэмшил, үнэт зүйлс, зорилго
		Хандлага, үнэт зүйл	Мэргэжлийн харилцаа болон үйлчилгээ	Насан туршдаа суралцахуйн	Мэргэжлийн үнэт зүйлс болон зан үйл	Урам зоригийн чиг баримжаа Хувийн зохион байгуулалт

Тайлбар: Судалгааны баг түүвэрлэн нэгтгэв.

Хүснэгт 14. Олон улсын хэмжээний баримт бичигт хийсэн харьцуулсан шинжилгээний үр дүн

Чадамжууд	Чадамжийн хүрээний нэр			
	Зүүн өмнөд Азийн багшийн цогц чадамжийн хүрээ	Дэлхий дахины багшийн үндсэн цогц чадамжийн хүрээ	Европын Холбооноос гаргасан Багшийн цогц чадамжууд	Багшийн мэргэжлийн стандартын дэлхий дахины хүрээ
Багшлахуй-суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөх	*	*	*	*
Багшлахуй (Багшлахуйн үр дүнтэй арга, багшлах ур чадвар, арга зүйн сонголт, эерэг орчин бүрдүүлэх, анги удирдах )	*	*	*	*
Үнэлгээ хийх	*	*	*	*
Тэгш хамруулах	*	*	*	
Олон нийттэй хамтран ажиллах	*	*	*	*
Өөрийгөө эргэцүүлэх ба мэргэжлийн тасралтгүй хөгжил	*	*	*	*
Харилцаа	*	*	*	*
Мэдлэг, ойлголт (Судлагдахууны агуулгын, заах арга арга зүйн агуулгын, заах арга зүйн, суралцагчийн талаарх, боловсролын бодлого, чиг хандлага, сургалтын хөтөлбөрийн, боловсролын шинжлэх ухааны, судалгааны арга зүйн, хөгжлийн сэтгэл судлалын, судалгаанд суурилсан мэдлэг)	*		*	*
Суралцахуйг дэмжих (чиглүүлэх, зохион байгуулах, урамшуулан сайшаах, суралцагч болон бүлгийг удирдах)	*		*	*
Мэдээлэл, харилцаа холбооны технологитой холбоотой		*	*	
Ёс зүйн үүрэг хариуцлага		*		

Тайлбар: \* тэмдэглэгээ нь тухайн чадамжийг агуулж байгааг илэрхийлнэ.

Багшийн мэдээлэл, харилцаа холбооны технологитой холбоотой чадамж хэд хэдэн хүрээнүүдэд багтаж байсан төдийгүй ЮНЕСКО Багшийн мэдээлэл харилцаа, холбооны чадамжийн хүрээ гаргах баримт бичигт дурдсанаар багшийн хувьд боловсролын үйл ажиллагаанд МХТ-ийг үр дүнтэй хэрэглэх нь өнөө үед чухал болохыг онцолжээ. Харин ЭЗХАХБ-ын чадамжийн хүрээний тухайд хувь хүний зөөлөн ур чадварыг чухалчилсан бол нийтлэг мэргэжлийн чадамжийн рубрикт үнэт зүйлс, ёс суртахуун, суралцагчийн суралцахуй ба хөгжил, байгууллага, хамт олонтойгоо хамтран ажиллах, хууль, бодлогын

талаарх мэдлэг, үнэлгээ, судалгаа болон бусдад зөвлөх, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой чадамжуудыг тодорхойлсон байна.

Эдгээр баримт бичгийн шинжилгээний үр дүнд судалгааны багаас судалгааны аргачлалын дагуу тодорхойлсон Багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээг зураг 7-д харуулав.

Зураг 7. Багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээ



Багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээ нь багшийн 1) Мэдлэг ойлголт, 2) Багшлахуй ба суралцахуй, 3) Хамтын ажиллагаа, 4) Мэргэжлийн хөгжил, үнэт зүйл гэсэн 4 айгаас бүрдэнэ (зураг 7).

Мэдлэг ойлголт айн хүрээ нь;

- судлагдахууны мэдлэг,
- багшлах арга зүйн мэдлэг,
- мэдээлэл, харилцаа, холбоо технологийн мэдлэг,
- боловсролын чиг хандлага, бодлого,
- судалгаанд суурилсан мэдлэг, ойлголт гэсэн бүрэлдэхүүнтэй.

Багшлахуй ба суралцахуй айд;

- төлөвлөлт,
- багшлахуйн ур чадвар,
- суралцахуйг дэмжих,
- тэгш хамруулалт,
- үнэлгээтэй холбоотой чадамжууд багтана.

Хамтын ажиллагаа айд;

- эцэг, эх, асран хамгаалагч,
- олон нийт,
- хамт олон,
- харилцаатай холбоотой чадамжууд хамаарч байна.

Мэргэжлийн хөгжил, үнэт зүйлс айн хүрээ нь:

- багш өөрийгөө эргэцүүлэхүй,
- мэргэжлийн тасралтгүй хөгжил,
- мэргэжил нэгтэндээ үзүүлэх мэргэжлийн дэмжлэг,
- багшийн үнэт зүйлс, хандлага гэсэн бүрэлдүүнтэй байхаар тус тус томъёологдож байна.



# ХОЁР. БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ МЭРГЭЖЛИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН СУДАЛГАА

## 2.1. Монгол Улсын бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн

Монгол Улсад бага боловсролын багш хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон төрийн бус өмчийн их дээд сургуулиудын төгсөгчийн эзэмших үр чадварыг нэгтгэн Хүснэгт 15-д жагсааж харуулав.

*Хүснэгт 15. Монгол Улсын Бага боловсролын багш мэргэжлээр төгсөгчдийн хувь хүний болон мэргэжлийн үр чадвар дадал төлөвшлийн нэгтгэл*

<i>ХУВЬ ХҮНИЙ СУУРЬ МЭДЛЭГ, ЧАДВАР, ХАНДЛАГА</i>
Эх түүх, соёл, ёс заншил, уламжлалаа мэдэх
Эх түүх, соёл, ёс заншил, уламжлалаар бахархах
Эх түүх, соёл, ёс заншил, уламжлалаа хадгалах
Эх түүх, соёл, ёс заншил, уламжлалаа хэрэглэх
Эх түүх, соёл, ёс заншил, уламжлалаа хөгжүүлэх
Иргэний ардчилсан ёсны суурийг бүрдүүлэгч, үнэт зүйлсийг мэддэг байх
Бусад үндэстэн, бүс нутаг, өөрийн улс орны түүх, соёлын өвийг олон ургалч агуулгаар олгох чадвартай
Бусад үндэстэн, бүс нутаг, өөрийн улс орны түүх, соёлын өвийг олон ургалч агуулгаар тайлбарлах чадвартай
Бусад үндэстэн, бүс нутаг, өөрийн улс орны түүх, соёлын өвийг олон ургалч агуулгаар баяжуулах чадвартай
Эх оронч үзэлтэй байх
Хүнлэг ёсыг дээдлэн сахидаг байх
Хувь хүний болон иргэний эрх, эрх чөлөө ардчилсан ёсыг эрхэмлэдэг
Хууль дээдлэх зарчмыг эрхэмлэдэг
Шударга ёсыг эрхэмлэдэг
Хүнлэг чанарыг эрхэмлэдэг
Бага насны хүүхэдтэй ажиллах сонирхолтой
Бага насны хүүхдийг хайрладаг сэтгэлтэй
Тулгамдсан асуудалд зөв шийдвэр олж чаддаг
Оюуны өндөр чадавхтай
Бусад улс үндэстний соёл иргэншлийг ойлгон хүндэтгэдэг
Эрх зүйт төр хууль цаазыг дээдэлдэг
Байгаль, нийгэм, хүний хоорондын харьцааг зохицуулдаг
Ёс зүй, эрх зүйн хэм хэмжээг мэддэг
Амьдрал, үйл ажиллагаандаа ёс зүй, эрх зүйн хэм хэмжээний талаарх мэдлэгээ хэрэглэх чадвартай байх
Эрүүл аж төрөх ёсны талаар шинжлэх ухааны төсөөлөлтэй
Өөрийн бие бялдрыг хөгжүүлэх чадвартай байх
Өөрийн бие бялдрыг хөгжүүлэх дадалтай байх
Урлаг спортын ерөнхий мэдлэгтэй
Байгаль, гоо сайханы мэдрэмжтэй,
Эрүүл аж төрөх ёс зүйд суралцсан

Гадаад хэлний зохих мэдлэгтэй байна
Бие даан бүтээлчээр суралцах
Өөрийгөө хөгжүүлэх чадвартай байх
Хамт олны дунд ажиллахад бэлэн байх
Өөрийн хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулдаг
Харилцааны соёлтой байх
Зөрчилтэй нөхцөлд бусдын үзэл бодлыг хүндэтгэн зөвшилцөх чадвартай
Өөртөө болон бусдын өмнө хариуцлага хүлээх чадвартай байх
Шинэ санаа гаргах чадвартай байх
Шинэ санаагаа хэрэгжүүлэх чадвартай
Шинэ санаагаа хэрэгжүүлэх дадалтай
<i>МЭРГЭЖЛИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ДАДАЛ ТӨЛӨВШИЛ</i>
Шинийг эрэлхийлэх, чадвартай
Асуудал шийдвэрлэх чадвартай (Асуудлыг тодорхойлох, шинэ санаа гаргах, шинэ санааг зураглах, Боломжит хувилбарыг сонгох)
Асуудлыг шинжлэн судалж шийдэл гаргах чадвар (Таамаглал дэвшүүлэн харьцуулсан судалгаа,анализ хийж загварчилах, баримт бичиг боловсруулах)
Суралцах төлөвлөгөөг жил, улирал, сар, өдөр, цагаар төлөвлөх чадвар (мэргэжлийн сэтгэлгээгээр хандах, хоорондоо хамааралтай зүйлсийг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг нь ойлгож, ач холбогдлоор нь ангилах, чухал санаан дээр төвлөрөх, харилцан хамаарлыг нь шалгах, харьцуулан сонгох)
Мэргэжлийн онцлогийг нийгэм цаг үетэй холбон ойлгуулах чадвартай
Мэргэжлийн онцлогийг нийгэм цаг үетэй холбон заах чадвартай
Мэргэжлийн онцлогийг нийгэм цаг үетэй холбон цаашид суралцах чадвартай
Мэргэжлийн онцлогийг нийгэм цаг үетэй холбон гүйцэтгэх чадвартай
Мэргэжлийн ёс зүйтэй
Мэргэжлийн хариуцлагатай
Мэргэжлийн чадвартай
Эдийн засгийн хувьд тооцоотой байх
Өөрийгөө хөгжүүлэн мэргэжлээ дээшлүүлэх чадвартай байх
Хүний хөгжлийн зүй тогтол, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг таньж мэдэх
Хүний хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг таньж мэдэх
Суралцагчийн хөгжил, төлөвшил болон нийгэм-сэтгэл зүйн орчны онцлог, түүнийг сургалт үйл ажиллагаанд харгалзах чадвартай байх
Боловсролын тогтолцоо, түүний удирдлагын үндсийн тухай мэдлэг
Хүний хөгжлийн зүй тогтол, хувийн ба нийгэм сэтгэлзүйн онцлогийг таних, харгалзах
Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах /хөтөлбөр боловсруулах, хөтөлбөр үнэлэх, хичээлийн бэлтгэл хангаж зохион байгуулах, хичээлд анализ хийх, хичээлийн материал боловсруулах, мэдлэг чадвар дүгнэх/;
Суралцагчийн нас сэтгэхүй, бодит орчин нөхцөлд тохирсон сургалтын арга барил, арга технологийг ашиглах
Суралцагчийн нас сэтгэхүй, бодит орчин нөхцөлд тохирсон зурах үйлийг эзэмшсэн
Суралцагчийн нас сэтгэхүй, бодит орчин нөхцөлд тохирсон урлах үйлийг эзэмшсэн
Суралцагчийн нас сэтгэхүй, бодит орчин нөхцөлд тохирсон наах бүтээх үйлүүдийг эзэмшсэн
Хүмүүнлэгийн болон нийгэм-эдийн засгийн шинжлэх ухааны үндсэн сургуулиудтай танилцсан байх
Нийгмийн шинжтэй үйл явдал, асуудлыг шинжлэх ухаанчаар задлан шинжлэх чадвартай
Шинжлэх ухааны аргуудыг мэргэжлин болон нийгмийн төрөл бүрийн үйл ажиллагаанд хэрэглэж чаддаг байх
Амьд болон амьгүй байгаль дэх үзэгдэл үйл явцын тухай бүрэн дүүрэн төсөөлөлтэй

Байгалийг танин мэдэх шинжлэх ухааны орчин үеийн аргуудын боломжийг ойлгосон
Байгалийг танин мэдэх шинжлэх ухааны орчин үеийн аргуудыг мэргэжлийн үүргээ биелүүлэхэд ашиглаж чаддаг байх
Мэргэжлийн үүргээ биелүүлэхтэй холбоотой зорилгыг тавих, зорилтуудыг тодорхойлох чадвартай
Мэргэжлийн үүргээ биелүүлэхтэй холбоотой зорилго зорилгыг шийдвэрлэхэд шинжлэх ухааны аргуудыг ашиглаж чаддаг байх
Сургалтын идэвхтэй арга барил болон сургалтын бусад арга барилын олон хувилбаруудаас оновчтой сонгон сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чадвартай
Багшийн нэр хүнд ёс зүй, төрийн хууль, дүрэм, журам сахин мэдэх
Багшийн нэр хүнд ёс зүй, төрийн хууль, дүрэм, журам сахин мөрдөх, үлгэрлэх
Багшийн нэр хүнд ёс зүй, төрийн хууль, дүрэм, журам сахин үлгэрлэх
Нэгээс доошгүй гадаад хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах чадвартай байх
Багаар ажиллах чадвартай байх
Орчин үеийн мэдээлэл технологийг ашиглан өөрийн мэдлэгээ баяжуулан, шинэ мэдлэг олж авах, бие дааж суралцах чадвартай бүтээлч сэтгэлгээтэй, ертөнцийг үзэх үзэлтэй
Номын сангийн фонд , компьютерын систем , гадаад ном хэвлэл зэргээр дамжуулан мэргэжлийн холбогдол бүхий мэдээллийг авч ашиглах чадвартай
Шинжлэх ухааны хөгжил, нийгмийн практик хурдацтай өөрчлөгдөж байгаа нөхцөлд өөрийн боломждоо дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан шинэ мэдлэг олж авах, өөрийн мэргэжил боловсролоо бүтээлчээр тасралтгүй дээшлүүлэх чадвартай байх
Багаар ажиллах, удирдах, манлайлах, гүйцэтгэх чадварууд (Баг бүрдүүлэх, Багийг удирдах, Менежментийг хэрэгжүүлэх, Манлайлах)
Тухайн гадаад хэлээр мэргэжил, мэдээллийг ашиглах чадвартай
Харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мультимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах үндсэн ур чадвартай байх
Хөтөлбөрийн хичээлээр мэдлэгийг эзэмшиж, мэргэжлийн ур чадварыг эзэмшихэд сургууль туслан дэмжсэн байна.
Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, бага насны хүүхдийг хөгжүүлэх арга технологи, боловсролын хөгжлийн үндсэн чиглэл, хэтийн төлөвийн талаар мэдлэг, чадвартай байх
Монгол улсын үндсэн хууль, боловсролын багц хууль, Засгийн газрын тогтоол шийдвэр, хүүхдийн эрхийн конвенц зэрэг эрх зүйн актыг зөв ойлгож хэрэглэх, тайлбарлах хэрэгжүүлэх чадвартай
Бага насны хүүхдийн мэдлэг чадвар хэвшлийг үнэлэх чадвартай
Бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр судалгаа хийж, тэдний хөгжлийн түвшинг тодорхойлох, судалгааны үр дүнд өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт өгч чаддаг чадвартай
Хүүхдийн хөгжлийн чиглэлээр судалгаа хийх, судалгааны үр дүнд боловсруулалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх
Бага насны хүүхдийн сурч хөгжих, үр ашигтай аргуудыг хэрэглэх чадвартай
Бага насны хүүхдэд аюулгүй, аюултай гэдгийг ойлгуулж мэдрүүлэх чадвар чадвартай
Хүүхдийг хайрладаг тэдэнтэй эв дүйтэй харьцдаг
Бага насны хүүхэд боловсролын ямар үйлчилгээг авах ёстой тухай мэдлэг
Ерөнхий сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлалын орчин үеийн онол арга зүйн мэдлэг
Бага насны хүүхдийн хөгжлийн тухай онол үзэл баримтлал
Бага насны хүүхдийн хөгжил, түүний онцлог
Хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэг
Судалгааны арга зүйн мэдлэг
Бага насны хүүхдийн нас сэтгэцийн хөгжлийн онцлогт тулгуурлан тэднийг хөгжүүлэх арга технологийн талаарх мэдлэг
Бага насны хүүхдийг сургаж хөгжүүлэх сургах зүйн дидактик системтэй мэдлэг эзэмшсэн

Бага насны хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх мэдлэг эзэмшсэн
Бага насны хүүхдийн математик чадварыг хөгжүүлэх мэдлэг эзэмшсэн
Бага насны хүүхдийн эцэг эхтэй ажиллах арга барилын мэдлэг эзэмшсэн
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж хөгжүүлэх онол арга зүйн мэдлэг
Холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг мөрдөх, хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчлах,
Бага насны хүүхдийн мэдлэг чадварыг үнэлэх,
Хувилбарт сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,
Хүүхдийн хэл яриа, сэтгэхүйг хөгжүүлэх,
Бага насны хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр эрүүл ахуйн дадал эзэмшүүлэх,
Сургалтын үйл ажиллагааны эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын шаардлагыг хангах.
Холбогдох хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг мөрдөх, хүүхэд эцэг эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчлах
Сургалтын арга барилын олон хувилбаруудаас оновчтойг сонгон авч сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
Хувилбарт сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
Бага насны хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл, чийрэг өсгөж, хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн дадал эзэмшүүлэх
Хүүхэд өөрийгөө илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харьцах, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах
Хүүхдийн эрх ашгийг хамгаалахад эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх
Заах арга, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх
Хөгжлийн орчин үеийн чиг хандлага, судалгааны, арга барилын талаар цогц мэдлэгтэй
Хүүхдийг судалж танин мэдэх чадварыг эзэмшсэн.
Суралцагчийн сурах үйл ажиллагааг удирдан дэмжихэд багшийн гүйцэтгэх үүргүүдийг мэддэг байх
Сургах үйл ажиллагааг сургалтын зорилгод чиглүүлэн хэрэгжүүлэх хичээлээрээ дамжуулан бие хүнийг хүмүүжүүлэх хөгжүүлэх мэдлэгтэй
Орчин үеийн сургалтын хэрэглэгдэхүүн тэдгээрийг хэрэглэх мэдлэгтэй
Сургалт хүмүүжлийн ажлын үр дүнг хянах ажлыг зохион байгуулах мэдлэгтэй
Хүүхдийг таньж мэдэх сурах хэрэгцээ, сонирхлыг судлах чадвар
Сургалтын өөр өөр орчинд суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжих чадвар
Суралцагчийг ялгаварлан гадуурхалгүйгээр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах чадвар
Сургалтыг бие хүний үнэт зүйлсийг төлөвшүүлэхтэй хослуулах чадвар
Сургалтын явцад суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, тэднээр техникийн аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах дүрмийг сахиулах чадвар
Хичээлээс гадуурх сургалт-хүмүүжлийн ажлыг төлөвлөх, удирдах чадвар
Анги удирдах /ангид хичээл заах/үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвар
Ангийн баримт бичиг /журнал, ажиглалт, тэмдэглэл, мэдээ/хөтлөх чадвар
Сургалт заах аргын нэгдэл болон заах аргын бусад хэлбэрийн үйл ажиллагаанд оролцох, бусад багш нартай хамтран ажиллах чадвар
Багшийн мэргэжлийн ёс зүйн шаардлагыг эрхэмлэн сахиж, биелүүлэх чадвар

## 2.2. Гадаад улсын бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн

Гадаад улсын бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн харьцуулсан шинжилгээ хийхдээ Монгол Улсын хоёр хөрш улс, Солонгос, Финлянд, Шинэ Зеланд, Филиппин, Австрали зэрэг улс орнуудын бага боловсролын багш бэлтгэдэг их, дээд сургуулиудыг сонгосон бөгөөд дараах хэсгүүдэд баримт бичгийн судалгааны үр дүнг өгүүлэв.

### *Оросын Холбооны Улс*

Москвагийн Улсын Сэтгэл Судлал Сурган Хүмүүжүүлэх Ухааны Их Сургуулийн бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн үр дүнд төгсөгч нь суурь чадамж, мэргэжлийн чадамж болон мэргэшлийн чадамжтай болж төгсөхөөр тусгажээ. Тухайлбал, суурь чадамжид системийн, шүүмжлэлт сэтгэлгээ, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, багаар ажиллах, манлайлах, харилцах, соёл хоорондын харилцаа, өөрийгөө хөгжүүлэх, амьдрал үйл ажиллагааны аюулгүй байдал гэсэн чадамжуудаас бүрддэг байна. Харин мэргэжлийн чадамжид мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн болон ёс зүйн үндэс, үндсэн болон нэмэлт боловсролын хөтөлбөр боловсруулах, суралцагчийн хувийн, хамтын сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа, хүмүүжил, сургалтын орчныг бүрдүүлэх, боловсролын үр дүнгийн хяналт, үнэлгээ, мэргэжлийн үйл ажиллагаа дахь сэтгэл судлал-сурган хүмүүжүүлэх ухааны технологи, боловсрол, сургалтын үйл ажиллагааны оролцогч талуудтай хамтран ажиллах, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс гэсэн чадамжийн элементүүдээс бүрдсэн байна. Мэргэшлийн чадамжийн тухайд сурган хүмүүжүүлэх, төслийн, дагалдахтай холбоотой чадамжуудаас бүрддэг. Сургалтын хөтөлбөрийн энэхүү хүрэх үр дүн нь төгсөгч эдгээр чадамжуудыг эзэмшсэн эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг мөн тогтоож өгсөн байдаг. Мэргэжлийн болон мэргэшлийн чадамжийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хувьд мэддэг байх, чаддаг байх, эзэмшсэн байх гэсэн гүйцэтгэлийн түвшин тогтоосон байна. Нарийвчилсан сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 16. ОХУ-ын Москвагийн Улсын Сэтгэл Судлал Сурган Хүмүүжүүлэх Ухааны Их Сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн*

№	Олон талт чадамжийн бүлэг	Чадамжийн тодорхойлолт	Чадамжийн индикатор
<b>ОЛОН ТАЛЫН ЧАДАМЖ - СУУРЬ ЧАДАМЖ</b>			
1	Системийн, шүүмжлэлт сэтгэлгээ	УК 1. Тавьсан зорилгоо шийдэхийн тулд системийн хандлагыг ашиглах, аливаа мэдээлэл анализ, синтез хийх, шүүмжлэлт байдлаар хандах, эрэл хайгуул хийх чадвартай байх.	УК 1.1. Аливаа зорилт, түүнийг бүрдүүлэгч хэсгүүдийг ялгах, шинжлэх. УК 1.2. Тавьсан зорилтдоо хүрэхийн тулд шаардлагатай мэдээллийг эргэцүүлэн шинжилдэг байх. УК 1.3. Аливаа зорилтыг шийдэх шийдлийн хувилбаруудыг гаргаж ирэх, тэдгээрийн давуу болон сул талыг үнэлж, дүгнэдэг байх. УК 1.4. Өөрийн эргэцүүлэл, үнэлгээг баримттай, логик дэс дараатай, грамотно боловсруулах. Аливаа баримтыг бусад оролцогчдын эргэцүүлэн боловсруулсан үнэлгээ, тайлбар, үзэл бодлоос ялгадаг байх. УК 1.5. Тодорхой зорилтын боломжит шийдлийн практик дээрх үр нөлөөг үнэлэх, тодорхойлдог байх.
2	Төсөл боловсруулах, хэрэгжүүлэх	УК 2. Тодорхой нөөц, хязгаар бүхий, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнээс үүдэн гарсан шийдлүүдийн оптималь аргыг сонгох; тавьсан зорилгын хүрээндээ зорилтуудын хүрээг тодорхойлох чадвартай байх.	УК 2.1. Аливаа төслийн тавьсан зорилгын хүрээн дэх хоорондоо холбоо хамаарал бүхий зорилтуудыг цогцоор нь тодорхойлох. УК 2.2. Тодорхой нөөц, хязгаар бүхий, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдлийн оптималь аргыг сонгох, төслийн тодорхой зорилтын шийдлийг төлөвлөх. УК 2.3. Тогтсон тодорхой хугацаанд төслийн тодорхой зорилтуудыг шийдэх. УК 2.4. Төслийн тодорхой зорилтын шийдлийн үр дүнг төсөөлдөг байх.
3	Багаар ажиллах, манлайлах	УК 3. Баг дотроо харилцан хамааралтайгаар өөрийн үүргээ биелүүлэх, хэрэгжүүлэх чадвартай байх.	УК 3.1. Тавьсан зорилгодоо хүрэхийн тулд багийн гишүүний хувьд өөрийн үүргийг тодорхойлох, хамтран ажиллах стратегийн үр ашигтай байдлыг ойлгодог байх. УК 3.2. Хамтран ажиллагсад болон харилцаанд орж байгаа ялгаатай бүлгүүдийн зан байдлын онцлогийг ойлгож, түүнийг өөрийн үйл ажиллагаандаа тооцдог байх. УК 3.3. Төлөвлөсөн үр дүндээ хүрэхийн тулд алхмуудын дэс дарааг төлөвлөх, аливаа үйл ажиллагааныхаа үр дүн, нөлөөг урьдчилан харах. УК 3.4. Багийн гишүүдтэйгээ харилцан мэдээлэл, туршлага, мэдлэг, багийн ажлын үр дүнг харуулах зэргээр үр дүнтэй харилцах. Хамтран ажиллаж байгаа хүмүүсийн зан байдлын онцлог, сонирхлыг тооцдог байх, үүсэж болох зөрчлийг шийддэг байх.

4	Харилцах	УК 4. Төрөлх болон гадаад хэл дээр бичгийн, ярианы хэлбэрээр ажил хэрэгч харилцах чадвартай байх.	<p>УК 4.1. Харилцагчтайгаа үгэн болон үгэн бус харилцааны хэрэгслийг ашиглах; төрөлх болон гадаад хэлээр ажил хэрэгч, үр дүнтэй харилцах хэв маягийг сонгодог байх.</p> <p>УК 4.2. Төрөлх болон гадаад хэл дээр харилцааны зорилтуудыг шийдвэрлэх явцдаа шаардлагатай мэдээллийг эрж олохын тулд мэдээлэл, харилцаа, холбооны технологийг ашигладаг байх.</p> <p>УК 4.3. Соёлын ялгаа, албан болон албан бус захидлын хэв маяг, найруулгын онцлогийг харгалзан төрөлх, гадаад хэлээр ажил хэрэгч захидал, харилцааг явуулдаг байх.</p> <p>УК 4.4. Төрөлх болон гадаад хэл дээр ажил хэрэгч аман яриаг соёлтой, үр ашигтай өрнүүлэх.</p> <p>УК 4.5. Мэргэжлийн чиглэлийн текстийг гадаад хэлнээс эх хэл рүү орчуулах чадвартай байх.</p>
5	Соёл хоорондын харилцаа	УК 5. Нийгмийн соёлын олон янз байдлыг нийгэм-түүх, ёс зүй, философийн контекстэд нь авч үзэх чадвартай байх.	<p>УК 5.1. Өөрийгөө хөгжүүлэх, бусадтай харилцахын тулд нийгмийн янз бүрийн бүлгүүдийн уламжлал, соёлын онцлогуудын талаарх шаардлагатай мэдээллийг ашигладаг байх.</p> <p>УК 5.2. Дэлхийн шашин, гүн ухаан, ёс зүйн сургаалыг багтаасан соёлын уламжлалын хүрээнд Орос улсын түүхэн хөгжлийн үе шатын талаарх мэдлэгт тулгуурлан нийгмийн янз бүрийн бүлгүүдийн нийгэм-соёлын уламжлал, түүх соёлын өвд хүндэтгэлтэй ханддаг байх.</p> <p>УК 5.3. Мэргэжлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор хүмүүсийн нийгэм-соёлын онцлогийг тооцох.</p>
6	Өөрийгөө хөгжүүлэх	<p>УК 6. Насан туршийн суралцахуйн зарчимд үндэслэсэн өөрийн хөгжлийн зураглалыг гаргах, хэрэгжүүлэх, цаг хугацааг зөв удирдах чадвартай байх.</p> <p>УК 7. Нийгмийн болон мэргэжлийн үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн хангахын тулд бие бялдын бэлтгэгдсэн байдлыг түвшинг хангах чадвартай байх.</p>	<p>УК 6.1. Хариуцсан ажлаа амжилттай гүйцэтгэхийн тулд өөрийн нөөц боломжийг (бие хүний, нөхцөл байдлын, цаг хугацааны гэх мэт) мэддэг байх.</p> <p>УК 6.2. Хөдөлмөрийн зах зээлийн шаардлага, карьерийн өсөлтийн үе шат, өөрийн нөөц боломж, арга хэрэгсэл, нөхцлийг тооцож өөрийн ирээдүйн зорилгыг төлөвлөхийн чухлыг ойлгодог байх.</p> <p>УК 6.3. Хөдөлмөрийн зах зээлийн шаардлага, карьерийн өсөлтийн үе шат, өөрийн нөөц боломж, арга хэрэгсэл, нөхцлийг тооцож үйл ажиллагааны зорилгоо хэрэгжүүлдэг байх.</p> <p>УК 6.4. Тавьсан зорилтуудыг шийдвэрлэх болон хүрсэн үр дүнд нөөц, цаг хугацааг ашиглахын үр ашгийг тунгаан боддог, үнэлгээ өгдөг байх.</p> <p>УК 6.5. Шинэ мэдлэг, чадвартай болохын тулд байгаа боломжийг ашиглах, сургалтын үйл ажиллагаандаа сонирхолтой байх.</p> <p>УК 7.1. Нийгмийн болон мэргэжлийн үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн хангахын тулд бие бялдын бэлтгэгдсэн байдлыг түвшинг хангах чадвартай байх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлдэг байх.</p> <p>УК 7.2. Мэргэжлийн тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод, гадаад нөхцлийг тооцож эрүүл мэндээ хамгаалсан технологийг ухамсартайгаар сонгох соёлыг хэвшүүлэх.</p>

7	Амьдрал үйл ажиллагааны аюулгүй байдал	УК 8. Онцгой байдлын нөхцөл үүссэн үед амьдрал үйл ажиллагааны аюулгүй нөхцлийг бий болгох, хангах чадвартай байх.	УК 8.1. Ажлын байрны аюулгүй, таатай нөхцлийг хангадаг байх. УК 8.2. Ажлын байрандаа аюулгүй байдлын техникийг зөрчсөнтэй холбоотой асуудлыг арилгах, илрүүлдэг байх. УК 8.3. Ажлын байранд онцгой нөхцөл байдлыг (байгалийн болон хүний санаатай үйлдлийн шинжтэй) үүсэхээс сэргийлсэн үйлдлийг хийдэг байх. УК 8.4. Онцгой байдлын нөхцөл үүссэн тохиолдолд яаралтай сэргээх, аврах арга хэмжээнд оролцдог байх.
<b>МЭРГЭЖЛИЙН ЕРӨНХИЙ ЧАДАМЖ</b>			
1	Мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн болон ёс зүйн үндэс	Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, боловсролын салбарын эрх зүйн актуудад нийцүүлэн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байх.	1. МЭДДЭГ: ОХУ-ын боловсролын тогтолцооны хөгжлийн тэргүүлэх чиглэл, ОХУ-ын боловсрол, сургалтын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн акт, хуулиуд, хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн асуудлаарх эрх зүйн баримт бичиг, СӨБ, бага, дунд, бүрэн дунд боловсролын улсын стандарт, хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомж, хүүхдийн эрхийн тухай конвенцийг мэддэг байх. 2. ЧАДДАГ: Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, боловсролын салбарын норматив-эрх зүйн баримт бичгийг хэрэглэж чаддаг байх. 3. ЭЗЭМШСЭН: Сурган хүмүүжүүлэх бодит нөхцөл дэх мэргэжлийн ёс зүйн шаардлага, эрх зүй, ёс суртахууны, ёс зүйн хэмжээг дагаж мөрддөг; сургуулийн өмнөх, бага, дунд, бүрэн дунд боловсролын улсын стандартад нийцсэн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг дадалтай байх.
2	Үндсэн болон нэмэлт боловсролын хөтөлбөр боловсруулах	Үндсэн болон нэмэлт боловсролын хөтөлбөр боловсруулахад оролцох, мөн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг (тэр дундаа мэдээлэл, харилцаа, холбооны технологийг ашиглахтай холбоотой хэсэг) боловсруулах	1. МЭДДЭГ: Нийгэм, бие хүний амьдрал дахь боловсролын үүрэг, эзлэх байр, боловсролын тогтолцооны үйл ажиллагаа, бий болдог зарчим, зүй тогтол, онол, түүх; сурган хүмүүжүүлэх орчин үеийн технологийг хэрэглээ, төрөл, үйл ажиллагааны чиг хандлагын үндсэн зарчим, багшлах арга зүйн үндэс, мэдээллийн харилцаа, холбооны салбарын боловсролын үр дүнд хүрэх арга замыг мэддэг байх. 2. ЧАДДАГ: Боловсролын бодит болон виртуал орчинд үндсэн болон нэмэлт боловсролын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэглэх, боловсруулах; боловсролын тогтолцоо, боловсролын технологийг ангилж чаддаг байх. 3. ЭЗЭМШСЭН: Ерөнхий боловсролын цөм хөтөлбөрийн хүрээнд судлагдахууны хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх дадалтай байх; МХХТ-ийн ерөнхий чадамж, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны МХХТ-ийн чадамж, судлагдахууны заах арга зүйн МХХТ-ийн чадамжтай байх.
3	Суралцагчийн хувийн, хамтын сургалт,	Улсын боловсролын стандартын шаардлагад нийцүүлэн суралцагчдын тэр дундаа тусгай хэрэгцээт	1. МЭДДЭГ: Ганцаарчилсан сургалтын технологийн хэв шинж, тусгай хэрэгцээт суралцагчидтай ажиллахад шаардлагатай сэтгэл судлал-сурган хүмүүжүүлэх технологийн хэрэглээний үндсийг мэддэг байх. 2. ЧАДДАГ: Боловсролын тусгай хэрэгцээт суралцагч тохирсон тусламжийг үзүүлэх, сэтгэл судлал-анагаах-сурган хүмүүжүүлэх хүрээний бусад мэргэжилтнүүдтэй харилцан хамтран ажилладаг.



	хүмүүжлийн үйл ажиллагаа	суралцагчдын ганцаарчилсан болон хамтын сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай байх.	3. ЭЗЭМШСЭН: Боловсролын тусгай хэрэгцээт (аутизм, анхаарал дутмагшлын болон хэт хөдөлгөөнтөх эмгэг г.м.) хүүхдийг илрүүлэх анхан шатны аргыг эзэмшсэн, тэдэнд тохирох тусламжийг үзүүлэх дадалтай байх.
4	Хүмүүжил, сургалтын орчныг бүрдүүлэх	Үндэстний суурь үнэт зүйлд үндэслэн суралцагчийн оюуны, ёс суртахууны хүмүүжил олгох чадвартай байх.	1. МЭДДЭГ: Суралцагчийн оюуны, ёс суртахууны хүмүүжлийн үндсийг мэддэг байх. 2. ЧАДДАГ: Суралцагчийн оюуны, ёс суртахууны хүмүүжлийн ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нийгэм-соёлын нөхцлийг харгалздаг байх. 3. ЭЗЭМШСЭН: Суралцагчийн оюуны, ёс суртахууны хүмүүжлийн ажлын шаардлагад нийцүүлэн тэднийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх аргыг эзэмшсэн байх.
5	Боловсролын үр дүнгийн хяналт, үнэлгээ	Сургалтын явцад тулгарах хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, засах залруулах, суралцагчдын боловсрол, сургалтын үр дүнг хянах, үнэлэх чадвартай байх.	1. МЭДДЭГ: Амжилтгүй суралцсан суралцагчдын хоцрогдлыг арилгах, засах сайжруулах ажлыг хэрэгжүүлэх тусгай арга, технологи, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх оношилгооны үндсэн мэддэг байх. 2. ЧАДДАГ: Амжилтгүй суралцсан суралцагчдад сурган хүмүүжүүлэх зүйн оношилгоог хийдэг, суралцагчийн хөгжлийн ахиц, түвшний үзүүлэлтийг үнэлэх, оношлох арга, арга хэрэгслийг хэрэглэдэг байх. 3. ЭЗЭМШСЭН: Амжилтгүй суралцсан суралцагчидтай ажиллах засах, сайжруулах ажлын аргыг хэрэглэх дадалтай, судлагдахуун хоорондын чадамжийн хөгжүүлэх, боловсрол, сургалтын үр дүнг хянах, үнэлэх аргыг эзэмшсэн байх.
6	Мэргэжлийн үйл ажиллагаан дахь сэтгэл судлал-СХУ-ны технологи	Сургалт, хүмүүжил, хөгжүүлэх үйл ажиллагааг боловсролын онцгой хэрэгцээт суралцагчдад ганцаарчилан явуулахад шаардлагатай мэргэжлийн үйл ажиллагааны сэтгэл судлал-СХ зүйн технологийг ашиглах чадвартай байх.	1. МЭДДЭГ: Ганцаарчилсан, тусгай сургалтыг тооцож сургалтын үйл ажиллагааны сэтгэл судлал-СХ зүйн үндэс, ганцаарчилсан сургалт, хүмүүжлийн ажлын сэтгэл судлал-СХ зүйн технологи, суралцагчийн хөгжлийн үе шат, хямрал үеийн сэтгэл зүйн зүй тогтол, бие хүний мөн чанарыг илрүүлэх, хөгжлийн зүй тогтлын талаар мэддэг байх. 2. ЧАДДАГ: Суралцагчийн бие хүний сэтгэл судлал-СХ зүйн тодорхойлолтыг (сэтгэл зүйн хөрөг) гаргах, сургалт, хүмүүжлийн ганцаарчилсан хэлбэрийн сэтгэл судлал-СХ зүйн технологийг хэрэглэдэг, сургалт-хүмүүжлийн ажлын төлөвлөхдөө суралцагчдын хүйсийн онцлогийн талаарх мэддэг зүйлээ ашиглаж чаддаг байх. 3. ЭЗЭМШСЭН: Хүмүүжлийн ганцаарчилсан арга зүйг хэрэгжүүлэхдээ суралцагчдын хүйсийн онцлогийг тооцдог байх; мэргэжлийн үйл ажиллагаандаа ганцаарчилсан сургалт, хүмүүжлийн (тусгай хэрэгцээт суралцагчдын) ажлыг явуулахдаа сэтгэл судлал-СХ зүйн технологийг ашиглах; хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг хууль ёсны асран хамгаалагчтай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх; суралцагчдын нас, сэтгэл зүй, бие хүний онцлогийг тооцож хувь хүний хөгжилд чиглэсэн боловсрол, сургалтын хөгжлийн хөтөлбөр, зураглалыг боловсруулах, хэрэгжүүлэх дадалтай байх.

7	Боловсрол, сургалтын үйл ажиллагааны оролцогч талуудтай хамтран ажиллах	Боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бусад оролцогч талуудтай харилцан хамтран ажиллах чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Хүүхдийн хөгжлийн үе шат, хямралын сэтгэл зүйн мөн чанар, бие хүний онцлог чанарыг илрүүлэх, хөгжлийн зүй тогтлыг мэддэг байх; эцэг эхийн төлөөлөлтэй үр ашигтай хамтран ажиллахад хэрэгтэй гэр бүлийн харилцааны үндсэн зүй тогтлыг мэддэг байх; бага насны болон өсвөр насныхны хөгжлийн зүй тогтол, нийгэм-сэтгэл зүйн онцлог, түүний төлөвшлийн зүй тогтлыг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Суралцагч хоорондын болон суралцагчид, бусад багш нартай үр дүнтэйгээр хамтран ажиллах.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: сэтгэл судлал-анагаах-сурган хүмүүжүүлэх мэргэжилтнүүдийн хүрээнд бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах дадалтай байх; суралцагчдын зан байдал, бие хүний тулгамдсан асуудлыг тэдний хөгжлийн онцлогтой холбон ажиглах, илрүүлэх дадалтай байх.</p>
8	Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс	Шинжлэх ухааны тусгай мэдлэгийн үндсэн дээр сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Нийгэм, бие хүний амьдралд боловсролын гүйцэтгэх үүрэг, байр суурь, боловсролын тогтолцооны үйлчлэл, бий болсон зарчим, зүй тогтол, онол, түүхийн асуудлыг нийгэм, хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухаан, оюун-ёс суртахууны хүмүүжлийн хүрээнд мэддэг, ойлгодог байх.</p> <p>2. ЧАДДАГ: Хүмүүжлийн ажлын орчин үеийн арга хэлбэрийг хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаан хэрэгжүүлж чаддаг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Лабораторийн туршилт, Талбайн туршилт, төсөлт ажил гэх мэт сургалтын арга, хэлбэрүүдийг эзэмшсэн байх; тоглоомын, сургалт-судалгаа, уран сайхан-бүтээлч, соёл-амралтын зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагааг тухайн сургалтын байгууллагынхаа нөөц боломж, тухайн орон нутгийн түүх-соёлын өөрийн өвөрмөц онцлог, оршин суугаа газар нутгийн онцлогийг харгалзан зохион байгуулдаг байх.</p>
<b>МЭРГЭШЛИЙН ЧАДАМЖ</b>			
1	Мэргэжлийн үйл ажиллагааны зорилтын хэлбэр: сурган хүмүүжүүлэх	Суралцагчдын бие хүний хөгжил болон сургалтын үр дүнд хүрэхэд чиглэсэн сургалтын цогц, олон талт арга хэмжээг хөгжүүлэх, төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай байх	<p>1. МЭДДЭГ: Суралцагчийн бие хүний хөгжлийн зүй тогтол, судлагдахуун хоорондын боловсролын үр дүн, бие хүний болон сургалтын үр дүн, сургалтын олон талт үйл зэрэг ойлголтуудын агуулгыг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Танхимын болон хичээлээс гадуурх үйл ажиллагаан дахь сургалтын олон талт үйлийн хөгжил, төлөвшлийн сэтгэл судлал-сурганы арга хэрэгслийг хэрэглэж чаддаг байх; судлагдахуун хоорондын сургалтын үр дүнд хүрэх боломж, нөөцийн үүднээс сургалтын нөхцөл байдалд шинжилгээ хийж чаддаг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Сургалтын олон талт үйлийг хөгжүүлэх, төлөвшүүлэх арга замыг эзэмшсэн байх.</p>

		<p>Бага боловсролын бүх үе шатанд (1-р ангийнхнийг сургуулийн амьдралд дасан зохицож эхлэхээс эхлээд бага боловсролын суурь боловсролын түвшинд элсэхэд нь бэлтгэх хүртэлх) суралцагчдын хөгжүүлэх нийгмийн нөхцөл байдлын онцлогийг тооцон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай байх.</p>	<p>1. МЭДДЭГ: Орчин үеийн боловсролын тогтолцооны хувьд маш чухал бага ангийн хүүхдийн сэтгэцийн хөгжлийн талаарх онолуулыг мэддэг байх; сургуулийн амьдралын янз бүрийн үе шатанд бага ангийнхныг сэтгэл зүйн болоод сурган хүмүүжүүлэх талаас нь дэмжих үндсэн арга, аргачлалыг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Бага боловсролын түвшинд суралцагчдын хөгжлийн нийгмийн нөхцөл байдлын онцлогт шинжилгээ хийхдээ хүүхдийн сэтгэцийн хөгжлийн талаарх онолуудыг хэрэглэж чаддаг байх; сургуулийн амьдралын янз бүрийн үе шатанд бага ангийнхныг сэтгэл зүйн болоод сурган хүмүүжүүлэх талаас нь дэмжлэг үзүүлдэг байх, бусад багш, ажилтан, эцэг эхтэй хамтран ажилладаг байх; бага боловсролын сургалтын үйл ажиллагааг туршлагатай багш, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчидтэй хамтран төлөвлөж чаддаг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Бага боловсролын түвшин бүрт суралцагчдын сэтгэцийн хөгжлийн нас зүйн онцлогтой оношлогооны өгөгдлийг харьцуулдаг байх; суралцагчдын хөгжлийн нийгмийн нөхцөл байдлын онцлогийг тооцон сургалтын үйл ажиллагааг төлөвлөдөг байх;</p>
		<p>Сургалтын явц дахь гарч буй бэрхшээлд үндэслэн суралцагчдын (тэр дундаа боловсролын тусгай хэрэгцээт) сургалт, хүмүүжлийн ажлыг ганцаарчилж, хүүхэд бүрт тохирсон байдлаар зохион байгуулах чадвартай байх.</p>	<p>1. МЭДДЭГ:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн нийгмийн болоод сурч боловсрох баталгааны талаарх үндсэн суурь баримт бичиг</li> <li>- Бага ангийн сурагчдын хөгжил, сургалт, хүмүүжлийн үндсэн суурь, орчин үеийн онолууд</li> <li>- Боловсролын тусгай хэрэгцээт суралцагчдын хөгжил, сургалт, хүмүүжлийн үндсэн суурь, орчин үеийн онолууд</li> <li>- Хүүхдийн сурах хувийн онцлог хэрэгцээг тооцон хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах онолууд</li> </ul> <p>2. ЧАДДАГ:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Боловсролын харилцан хамаарлын нөхцөл байдалд шинжилгээ хийхийн тулд хүүхдүүдийн нийгмийн болоод сурч боловсрох баталгааны талаарх үндсэн, суурь баримт бичгүүдийг хэрэглэдэг байх,</li> <li>- Сургалтын ажилтан, менежер, сэтгэл зүйч, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажилладаг байх,</li> <li>- Хүүхдийн сурах хувийн онцлог хэрэгцээг тооцон сургалт, хүмүүжлийн алдартай онолын үндсэн дээр амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөдөг, хэрэгжүүлдэг байх</li> </ul>

		<p>3. ЭЗЭМШСЭН:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн нийгмийн болоод сурч боловсрох баталгааны талаарх үндсэн, суурь баримт бичгүүдийг хэрэглэх зарчим, нэр томъёог мэддэг байх,</li> <li>- Хүүхдийн хүйс, нас, сэтгэл зүйн онцлогийг тооцон сургалтын үйл ажиллагааны үр дүнд хянасан, үнэлсэн, оношилсон өгөгдөл, мэдээллийн сангаас сургалтын үйл ажиллагааг засаж сайжруулдаг дадалтай байх,</li> <li>- Бага ангийн хүүхдүүдийн сэтгэцийн хувийн хөгжлийн харилцан адилгүй байдлыг тооцон сургалтын үр дүнг хяналт шинжилгээний өгөгдөлд үндэслэн тусгай хэрэгцээт суралцагчдын сургалтын үйл ажиллагааг сайжруулах дадалтай байх,</li> </ul>
	Бага боловсролын суралцагчдын оюуны ухааны хөгжлийг хангах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Бага боловсролын түвшинд суралцагчийн оюун ухааны хөгжлийн үндсийг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Бага боловсролын түвшинд суралцагчийн логик, эргэцүүлэн дүгнэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх стандарт арга, аргачлалыг хэрэглэх нөхцлийг үнэлдэг, мэддэг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Бага боловсролын түвшинд суралцагчийн оюун ухааны хөгжлийн стандарт арга, аргачлалыг хэрэглэх арга зүйн эзэмшсэн байх.</p>
	Бага боловсролын түвшинд суралцагчийн гоо зүйн хөгжлийг хангах чиглэлээр сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Бага боловсролын түвшинд суралцагчийн гоо зүйн хөгжлийн үндсийг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Бага боловсролын түвшинд суралцагчийн урлагтай харилцах харилцаа, гоо зүйн мэдрэмж, сэтгэл хөдлөл, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх стандарт аргуудыг хэрэглэх нөхцлийг үнэлж чаддаг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Бага боловсролын түвшинд суралцагчийн гоо зүйн хөгжлийг хангах стандарт аргуудыг хэрэглэх аргыг эзэмшсэн байх.</p>
	Бага боловсролын түвшинд суралцагчийн зан үйлээ зохицуулах чадварыг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Бага боловсролын түвшинд суралцагчийн үйл ажиллагааныхаа болон зан байдлын зохицуулалтыг хөгжүүлэх үндсийг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Бага боловсролын түвшинд суралцагчийн өөрийн зан байдлын, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, өөртөө хяналт тавих, өөртөө зорилго тавих, авьяасыг хөгжүүлэх стандарт аргуудыг хэрэглэх нөхцлийг үнэлж чаддаг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Бага боловсролын түвшинд суралцагчийн зан байдал, үйл ажиллагаагаа зохицуулах стандарт аргуудыг хэрэглэх арга зүйг эзэмшсэн байх.</p>

2	Мэргэжлийн үйл ажиллагааны зорилт: төслийн	Суралцагчийн хөгжил, хүмүүжлийн хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх хамт олны ажилд оролцох чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Бие хүний болон мэргэжлийн өөрийн хөгжлийг хангах нөхцөл, арга, хэрэгсэл, мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээний үндэс, боловсролын хөтөлбөр, тогтолцоог дизайнчлах технологийг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Бие хүний, мэргэжлийн хөгжлийг хангах хөтөлбөрийг боловсруулах, боловсролын хөтөлбөрийг дизайнчлах чадвартай байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Бие хүний, мэргэжлийн өөрийн хөгжлийн хүрээг дизайнчлах, боловсруулах дадалтай байх; боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд сэтгэл судлал-сурган зүйн хөтөлбөрийг боловсруулах чиг хандлага, загварт шинжилгээ хийх чадвартай байх.</p>
		Бага боловсролын түвшинд хууль ёсны асран хамгаалагчтай зөвлөлдөх чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Бага боловсролын түвшний суралцагчийн асран хамгаалагчид зөвлөн туслах үйл ажиллагааны үндсийг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Боловсролын стандартын хүрээнд сургалт, хүмүүжлийн хэвшмэл асуудлуудаар бага боловсролын суралцагчдын асран хамгаалагчид зөвлөх тодорхой аргуудын хэрэглэгддэг байдлыг үнэлж чаддаг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Бага боловсролын түвшинд суралцагчийн асран хамгаалагчид зөвлөн туслах аргыг эзэмшсэн байх.</p>
		Бага боловсролын түвшинд сургалтын хөгжүүлэх орчныг бий болгох үйл ажиллагаанд оролцдог байх.	<p>1. МЭДДЭГ: Бага боловсролын сургалтын хөгжүүлэх орчны үндсийг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Боловсролын технологийг хөгжүүлэлтийг ашиглахад үндэслэн бага боловсролын суралцагчдыг хөгжүүлэх сургалтын орчны бодит жишээнд шинжилгээ хийж чаддаг байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Бага боловсролын хөгжүүлэх сургалтын орчны бий болгох стандарт арга, сэтгэл судлал-сурган хүмүүжүүлэх зүйн дэмжлэгийг хэрэглэх аргыг эзэмшсэн байх.</p>
3	Мэргэжлийн үйл ажиллагааны зорилт: дагалдах	Суралцагчдын бие хүний болон хичээл хоорондын сургалтын үр дүн, хөгжлийн түвшний оношилгоо хийх чадвартай байх.	<p>1. МЭДДЭГ: Суралцагчдын бие хүний болон хичээл хоорондын сургалтын үр дүнгийн үнэлгээний орчин үеийн туршлагын сэтгэл зүйн үндэс; суралцагчдын хөгжлийн сэтгэл зүй-сурган хүмүүжүүлэх талаас оношлох арга, аргачлал, сурлагын амжилтыг үнэлэх орчин үеийн арга, аргачлалыг мэддэг байх.</p> <p>2. ЧАДДАГ: Орчин үеийн үнэлгээ, хэмжил зүйн материалуудыг ашиглан суралцагчийн бие хүний болоод судлагдахуун хоорондын үр дүнг үнэлэх үнэлгээ явуулах чадвартай байх.</p> <p>3. ЭЗЭМШСЭН: Авсан үр дүнг цуглуулах, боловсруулах, шинжилгээ хийх аргачлал, сэтгэл судлал-сурганы оношлогооны арга, аргачлалыг эзэмшсэн байх.</p>

## ***Бүгд Найрамдах Хятад Ард Улс***

БНХАУ-ын “Зүүн хойд багшийн их сургууль”-ийн бага боловсролын багш мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тухайд багш мэргэжлээр төгсөгчдөд нийтлэг шаардлага тавьдгаас гадна ямар мэдлэг, чадвартай байхыг тодорхойлж өгсөн байдаг байна. “Зүүн хойд багшийн их сургууль”-ийн боловсролын зорилго нь намын боловсролын бодлогыг бүрэн хэрэгжүүлж, оюутан залуусыг мэдлэгтэй, чадварлаг, хариуцлагатай бие даан суралцагч болгон төлөвшүүлэх, боловсролын үйл хэрэгт үнэнч төлөвшүүлэх, орчин үеийн боловсролын үзэл баримтлалтай, боловсролын онолын гүн гүнзгий мэдлэгтэй, боловсролын алсын хараатай, хүчирхэг боловсролтой, чанартай, мэргэжлийн өндөр түвшинд төлөвшүүлэх. 21-р зууны хэрэгцээ шаардлагад нийцсэн багшлах, судалгаа шинжилгээ хийх, удирдах чадвартай, шинэлэг сэтгэлгээтэй бага ангийн багш нарыг бэлтгэхэд оршдон байна.

Төгсөгчдөд тавигддаг нийтлэг шаардлагад дараах шаардлагууд орно. Үүнд:

- Боловсролын шинжлэх ухаан болон холбогдох салбаруудын суурь мэдлэг, суурь онол, үндсэн ур чадварыг системтэй эзэмшсэн байх;
- Боловсролын судалгааны үндсэн аргуудыг системтэйгээр эзэмшиж, боловсролын асуудлыг илрүүлэх, шинжлэх, шийдвэрлэх чадвартай, шүүмжлэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, инноваци, бизнес эрхлэх мэдрэмжтэй байх;
- Бага боловсролд шаардлагатай шинэлэг сэтгэлгээ, дадлага хийх чадварыг төлөвшүүлэх, олон салбарыг нэгтгэх авъяас чадварыг төлөвшүүлэх;
- Мэдээллийн өндөр мэдлэгтэй байх, орчин үеийн мэдээллийн технологийг боловсрол, заах үйл ажиллагаанд ашиглах чадвартай байх;
- Хятадын бүх шатны боловсролын бодлого, дүрэм журмыг сайн мэддэг;
- Бие даан суралцах, насан туршдаа суралцах, өөрийгөө хөгжүүлэх мэдлэг, чадвартай байх.

Харин бага боловсролын багш мэргэжлээр төгсөгчид дараах үндсэн мэдлэг чадвартай байна гэжээ. Үүнд:

1. Бага ангийн боловсролд үнэнч, сурагчдаа хайртай, багшийн мэргэжлийн ёс зүйтэй, бодитой, шинийг эрэлхийлэгч байх;
2. Тухайн мэргэжлийн анхан шатны мэдлэг, чадвартай байх; Системчилсэн боловсролын онолыг эзэмшиж, хүмүүжлийн хөгжлийн хил хязгаар, динамикийг ойлгох;
3. Салбарын үндсэн суурь мэдлэг, үндсэн онол, үндсэн ур чадварыг эзэмшсэн байх, салбаруудын хил хязгаар, хөгжлийн чиг хандлагыг ойлгох, шинжлэх ухааны сэтгэлгээ, шинийг эрэлхийлэх сэтгэлгээтэй байх;
4. Цаашид суралцах, хөгжих боломж бүхий тухайн салбарын үндсэн мэдлэг, үндсэн онол, үндсэн ур чадварыг системтэйгээр эзэмшүүлэх;
5. Хүмүүнлэг, нийгэм, байгалийн шинжлэх ухааны өргөн хүрээний мэдлэгийг эзэмшиж, цогц мэдлэгийн бүтцийг бүрдүүлдэг, олон салбарыг хамарсан багшлах чадвартай байх;
6. Бага боловсролын мэдлэгийг хүчтэй дамжуулах, суурь бичиг үсэгтэй байх;
7. Бага боловсролын судалгаа шинжилгээний тодорхой чадвартай, бага боловсролыг удирдах чадвартай байхаас гадна өөрийгөө хөгжүүлэх чадвартай байх;

8. Уран сайхны бясалгалын иж бүрэн практик үйл ажиллагааны чадвартай байх;
9. Намын үндсэн зарчмыг баримталж, эх орноо хайрлаж, боловсролд хайртай байх;
10. Компьютерийн ашиглалтын арга техникийг эзэмшсэн байх, янз бүрийн арга хэрэгсэл ашиглан мэдээллийг олж авах, тайлбарлах, үнэлэх, удирдах, ашиглах чадвартай байх;
11. Энэ чиглэлээр гадаад хэл эзэмшиж, гадаад ном, тогтмол хэвлэл унших чадвартай байх;
12. Илэрхийлэх, зохион байгуулах чадвар сайтай байх;
13. Гүн гүнзгий соёлын өв, гоо зүй, сэтгэлзүйн сайн чанар, эрүүл бие галбиртай байна.

### **Шинэ Зеланд Улс**

Шинэ Зеланд улсын Аукландын Их Сургууль нь бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгээ тодорхойлохдоо мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн туршлага, мэргэжлийн үэнт зүйлс, хамтын ажиллагаа, түншлэл гэсэн 3 айгаас бүрдсэн 7 стандарттай байхаар тогтоожээ. Аукландын Их Сургуулийн сургалтын хөтөлбөрийн үр дүнг дэлгэрнгүйгээр доор хүснэгтэд нэгтгэн харуулав.

*Хүснэгт 17. Шинэ Зеланд улсын Аукландын Их Сургуулийн сургалтын*

*хөтөлбөрийн хүрэх үр дүн*

<b>Стандартууд</b>	<b>Гүйцэтгэлийн түвшин</b>
<b>Мэргэжлийн мэдлэг</b>	
Стандарт 1: Төгсөн гарч буй багш нь юу зааж буйгаа мэддэг байх	А) Суралцагчид болон тэдний хөтөлбөрийн сургалтын агуулгад тохирсон мэдлэгтэй байх; Б) суралцагчид болон тэдний хөтөлбөрийн сургалтын агуулгад тохирсон сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэгтэй байх; В) Шинэ Зеландын Аотеароагийн холбогдох сургалтын баримт бичгийн талаар мэдлэгтэй байх; Г) Сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд нэмэлт хэлийн хувиар англи хэлийг судлах асуудлыг дэмжих агуулгын болон сурган хүмүүжүүлэх мэдлэгтэй байх;
Стандарт 2: Төгсөн гарч буй багш нар суралцагч, тэдний хэрхэн суралцаж байгааг мэддэг байх	А) Сурган хүмүүжүүлэх ухаан, хүний хөгжил, суралцахуйн талаарх олон төрлийн холбогдох онол, судалгааны талаар мэдлэгтэй байх; Б) Үнэлгээ (assessment), үнэлгээтэй (evaluation) холбогдох онол, зарчим, зорилгын талаар мэдлэгтэй байх; В) Ялгаатай суралцагчдын мета танин мэдэхүйн стратегийг хэрхэн хөгжүүлэх талаар мэддэг байх; Г) Суралцагчид болон сургалтын нөхцөл байдалд тохирсон сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэрхэн сонгох талаар мэддэг байх;
Стандарт 3: Төгсөн гарч буй багш нар нөхцөл байдлын хүчин зүйлс багшлахуй ба суралцахуйд хэрхэн нөлөөлдөгийг ойлгодог байх	А) Багш, суралцагчдад хувь хүн, нийгэм, соёлын хүчин зүйлс нөлөөлж болох цогц нөлөөллийн талаар ойлгодог байх; Б) Шинэ Зеландын Аотеароагийн хоёр соёлын хүрээнд үр дүнтэй ажиллахын тулд тиканга болон те рео Маоригийн талаар мэдлэгтэй байх; В) Шинэ Зеландын Аотеароа улсын хоёр соёл, олон соёлт, нийгэм, улс төр, эдийн засаг, түүхэн нөхцөл байдлын хүрээнд боловсролын талаар ойлголттой байх;
<b>Мэргэжлийн туршлага</b>	

Стандарт 4: Төгсөж буй багш нар сургалтын аюулгүй орчин, чанартай багшлахуйг төлөвлөхдөө мэргэжлийн мэдлэгээ ашигладаг байх	<p>А) Сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, үнэлэх, багшлахуйдаа агуулгын мэдлэг, сурган хүмүүжүүлэх мэдлэгт тулгуурлана;</p> <p>Б) Суралцагчдын амжилтад нөлөөлж, дэмжихийн тулд олон төрлийн сургалтын туршлагыг дэс дараатай ашиглах;</p> <p>В) Суралцагчдын олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, үнэлдэг байх, тэдний хүлээлтэд нийцүүлдэг байх</p> <p>Г) Аман болон бичгийн хэл (маори ба/эсвэл англи хэл), тоо бодох чадвар, МХХТ-ийн мэдлэгийг мэргэжлийн үүрэгтээ нийцүүлэн харуулах;</p> <p>Д) Те рео Маори ба соёлын уламжлалыг практик дээрээ зүй ёсоор ашиглах;</p> <p>Е) Суралцагчдын бие махбодийн болон сэтгэл санааны аюулгүй байдлыг дэмжих, хөгжүүлэх стратеги, тууштай байдлаа харуулах</p>
Стандарт 5: Төгсөх ангийн багш нар суралцахыг дэмжихийн тулд нотолгоог ашигладаг байх	<p>А) өөрсдийн практикийг эргэцүүлэн бодох, сайжруулахын тулд нотлох баримтыг системтэй, шүүмжлэлтэй харьцах</p> <p>Б) үнэлгээний мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, сургалтыг сайжруулах, төлөвлөлтийг мэдээлэх зорилгоор ашиглах</p> <p>В) үнэлгээний мэдээллийг суралцагчид, тэдний эцэг эх/асран хамгаалагчид болон ажилтнуудад хэрхэн зөв хүргэх талаар мэдэх</p>
<b>Мэргэжлийн үнэт зүйл, хамтын ажиллагаа, түншлэл</b>	
Стандарт 6: Төгсөж буй багш нар суралцагч болон суралцахуйн хүрээний гишүүдтэй эерэг харилцаа, түншлэлийг хөгжүүлэх	<p>А) Ялгаатай үнэ цэнэ, итгэл үнэмшил нь суралцагчид болон тэдний суралцахуйд хэрхэн нөлөөлж болохыг хүлээн зөвшөөрөх</p> <p>Б) Хамт олон, эцэг эх /асран хамгаалагч, гэр бүл/ ванау болон олон нийттэй үр дүнтэй ажиллах мэдлэг, байр суурьтай байх</p> <p>В) Суралцагчидтайгаа үр дүнтэй харилцааг бий болгох</p> <p>Г) Олон янзын суралцагчдыг үр дүнтэй оролцуулах суралцахуйн соёлыг дэмжих</p> <p>Д) Тэ рео Маори ме нга тиканга-а-ивиг хүндэлдэг байдлаа практик дээрээ харуулах</p>
Стандарт 7: Төгсөгч багш нар мэргэжлийнхээ төлөө тууштай ажилладаг байх	<p>А) Боловсролын зөвлөлийн Ёс зүйн дүрмийг / Нга Тиканга Мататикаг дагаж мөрдөх</p> <p>Б) Багшийн ёс зүй, мэргэжлийн болон эрх зүйн хариуцлагын талаар мэдлэг, ойлголттой байх</p> <p>В) Суралцагчдын сурч боловсрох, сайн сайхны төлөө хариуцлагатай байдаг хүмүүстэй хамтран ажиллах</p> <p>Г) Суралцахуйн болон багшлахуйн мэргэжлийн гүн ухааны хандлагыг бий болгох, төлөвшүүлэх чадвартай байх</p>

## **Австрали Улс**

Австрали Улсын Ньюкаслын Их Сургууль нь бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгээ тодорхойлохдоо дараах төгсөгчдийн чадамжуудыг тогтоожээ. Үүнд:

1. Бие даан насан туршдаа суралцах үндэс болох нэг буюу хэд хэдэн салбар дахь үндсэн зарчим, үзэл баримтлалыг гүнзгийрүүлсэн өргөн, уялдаа холбоотой мэдлэг эзэмших;
2. Боловсролын онол, практикийг оновчтой эрэл хайгуул хийдэг ухаалаг судлаач болох;
3. Боловсролын талаар олон нийтийн хэлэлцүүлэгт бүтээлч үүрэг гүйцэтгэдэг шинэлэг удирдагч болох;
4. Мэдлэгийг шүүмжлэх, дүн шинжилгээ хийх, нэгтгэх, танин мэдэхүйн ур чадвартай болох;



5. Тодорхой чиглэлээр талаар гүнзгий мэдлэг, ойлголттой болох замаар танин мэдэхүйн болон техникийн ур чадвартай болох;
6. Суралцагчийн бие даасан байдалд тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэхэд нь эргэцүүлэн бодох, шүүн тунгаах танин мэдэхүйн болон бүтээлч ур чадвартай;
7. Мэдлэг, санаагаа тодорхой, уялдаатай, бие даасан байдлаар илэрхийлэх харилцааны ур чадвар;
8. Төлөвлөлт, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад санаачилга, шүүлттэй байх мэдлэг, ур чадвараа мэргэжлийн практикт ашиглах чадвараа харуулдаг байх;
9. Мэдлэг, ур чадвараа янз бүрийн нөхцөлд дасан зохицох мэдлэг, ур чадвараа харуулсан байх;
10. Мэдлэг, ур чадвараа сургалт, мэргэжлийн үйл ажиллагаандаа хариуцлагатай, өргөн хүрээний хүрээнд бусадтай хамтран ажиллах чадвараа харуулдаг;
11. Мэргэжлийн, ёс зүйтэй, үр дүнтэй ажилладаг урам зоригтой багш болох.

### ***Бүгд Найрамдах Финлянд Улс***

Бүгд Найрамдах Финлянд Улсын Оулугийн Их Сургуулийн бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн нь мэдлэг, ажлын арга, барил түүний хэрэглэх чадвар, хариуцлагатай байдал, манлайлал, энтрепренершип чадвар, үнэлгээ, насан туршийн боловсролын гол ур чадвар гэсэн чадамжуудтай төгсөгч бэлтгэхэд чиглэсэн байна.

*Хүснэгт 18. Финлянд Улсын Оулугийн Их Сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн*

<b>Бүрэлдэхүүн</b>	<b>Хүрэх үр дүн</b>
Мэдлэг	<ul style="list-style-type: none"> <li>- Оюутан өөрийн шинжлэх ухааны салбарын үндсэн ойлголт, арга зүй, шинжлэх ухааны уламжлал, онол, судалгааны үр дүн, арга зүйг мэддэг.</li> <li>- Оюутан өсөлт, хөгжил, сурган хүмүүжүүлэх, суралцах чиглэлээр хийсэн судалгаагаар олж авсан мэдлэгээ хэрхэн шинжлэх, энэ мэдлэгээ янз бүрийн орчинд хэрхэн ашиглах талаар мэддэг.</li> <li>- Оюутан тэгш хамруулах боловсролын зарчмуудыг мэддэг.</li> </ul>
Ажлын арга, барил түүний хэрэглэх чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Оюутан нь бага хэмжээний судалгааг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, ажлын амьдралд шаардлагатай тайланг гаргах, мэдлэгийн янз бүрийн эх сурвалжийн найдвартай байдлыг үнэлэх чадвартай.</li> <li>- Оюутан нь сургалтын хөтөлбөр гэх мэт боловсролын төлөвлөлтийн механизм, баримт бичгүүдийг мэддэг, тэдгээрийг хэрхэн шинжлэх, утга учиртай хэрэгжүүлэх талаар мэддэг.</li> <li>- Оюутан өсөлт, суралцахтай холбоотой хувь хүний хэрэгцээг хэрхэн харгалзан үзэх, түүнийг өөрийн үйл ажиллагаанд хэрхэн тусгах талаар мэддэг.</li> <li>- Оюутан өөрийн үйл ажиллагааг үнэлж, боловсролын салбарт янз бүрийн чиг үүрэгт өрөвдөх сэтгэлтэй, ёс зүйтэй, хамтран ажиллах, сурган хүмүүжүүлэх тактиктэй ажиллах чадвартай.</li> <li>- Оюутан нь боловсролын нийгмийн болон дэлхийн холбоосыг хэрхэн тайлбарлахыг мэддэг бөгөөд сурган хүмүүжүүлэх шинжээчийн хувьд нийгмийн хариуцлагаа тодорхойлдог.</li> <li>- Оюутан хүний харилцан үйлчлэл, түүний сэтгэл зүйн үндсийг тэгш эрх, хүний эрх, халамжийн үүднээс хэрхэн үнэлж, дүн шинжилгээ хийхээ мэддэг.</li> </ul>

Хариуцлагатай байдал, Манлайлал, Энтрепренершип чадвар	- Оюутан боловсролын салбар дахь хариуцлагын янз бүрийн чиглэлийг хэрхэн тодорхойлж, тодорхойлох, ажлын амьдралын янз бүрийн салбарт өөрийн байр суурь, сонирхлыг хэрхэн үнэлэх талаар мэддэг. - Оюутан нь олон мэргэжлийн ажлын хамт олны нэг хэсэг болгон бие даан, хариуцлагатай байдлаар өөрийн чиглэлээр мэргэшсэн болон удирдлагын чиг үүргийг гүйцэтгэх суурь мэдлэгтэй.
Үнэлгээ	Оюутан насан туршийн боловсролын тасралтгүй байдлыг харгалзан өөрийн хөгжлийг үнэлж, бие даасан бүлэг, хүмүүсийн хөгжлийг хариуцах чадвартай.
Насан туршийн боловсролын гол үр чадвар	- Оюутан өөрийн шинжлэх ухааны чиглэлээр төрөлх хэл, хоёр дахь үндэсний хэл, нэг гадаад хэлээр амаар болон бичгээр хэлэлцүүлэгт оролцох боломжтой. - Оюутан тасралтгүй суралцах, өөрийн чадамжийг хөгжүүлэх, үнэлэх чадвартай

### **Бүгд Найрамдах Филиппин Улс**

Бүгд Найрамдах Филиппин Улсын Ерөнхийлөгчийн Дээд боловсролын комиссын албанаас 2017 онд 74 дүгээр шийдвэртээ бага боловсролын багшийн бакалаврын хөтөлбөрийн хүрэх үр дүнг тогтоожээ. Төгсөгчдийн хувьд ерөнхий шаардлага нь:

- Сургалтын янз бүрийн чиглэлээр суралцагчдын олон янз байдлын талаар гүнзгий ойлголттой гэдгээ харуулах;
- Олон чиглэлээр сурган хүмүүжүүлэх цогц, ач холбогдол бүхий агуулгын мэдлэгтэйг харуулах;
- Сургалтын үр дүнг хэмжихэд үнэлгээний тохирсон аргуудыг ашиглах;
- Сурах, сургах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд харилцаа, дээд түвшний сэтгэлгээний чадварыг харуулж, технологи, арга хэрэгслүүдийг ашиглах;
- Хувь хүний хувьд, мэргэжлийн түвшинд ч үлгэр жишээ багшийн эерэг чанаруудыг эзэмшсэн байх;
- Хувийн болон мэргэжлийн хөгжлийг тасралтгүй дээшлүүлэх хүсэл эрмэлзлийг харуулах шаардлагатай байна.

Үүнээс гадна бакалаврын сургалтын хөтөлбөрийн үр дүнг хичээл бүрээр тодорхойлсон бөгөөд шалгуур үзүүлэлтийг ч мөн адил тогтоож өгсөн байна. Дараах хүснэгтэд сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнг хичээл бүрээр харуулав.

*Хүснэгт 19. Филиппины бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн*

<b>Бага боловсрол – Бакалавр</b>						
<b>Хичээл</b>	<b>Хөтөлбөрийн хүрэх үр дүн</b>					
	<b>А</b>	<b>Б</b>	<b>В</b>	<b>Г</b>	<b>Д</b>	<b>Е</b>
Суурь онол, ойлголт						
Хүүхэд, өсвөр насны суралцагчид, суралцахуйн зарчим	I	I	I	I	I	I
Багш мэргэжил	I	I	I	I	I	I
Багш ба олон нийт, Сургуулийн соёл ба байгууллагын манлайлал	I	I	I	I	I	I
Тусгай ба тэгш хамруулах боловсролын үндэс	I	I	I	I	I	I
Сурган хүмүүжүүлэх арга зүйн агуулгын мэдлэг						
Суралцагч төвтэй багшлахуй, суралцахуйг дэмжих	P	P	P	P	P	P

Суралцахуйн үнэлгээ 1	P	P	P	P	P	P
Суралцахуйн үнэлгээ 2	P	P	P	P	P	P
Багшлахуй ба суралцахуйн арга, технологи 1	P	P	P	P	P	P
Багш болон сургуулийн хөтөлбөр	I	I	I	I	I	I
Багш ба сургуулийн сургалтын хөтөлбөрт бичиг үсгийн шинэ чадварыг бий болгох, хөгжүүлэх	I	I	I	I	I	I
Туршилтын сургалт						
Дадлага судалгаа ба багшлах дадлага	D	D	D	D	P	P
Мэргэшлийн хичээл						
Бага ангид байгалийн ухаан заах (биологи, хими)	D	D	D	P	P	I
Бага ангид байгалийн ухаан заах (физик, дэлхий ба сансар огторгуйн шинжлэх ухаан)	D	D	D	P	P	I
Бага ангид нийгмийн ухаан заах (филиппиний түүх ба засгийн газар)	D	D	D	P	P	I
Бага ангид нийгмийн ухаан заах (соёл, газар зүй)	I	D	D	P	P	I
Бага ангид филиппин хэл заах 1 – филиппин хэлний бүтэц, хэрэглээ	I	D	D	P	I	I
Бага ангид филиппин хэл заах 2 – утга зохиол ба филиппин хэл	I	D	D	P	I	I
Бага анги математик заах	D	D	D	P	I	I
Гэр ахуй, эдийн засгийн боловсрол 1	D	D	D	P	I	I
Гэр ахуй, эдийн засгийн боловсрол 2	D	D	D	P	I	I
Бага ангид хөгжим заах	D	D	D	P	I	I
Бага ангид урлаг заах	D	D	D	P	I	I
Бага ангид утга зохиолоор дамжуулан англи хэл заах	D	D	D	P	I	I
Эх хэлний агуулга ба заах арга зүй	D	D	D	P	I	I
Ёс зүй, зөв зан байдал	D	D	D	P	I	I
Багшлахуй, суралцахуйн арга, технологи 2	P	P	P	P	I	I
Боловсролын судалгаа	I	P	P	P	I	I
Сонгон судлах хичээл						
Олон ангид хичээл заах, мэргэжлийн хичээлд	D	D	D	P	I	I

*Тайлбар: Түлхүүр I – ойлголт, концепц/зарчмуудыг тайлбарласан*

*P – дадлага хийсэн - удирдуулсан*

*D – янз бүрийн орчинд хамгийн бага хяналтын дор харуулсан*

*Хүснэгт 20. Филиппины бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд*

<b>Хүрэх үр дүн</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
А. Судлагдахуун бүрээр суралцагчдын олон янз байдлын талаар гүн гүнзгий ойлголттой байгаагаа харуулах	<ol style="list-style-type: none"> <li>1. Суралцагчдыг оношилж, тэдэнд тохирсон, соёлын ялгаатай байдалтай нь холбоотой сургалтын үйл ажиллагаа явуулж, туршлага эзэмшүүлэх</li> <li>2. Суралцагчдын сурах арга барил, зорилго, соёлд нийцсэн сургалтын материалыг боловсруулж, ашиглах</li> <li>3. Суралцагчдын шүүн тунгаах чадвар болох бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх сургалтын арга, стратегийг сонгох</li> <li>4. Сургалтын янз бүрийн чиглэлийг заахдаа хөгжлийн зохистой үйл ажиллагааг ашиглах</li> <li>5. Сургалтыг үр дүнтэй явуулахын тулд зохистой технологи ашиглах</li> </ol>

	6. Сурах-сургах үйл ажиллагааг төлөвлөхдөө сургалтын талаарх онолуудыг ашиглах
Б. Судлагдахуун бүрийн агуулгын бүх талын, гүн гүнзгий мэдлэгийг харуулах	<ol style="list-style-type: none"> <li>1. Сэдвийн агуулгыг үнэн зөв, тодорхой бөгөөд цогцоор тайлбарлах.</li> <li>2. Одоогийн агуулгыг өмнө үзсэн болон дараа үзэх хичээлтэй уялдуулах.</li> <li>3. Сургалтыг баяжуулахын тулд боловсролын болон тодорхой салбарын сүүлийн үеийн хөгжлийн асуудлыг хамруулж оруулах.</li> <li>4. Тодорхой агуулгад тохирсон заах арга зүй, технологийг ашиглах.</li> <li>5. Тохирсон сургалтыг явуулахын тулд боловсролын асуудал, чи хандлага, туршлагыг орон нутгийн болон дэлхийн хэмжээний агуулгатай харгалзан үзэх.</li> </ol>
В. Сургалтын үр дүнг хэмжихэд үнэлгээний тохирсон аргуудыг ашиглах.	<ol style="list-style-type: none"> <li>1. Бодит үнэлгээ, үнэгээний арга, хэрэгсэл, үнэлгээний хувилбаруудыг боловсруулах.</li> <li>2. Үнэлгээний үр дүнг тайлбарлаж, сурах, сургах үйл ажиллагааг сайжруулахад ашиглах.</li> <li>3. Технологийн тохиромжтой, боломжийн хэрэгслийг ашиглан суралцагчдын гүйцэтгэлийн талаар үнэн зөв, шинэчилсэн бүртгэлийг тогтмол хийх.</li> <li>4. Эцэг эх, асран хамгаалагч, холбогдох хүмүүст үнэлгээний үр дүнгийн талаарх мэдээллийг цаг тухайд нь, тогтмол өгч байх.</li> </ol>
Г. Сурах, сургах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд харилцаа, дээд түвшний сэтгэлгээний чадварыг харуулж, технологи, арга хэрэгслүүдийг ашиглах.	<ol style="list-style-type: none"> <li>1. Хичээлийн янз бүрийн нөхцөлд бүтээлч, шүүн тунгаах сэтгэлгээ, логик үндэслэл, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах чадварыг харуулах.</li> <li>2. Суралцагчдын өндөр эрэмбийн сэтгэх чадварыг хөгжүүлэх сургалтын нөхцлүүдийг бий болгох.</li> <li>3. Суралцагчдын харилцааны чадварыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх.</li> <li>4. Сурах, сургах үйл ажиллагааг дэмжих арга хэрэгсэл, технологийг ашиглах.</li> </ol>
Д. Хувь хүний хувьд, мэргэжлийн түвшинд ч үлгэр жишээ багшийн эерэг чанаруудыг эзэмшсэн байх.	<ol style="list-style-type: none"> <li>1. Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, хамтран ажиллагчид болон бусад холбогдох хүмүүстэй харилцахдаа багшийн мэргэжлийн хэм хэмжээг баримтлах.</li> <li>2. Багшийн хувийн болон мэргэжлийн эерэг шинж чанаруудыг харуулах.</li> <li>3. Суралцагчдын төдийгүй эцэг эх, асран хамгаалагчдын сайн сайхан байдал, олон нийтийн асуудалтай холбооой асуудал, зөрчил, санал зөрөлдөөнийг шийдвэрлэхдээ мэргэжлийн ур чадвар, шударга үнэнч байдлыг харуулах</li> </ol>
Е. Хувийн болон мэргэжлийн хөгжлийг тасралтгүй дээшлүүлэх хүсэл эрмэлзлийг харуулах.	<ol style="list-style-type: none"> <li>1. Семинар, сургалтад хамрагдах, наадамд оролцох, судалгаа хийх болон боловсролын салбарын өөр бусад үйл ажиллагаанд оролцох замаар хувийн болон мэргэжлийн тал дээр хөгжих.</li> <li>2. Сургуулиас зохион байгуулдаг олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцох.</li> </ol>

### ***Бүгд Найрамдах Солонгос Улс***

Солонгосын бага ангийн багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд нь дараах боловсролын зорилготой байдаг. Үүнд:

1. Оюутнуудад мэргэжлийн багш нарт шаардагдах зан чанар, тууштай байдал, ёс зүйг төлөвшүүлэх;
2. Оюутнууд аливаа сэдвээр агуулгын гүнзгий мэдлэгийг эзэмшүүлж хөгжүүлэх;
3. Оюутнуудын суралцагчийн сурах үйл ажиллагааг үр дүнтэй дэмжихэд шаардагдах сурган хүмүүжүүлэх ур чадварыг хөгжүүлэх;

4. Оюутнуудын боловсролын үзэгдлийг судлах чадварыг хөгжүүлэх;
5. Оюутнууд өөрчлөгдөж буй ертөнцөд үр дүнтэй дасан зохицохын тулд тэдний бүтээлч чадвар, шүүмжлэлт сэтгэлгээ, МХТ-ийн чадамжийг хөгжүүлэхэд оршдог байна гэжээ.

Солонгосын бага ангийн багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тухайд ерөнхий суурь хичээлтэй нь холбосон байдаг байна. Ерөнхий суурь хичээлийг 3 ангилалд хуваадаг бөгөөд эдгээр нь оюутнуудыг ирээдүйд нийгмийн боловсролтой, оюунлаг гишүүн болгоход чиглэсэн ба их сургуулийн түвшинд суралцахад шаардлагатай суурь чадваруудыг хөгжүүлэх зорилготой байдаг байна. Хүснэгт 21-д сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнг дэлгэрэнгүй үзүүлэв.

Хүснэгт 21. Солонгосын бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн

Ерөнхий суурь хичээл	Оюутны эзэмших мэдлэг, ур чадвар
<p><b>(а) Академик суурь:</b> Энэ ангилал нь бүх оюутнуудын нийтлэг суурь болж, үндсэн ур чадварыг нэмэгдүүлдэг бөгөөд төгссөний дараа ч бас хэрэглэгддэг. Энэ ангилалд оюутнуудын шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлэх, эх хэл, гадаад хэлээр ярих, бичих замаар үзэл бодлоо тод, үр дүнтэй илэрхийлэх чадварыг хөгжүүлэх хичээлүүд багтана.</p> <p>Мөн математикийн сэтгэх чадвар академик шаардлагын дагуух статистикийн нарийвчилсан шинжилгээ; оюутнуудын шинжлэх ухааны мэдлэг болон туршилтын арга зүйг дээшлүүлэх шинжлэх ухааны суурь хичээлүүд; компьютерийн шинжлэх ухаан, мэдээллийн менежментийн зарчим, хэрэглээний аргуудыг ойлгоход туслах хичээлүүд багтана.</p>	<p>1) Шүүмжлэлт сэтгэлгээ ба бичих: Яриа, бичгээр дамжуулан логик, шүүмжлэлтэй сэтгэх, аналитик ба синтетик байдлаар унших, болон академик салбар бүрийн уламжлал, хэлбэрт тохирсон арга барилаар мэдлэгийг бий болгож, хуваалцах чадварыг хөгжүүлэхийг боловсролтой хувь хүнээс шаардагддаг онцлогтой.</p> <p>2) Гадаад хэл: Гадаад хэлний чадамж нь оюутнуудад шүүмжлэлтэй сэтгэх чадвар, сургуулийн янз бүрийн академик үйл ажиллагааг явуулахад шаардлагатай чадварыг дээшлүүлэхэд тусалдаг бөгөөд дэлхийн харилцааны бэрхшээлийг арилгахад тусалдаг.</p> <p>3) Математикийн шинжлэх ухааны хичээлүүд нь оюутнуудад математикийн үндсэн мэдлэгийг олж авах, түүний зарчмуудыг ойлгох, хэрэгжүүлэх, математикийн илэрхийлэл, диаграмм, статистикийн үр дүнгийн дүн шинжилгээ хийх замаар логик, шинжлэх ухааны үндэслэлтэй чадварыг хөгжүүлэхэд тусалдаг.</p> <p>4) Байгалийн шинжлэх ухааны хичээлүүд нь оюутнуудад шинжлэх ухааны суурь мэдлэгийг олж авах, шинжлэх ухааны сэтгэлгээ, туршилт хийх замаар бүтээлч сэтгэлгээг бий болгох шинжлэх ухааны авьяас чадварыг хөгжүүлэхэд тусалдаг.</p> <p>5) Компьютер, мэдээллийн шинжлэх ухааны хичээлүүд нь эрдэм шинжилгээний ажил болон өдөр тутмын амьдралд хэрэгтэй компьютер, мэдээллийн технологийн үндсэн зарчмууд, хувийн мэдээллийн хамгаалалтын талаархи ойлголт, чадварыг хөгжүүлдэг</p>
<p><b>(в) Академик чиглэлээр либерал урлагийн боловсрол эзэмшсэн хүний оюуны тэнцвэртэй мэдлэг, ойлголтыг төлөвшүүлэхийг эрмэлздэг.</b></p> <p>Энэ ангилал нь оюутнуудад өргөн хүрээний их дээд сургуулийн боловсрол эзэмшүүлж, эрдэм шинжилгээний салбар тус бүрт олон янзын мэдлэг, үндсэн арга зүй эзэмших боломжийг олгодог. Идэвхтэй унших, судлах, мэтгэлцээний явцад оюутнууд өөрсдийн байр сууриа тусгах, тодруулах зорилгоор бие даасан сэтгэлгээг хөгжүүлэх бөгөөд</p>	<p>1) Хэл, уран зохиолын хичээлүүд нь өөр өөр хэлийг ойлгох; уран зохиолын бүтээлийн шинж чанар, бүтэц, агуулга; төрөл бүрийн академик арга зүй, мэдлэг олж авах зорилготой. Тиймээс хичээлүүд нь хүн төрлөхтний амьдралын талаар илүү гүнзгий мэдлэгтэй болохын тулд хэл, уран зохиолын бүтээлийг гүн гүнзгий унших, танилцуулах, мэтгэлцэх, бүтээлийг үнэлэх замаар нэгдмэл, шүүмжлэлт талаас нь ойлгох чадавхийг дээшлүүлэх зорилготой юм</p> <p>2) Соёл, Урлагийн хичээлүүд нь харааны болон сонсголын урлагийн бүтээл, үйл ажиллагааны талаархи академик мэдлэг олж авах, соёлын олон янз байдлын талаархи хүмүүнлэг ойлголтод төвлөрдөг. Тиймээс хичээлүүд нь хүн төрлөхтний амьдралын талаар илүү гүнзгий мэдлэгтэй байх, соёл урлагийг гүнзгий уншлага, илтгэл, мэтгэлцээн, үзүүлбэрийг үнэлэх замаар нэгдсэн, шүүмжлэлт талаас нь ойлгох чадавхийг дээшлүүлэх зорилготой юм</p>

<p>ингэснээр шүүмжлэлтэй, бүтээлч чадварыг хөгжүүлэхэд туслах болно.</p> <p>Эдгээр хичээлүүд нь оюутнуудын хүний амьдрал, нийгэм, байгальтай холбоотой томоохон асуудлуудын талаархи мэдлэг, мөн ертөнцийг болон өөрсдийгөө хариуцлагатайгаар дүгнэх үнэлэх чадварыг бий болгоход хувь нэмэр оруулдаг.</p>	<p>3) Түүх ба философийн хичээлүүд нь соёл иргэншлийн харилцааг дэлхийн иргэн болгон төлөвшүүлэх, хүн төрөлхтний оюун санааны соёлын өвийн сургаал, дорно ба өрнөдийн янз бүрийн нийгмийн түүхүүд, дорнод ба өрнөдийн философи, шашин, гоо зүйн үнэт зүйлсийн систем (үнэн, сайн сайхан, гоо үзэсгэлэн)ээр дамжуулан эртний сэтгэлгээний суурь мэдлэгийг эзэмшүүлэх, хөгжүүлэхэд чиглэдэг.</p> <p>Эдгээр хичээлүүд нь нэг хэмжээст сэтгэлгээнээс хальж нэгдмэл, нэгтгэх сэтгэлгээг бий болгодог.</p> <p>4) Улс төр, эдийн засгийн хичээлүүд нь өөрчлөгдөж буй норматив, улс төр, эдийн засгийн зан үйл, түүнчлэн хувь хүмүүс ба корпорациудын хоорондын харилцаа, үндэсний болон олон улсын нийгэмлэгийн харилцан хамаарлын академик ойлголтод чиглэдэг. Олон янзын үнэт зүйлсийн талаар арга зүйн дүн шинжилгээ хийх, мэтгэлцэх, оюутнуудад үзэгдлийг янз бүрийн өнцгөөс тайлбарлах чадвар, сэтгэхүйн үйл явцыг бий болгох замаар хожим амьдралд үүсч болох норматив, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын талаархи ойлголтыг бий болгож, санал бодлоо илэрхийлэх, бие даан оролцох чадвартай болно.</p> <p>5) Хүн ба Нийгмийн хичээлүүд нь нийгэм, соёл, сэтгэл зүй, боловсролын үйл ажиллагаанд хувь хүн, бүлэг, нийгэм, хүн төрөлхтний оролцоотойгоор олон янзын академик мэдлэг, хандлагын төрөл бүрийн хэв шинж, шинж чанаруудын талаар ойлгоход тусалдаг. Түүнчлэн эрдэм шинжилгээний салбар бүрт ашигладаг олон янзын ойлголтын хүрээ, зэрэг чухал асуудлуудын талаар сурч мэдсэнээр, оюутнуудын янз бүрийн үзэгдлийг олон талаас нь ойлгох, дүн шинжилгээ хийх, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлэхэд туслана. Мөн нийгмийн болон хувь хүний бодитой нөхцөл байдлыг үнэлэх, ойлгох чадварыг хөгжүүлэхийг эрмэлздэг.</p> <p>6) Байгаль, технологийн хичээлүүд нь орчин үеийн нийгэмд боловсролтой хүний хувьд шинжлэх ухааны суурь мэдлэгийг эзэмших, шинжлэх ухаан, технологийн уялдаа холбоог ойлгоход чиглэдэг. Үүний дагуу эдгээр сургалт нь оюутнуудад байгаль орчин, орчин үеийн нийгэм дэх технологийн үүргийг ойлгоход тусалдаг. Мөн оюутнуудын янз бүрийн академик мэдлэгийн хүрээг харгалзан үзэж баримт нотолгоо / туршилт ба онолын боловсрол хоёрын хооронд зохих тэнцвэрийг бий болгохыг хичээдэг.</p> <p>7) Амьдрал ба хүрээлэн буй орчны хичээлүүд нь нь хүн төрөлхтний амьдралын хэв маяг, оршин тогтноход ихээхэн нөлөөлдөг бөгөөд амьдрал, хүрээлэн буй орчинтой холбоотой шинжлэх ухааны үндсэн мэдлэгийн талаарх ойлголтыг хүний үйл ажиллагааны янз бүрийн салбарууд болон олон янзын судалгааны салбаруудтай холбох чадвар, хэтийн төлөвшлийг хөгжүүлэхэд чиглэгддэг. Үүний</p>
--	---

	<p>дагуу уг хичээлүүд нь оюутнуудад биологийн хөгжил, хүрээлэн буй орчны хурдацтай өөрчлөлт нь хүний амьдрал, орчин үеийн нийгэмд хэрхэн нөлөөлж байгааг ойлгуулж, амьдрал, дэлхий, хүрээлэн буй орчны талаархи суурь мэдлэгийг эзэмшүүлэхэд туслах зорилготой юм.</p> <p>Мөн боловсролын туршлага хуримтлуулах замаар хөгжихөд нь туслах жишээг багтаасан, баримт нотолгоо / туршилт ба онолын боловсрол хоёрын хооронд зохих тэнцвэрийг бий болгохыг хичээдэг.</p>
<p><b>(с) Ерөнхий суурийн сонгон суралцах хичээлийг оюутны сонирхол, хувь хүний сониуч байдалд нийцүүлэн чөлөөтэй сонгож болно.</b></p> <p>Янз бүрийн салбарт оюуны туршлага, үйл ажиллагааг төлөвлөх замаар эдгээр хичээлүүд нь өөрийгөө хөгжүүлэх, сэтгэлгээгээр дамжуулан өөрийн карьер, зан чанарыг хөгжүүлэх, анхдагч үндэс суурийг тавьдаг.</p> <p>Эдгээр хичээлүүд нь нэгдүгээр курсийн оюутнуудад коллежийн амьдрал, шинжлэх ухааны талаар илүү сайн ойлголттой болох, манлайлах чадварыг хөгжүүлэх; урлаг, биеийн тамирын боловсрол олгох; орчин үеийн нийгмийн нарийн төвөгтэй байдал, интеграци мэдлэгийн талаархи салбар хоорондын ойлголт өгөх; оюутнуудын бүтээлч байдал, бие даасан судалгааны чадварыг хөгжүүлэх; Солонгосын түүх, соёлын үндсэн шинж чанаруудыг ойлгоход тусалдаг.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1) Биеийн тамирын сургалт нь ур чадварыг хөгжүүлэх зорилготой хамтын ажиллагааны болон спортын ур чадвар ба эрүүл мэндийн биеийн тамирын дасгалаас бүрдэнэ. Тэд их сургуулийн амьдрал, цаашилбал эрүүл чийрэг бие бялдар, оюун ухаантай хүмүүсийг хөгжүүлдэг.</li> <li>2) Урлагийн дадлагын хичээлүүд нь оюутнуудын урлагийн бүтээлийг харааны, сонсголын болон урлагийн туршлагаар дамжуулан ойлгох, бүтээх чадварыг хөгжүүлэх зорилготой.</li> <li>3) Коллежийн амьдрал ба манлайллын хичээлүүд нь шинэ оюутнуудад их сургуульд дасан зохицож, эрдмийн ажлаа амжилттай гүйцэтгэхэд тусалдаг. Мөн оюутнуудад хүн төрөлхтний зохих үнэт зүйлс, зан төлөвийг төлөвшүүлэх, хамтын үүрэг хариуцлага, дадлага хийх замаар үйлчлэх хандлагыг дагалдах манлайллын чадварыг хөгжүүлэхийг уриалдаг.</li> <li>4) Бүтээлч байдал ба Конвергенцийн хичээлүүд нь "Хараат бус судалгаа", "Хараат бус бүлгийн семинар" -аар дамжуулан оюутнуудын бие даасан судалгааны чадварыг хөгжүүлэхэд тусалдаг. Энэ нь салбар дундын хичээлүүдүүдээр дамжуулан бүтээлч авъяас чадвараа дээшлүүлэхэд зориулагдсан бөгөөд янз бүрийн сэдвүүдийг агуулгаар нэгтгэх, дүн шинжилгээ хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх боломжийг олгодог.</li> <li>5) Солонгосын тухай англи хэл дээр (гадаад хэлээр) явагддаг хичээлүүд нь Солонгосын нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, түүхийг олон янзын академик талаас нь ойлгох боломжийг олгоход чиглэгддэг.</li> </ol>



## **ГУРАВ. “БАГШ, БАГА БОЛОВСРОЛ” ХӨТӨЛБӨРӨӨР ТӨГСӨГЧИЙН ХӨГЖИХ ХЭРЭГЦЭЭНИЙ БОЛОН АЖИЛ ОЛГОГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА**

### **3.1. Судалгааны товч танилцуулга**

Багш бага боловсрол сургалтын жишиг хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр сурч төгссөн бага боловсролын багшийн сэтгэл ханамжийн судалгааг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн ба хувийн хэвшлийн 40 сургуулийн 824 бага ангийн багш, 259 сургуулийн 259 бага боловсролын сургалтын менежерийг хамруулан авч, судалгааны үр дүнг боловсруулан гаргалаа.

Судалгааны тайлан нь 4 бүлэг, дүгнэлт, санал, хавсралт гэсэн бүтэцтэй бөгөөд 1-р бүлэгт судалгааны асуулгад хийсэн фактор анализын үр дүнг танилцуулсан бөгөөд 2- бүлэгт Бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээний судалгааны үр дүнг; 3-р бүлэгт Бага боловсролын сургалтын менежерийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг; 4-р бүлэгт Багш (төгсөгч)-ийн болон сургалтын менежер (ажил олгогч)-ийн судалгааны үр дүнд хийсэн харьцуулсан шинжилгээг тус тус авч үзлээ.

Судалгааны мэдээлэл цуглуулахад аймаг, дүүргийн БШУ-ны газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүд (үүнд; Б.Аяужин (Баян-өлгий), Э.Бат-эрдэнэ (Ховд), Ж.Бумтуяа (Дорнод), Х.Байгалмаа (Хэнтий), Б.Өнөрбаян (Дархан-уул), П.Мягмаржаргал (Сэлэнгэ), Э.Ундармаа (Хөвсгөл), П.Одончимэг (Орхон), Т.Цэрэнханд (Баянзүрх дүүрэг), Б.Март (Сонгинохайрхан дүүрэг)), эдгээр аймаг, дүүргийн сургуулиудын бага боловсролын багш, бага боловсролын сургалтын менежерүүдийн оролцоо, хамтын ажиллагаа үнэтэй хувь нэмэр оруулсанд судалгааны багийн зүгээс Талархлаа илэрхийлье.

#### ***Судалгааны зорилго, зорилт***

Багш, бага боловсрол хөтөлбөрөөр төгсөгчийн болон ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа авч, Багш бага боловсролын сургалтын жишиг хөтөлбөр боловсруулахад судалгааны үндэслэл бүхий санал, дүгнэлт гаргахад судалгааны зорилго оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавив. Үүнд:

1. Багш бага боловсрол мэргэжлээр төгсөгчийн болон ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах
2. Судалгааны хэрэгсэл (асуулга), үр дүнд хүчин зүйл (фактор анализ)-ийн шинжилгээ хийх
3. Багш (төгсөгч), сургалтын менежер (ажил олгогчийг төлөөлж) асуулга судалгааны үр дүнд харьцуулсан шинжилгээ хийх
4. Судалгааны үр дүнд дүгнэлт гаргах, тайлагнах

#### ***Судалгааны арга зүй, аргачлал***

Судалгааг тоон ба чанарын судалгааны аргууд, хүчин зүйлийн шинжилгээ, контент шинжилгээний арга, аргачлалыг ашиглан явуулна.

*Тоон судалгааны арга*

✓ Асуулга:

- ✓ Бага боловсролын багшийн талаарх ерөнхий мэдээлэл

- ✓ Бага боловсролын сургалтын хөтөлбөр, агуулга
- ✓ Багшийн чадамжийн хүрээ, үнэлгээ
- ✓ Бага боловсролын багшийн хөгжлийн хэрэгцээ шаардлага, нөхцөл боломж
- ✓ Багш боловсрол хөтөлбөрөөр төгсөгчийн чадамжийн үнэлгээ (ажил олгогч)
- ✓ Статистик болон судалгааны тоон мэдээллүүдэд шинжилгээ хийх (Контент анализ)
  - ✓ ЕБС-ын статистик, тоон мэдээлэл (2021-2022)

#### *Чанарын судалгааны арга*

- ✓ Багш-бага боловсрол сургалтын хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр бага боловсролын сургалтын менежерийн бусад саналууд
- ✓ Багш-бага боловсрол сургалтын хөтөлбөрт багтах судлагдахууны агуулгад оруулах өөрчлөлтүүдийг нэгтгэх
- ✓ Бага ангийн багш нарт үүссэн хөгжих хэрэгцээг шийдвэрлэх арга замыг талаарх нээлттэй асуулгад өгсөн хариултуудад боловсруулалт хийх

#### **Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах**

Мэдээлэлийг Google form ашиглан цуглуулж, анхдагч мэдээллийн сан бүрдүүлнэ. Судалгааны мэдээллийг EXCEL, SPSS-25 программаар боловсруулна. Мэдээлэлд боловсруулалт хийхдээ холбогдох мэдээлэлд дан болон харьцуулсан тоололт, хүчин зүйлийн шинжилгээ хийнэ.

#### **Хамрах хүрээ, түүвэр**

Эх олонлог: БШУЯ-ны 2020-2021 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр Монгол улсад ерөнхий боловсролын 839 (эдгээрээс 672 төрийн өмчийн, 167 төрийн бус өмчийн) сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж, бага боловсролын 356904 суралцагч суралцаж, 11467 багш ажиллаж байна.

Судалгаанд 5 бүсийн төлөөллийг оролцуулан аймаг, дүүргээс сургуулиудыг сонгохдоо:

- Аймаг, дүүргийн бага ангийн сурагчдын тоо, бага ангийн багшийн тоо хамгийн олон төрийн өмчийн 2, төрийн бус өмчийн 1 сургууль,
- Сумын төвийн бага ангийн багш, сурагч ихтэй төрийн өмчийн 2 сургууль,
- Багийн 1 сургуулийг тус тус хамруулна.

#### *Хүснэгт 22. Түүвэрт сонгогдсон сургуулийн мэдээлэл (бус, багшийн тоо)*

Бүс	Аймаг, дүүрэг	Багшийн тоо		
		Нийт	Төрийн өмчийн	Төрийн бус өмчийн
Баруун бүс	Баян-өлгий	564	541	23
	Ховд	335	335	0
Зүүн бүс	Дорнод	291	275	16
	Хэнтий	296	290	6
Төвийн бүс	Дархан-уул	351	300	51
	Сэлэнгэ	374	369	5
Хангайн бүс	Хөвсгөл	480	476	4
	Орхон	317	292	25
Улаанбаатар	Баянзүрх	1,227	893	334
	СХД	841	806	35
<b>Нийт</b>		<b>5076</b>	<b>4577</b>	<b>499</b>

Хүснэгт 23 Түүвэр (сургуулийн нэрээр)

№	Бүс	Аймаг	Байршил	Өмчийн хэлбэр	Сургуулийн нэр	Бүлэг	Багш	Менежер Тоо
1	Баруун	Баян-өлгий	А	Төрийн	Өлгий сумын лаборатори II сургууль	33	33	47
2			А	Төрийн	Өлгий сумын V сургууль	31	38	
3			С	Төрийн	Дэлүүн сумын I сургууль	26	40	
4			Б	Төрийн	Улаанхус сумын III сургууль	14	18	
5			С	Төрийн	Цэнгэл сумын I сургууль	26	27	
6			А	Хувийн	Дарын цогцолбор сургууль	8	8	
7		Ховд	А	Төрийн	Жаргалант сумын II сургууль	22	22	24
8			А	Төрийн	Лаборатори I сургууль	30	30	
9			С	Төрийн	Булган сумын Минжит булган ЦС	19	19	
10			С	Төрийн	Үенч сумын сургууль	15	14	
1	Зүүн	Дорнод	А	Төрийн	Хэрлэн сумын V сургууль	25	25	16
2			С	Төрийн	Баян-Уул сумын сургууль	18	18	
3			С	Төрийн	Дашбалбар сумын сургууль	10	10	
4			А	Төрийн	Хэрлэн сумын шинэ хөгжил ЦС	26	27	
5			Б	Төрийн	Халхгол сум, Ялалт багийн сургууль	5	5	
6			А	Хувийн	Хэрлэн сумын Фловер сургууль	8	8	
7		Хэнтий	А	Төрийн	Хэрлэн сумын лаборатори I сургууль	36	34	26
8			С	Төрийн	Бор-Өндөр сумын Бор-Өндөр ЦС	30	30	
9			Б	Төрийн	Батноров сум, Бэрх тосгоны сургууль	10	10	
10			А	Төрийн	Хэрлэн сумын Тэмүүжин ЦС	27	27	
11			С	Төрийн	Өмнөдэлгэр сумын сургууль	15	14	
12			С	Хувийн	Бор-Өндөр сум, Их ирээдүй бага сургууль	5	6	
1	Төв	Дархан-Уул	С	Төрийн	Орхон сумын сургууль	9	9	23
2			Б	Төрийн	Хонгор сумын XI сургууль	6	5	
3			С	Төрийн	Хонгор сумын XIV сургууль	8	10	
4			А	Төрийн	Дархан сумын Од ЦС	53	53	
5			А	Төрийн	Оюуны ирээдүй ЦС	54	54	
6			А	Хувийн	Дархан сумын Монгол-Оюу сургууль	10	10	
7		Сэлэнгэ	А	Төрийн	Сүхбаатар сумын I сургууль	23	23	35
8			А	Төрийн	лаборатори IV сургууль	15	16	
9			С	Төрийн	Сайхан сумын сургууль	16	16	
10			С	Төрийн	Мандал сумын IV сургууль	19	19	
11			С	Хувийн	Мандал сумын Билиг сургууль	6	5	
1	Хангай	Хөвсгөл	Б	Төрийн	Бүрэнтогтох цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор	5	5	36
2			А	Төрийн	Хөвсгөл дэлгэр мөрөн цогцолбор сургууль	32	32	
3			С	Төрийн	Хөвсгөл Жаргалант сумын сургууль	19	19	
4			С	Төрийн	Хөвсгөл Тариалан сумын сургууль	21	21	
5			А	Төрийн	Хөвсгөл лаборатори Эрдмийн далай ЦС	25	26	
6		А	Хувийн	Далай ван ДС-ийн харьяа сургууль	5	4		
7		Орхон	А	Төрийн	Баян-Өндөр сумын IV сургууль	37	38	23
8	С		Төрийн	Жаргалант сумын сургууль	10	10		
9	А		Төрийн	Баян-Өндөр сумын I сургууль	32	32		
1	Улаанбаатар	БЗД	Н	Төрийн	Лаборатори 44 дүгээр сургууль	52	56	9
2			Н	Төрийн	Шавь ЦС	80	80	
3			Н	Хувийн	Олонлог академи бүрэн дунд сургууль	38	40	
4		СХД	Н	Төрийн	65 дугаар сургууль	63	63	39
5			Н	Төрийн	Хөгжил цогцолбор сургууль	65	65	
6			Н	Хувийн	Тольт сургууль	11	9	
					Нийт		1183	308

### 3.2. Судалгааны үр дүнд хийсэн хүчин зүйлийн шинжилгээ

“Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчийн хөгжих хэрэгцээний болон ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа”-ны асуулгыг багш, сургалтын менежерт зориулж 2 хувилбараар боловсруулсан бөгөөд бага боловсролын 824 багш, 259 сургалтын менежерүүдийг хамруулсан хариултын үр дүнг SPSS-25 программ хангамж ашиглан боловсруулалт хийв. Ингэхдээ хувьсагчуудад хүчин зүйлийн шинжилгээ хийж, үр дүнг гарган авлаа. Үүнд:

1. Орхигдсон утга
2. О вариацийн утга
3. Найдвартай байдлын шинжилгээ
4. КМО тест буюу түүвэр хүрэлцээтэй эсэх шинжилгээ
5. Хувьсагчуудын нийтлэг байдал
6. Rotated component matrix буюу хүчин зүйлс бүрийн хувьсагчдыг харьцуулалт
7. Хамаарлын шинжилгээ хийсэн бөгөөд шинжилгээ тус бүрийг тодруулан авч үзье.

#### 1. Орхигдсон утга

Энэ утга нь тест (асуулга)-ийн доторх хувьсагчууд буюу асуултуудад судалгааны зорилгыг илэрхийлэх хувьсагчууд бүрэн орсон болохыг харуулна. Хувьсагчуудын давтамжийн өсөлтийг харахад орхигдсон утга алга. Хувьсагчийн хэвийн хэмжээ (буюу хамгийн бага утга 1, хамгийн их утга 5)-ээс давсан тоон утга байхгүй тул тухайн нэгжид өгөгдөлүүд бүрэн байна (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү).

#### 2. 0 вариацийн утга

Тэг вариацийн утгыг бүлэг асуулт тус бүрийн нийлбэрээр тооцож гаргалаа. Судалгаанд оролцсон 11 оролцогч бодитой бус хариулт өгсөн буюу вариацийн утга 1-ээс доош утгатай байна.

#### О вариаци (тайлбарлах)

ID багш	64	148	287	300	475	538	603	732
ID менежер	181	197	208					

#### 3. Найдвартай байдлын шинжилгээ

Өгөгдөлийн найдвартай байдлын шинжилгээгээр багш нарын асуулгын Кронбах альфа утга .724-.976 буюу энэ нь Kline (1999)-ны тодорхойлсоноор хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Харин хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээл, шийдвэрлэдэг арга зам (менежер) нь найдвартай байдлыг хангаж чадахгүй байна (Хүснэгт 24).

Асуултуудын нийт статистикаас найдвартай байдлын шинжилгээний хүрээнд ямар нэгэн хувьсагчийг хасах шаардлагагүй байна.

Хүснэгт 24. Найдвартай байдал (Reliability Statistics)

Асуулга	Менежер		Багш	
	Cronbach's Alpha	N of Items	Cronbach's Alpha	N of Items
Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын өөрчлөлт	0.855	15	.939	15
Багш мэргэжлээр ажиллахад шаардлагатай чадвар, хандлага	0.949	33	0.976	26
Ажлын байранд тулгардаг бэрхшээл	0.847	14	0.939	14
Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээл	0.657	11	0.839	11
Шийдвэрлэдэг арга зам	0.564	7	0.724	6
Заахад амархан, хэцүү хичээл	0.768	11	0.864	10
Бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээ	0.749	12	0.906	13
Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	0.816	13	0.936	13

#### 4. КМО болон Bartlett's Test

КМО=.709-.981 хооронд байгаа нь (Field, 2009)-ийн дагуу зөвшөөрөгдсөн хэмжээнээс дээгүүр буюу хүчин зүйлийн шинжилгээн дэх хувьсагчуудын хүрээнд түүвэр хүрэлцээтэй байна (хүснэгт 25).

Хүснэгт 25. Түүврийн хүрэлцээтэй байдлын шинжилгээ

Хувьсагч	менежер		багш	
	Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.	Approx. Chi-Square	Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.	Approx. Chi-Square
Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын өөрчлөлт	0.781	1830.9	0.904	9462.39
Багш мэргэжлээр ажиллахад шаардлагатай чадвар, хандлага	0.939	4248.2	0.981	20703.96
Ажлын байранд тулгардаг бэрхшээл	0.876	1074.9	0.947	7964.87
Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээл	0.71	332.5	0.865	2992.18
Шийдвэрлэдэг арга зам	0.709	121.5	0.768	976.83
Заахад амархан, хэцүү хичээл	0.754	737.3	0.854	4613.62
Бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээ	0.774	487.1	0.919	4957.98
Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	0.835	754.8	0.955	6437.03

#### 5. Хувьсагчуудын нийтлэг байдал (Communality)

Өгөгдөлд дараагийн шатны боловсруулалт хийхэд хувьсагчуудын нийтлэг байдлыг ашиглах ба ингэхдээ тодорхой коэффициенттэй жишнэ. Энд бид 0.4 гэсэн утгыг өгсөн бөгөөд дараах хувьсагчууд энэ утгаас бага байгаа тул шинжилгээнээс хасч болно гэж үзсэн (хавсралт 2-т өнгөөр тэмдэглэснийг харна уу).

- ✓ Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээлийн хувьд,
  - хичээлийн бэлтгэл,
  - сургалтын баримт бичиг,
  - гадаад хэлний мэдлэг, хэрэглээ,

- үнэлж дүгнэх үйл ажиллагаа
- ✓ Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хувьд,
  - багш нарын мэргэжилдээ хандах хандлагыг сайжруулах,
  - сайн туршлагыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх

#### **6. Rotated component matrix буюу хүчин зүйлс бүрийн хувьсагчдын харьцуулалт**

Энэ шинжилгээгээр хувьсагчуудыг компонент болгон бүлэглэж болох ба жишээ нь бага боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын өөрчлөлт гэсэн асуулгын 15 хувьсагчийг 4 бүлэглэж болно (хавсралт 3-т дэлгэрүнгүй байдлаар харуулав). Хувьсагчуудын тайлбарлагдах шинж 67.064 хувьтай байна

#### **7. Хамаарлын шинжилгээ**

Хүчин зүйл бүрийн хувьсагчдыг харьцуулан гаргасан. SPSS- absolute values .40 ба түүнээс бага утгыг харуулахгүй байхаар тохируулсан байдаг тул Боловсрол судлал, Сэтгэл судлал гэсэн нүдэнд утга нь хоосон байна (хавсралт 4).


Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад багшид тулгардаг бэрхшээл гэсэн асуулгын 11 хувьсагчыг 3 хүчин зүйлд хувааж болно. Хувьсагчуудын тайлбарлагдах шинж 66.198 хувьтай байна.

### 3.3. “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчийн хөгжих хэрэгцээний судалгааны үр дүн

#### 3.3.1. Ерөнхий мэдээлэл

Энэхүү судалгаа нь бага боловсролын багшийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах үндэслэлийг тодорхойлоход бага боловсролын багш (төгсөгчид)-ийн саналыг тусгахыг зорьсон болно. Тус судалгаанд Монгол Улсын газарзүйн бүсээс түүврээр сонгогдсон 8 аймаг, нийслэлийн 2 дүүргийн бага боловсролын нийт 824 багшийг онлайн хэлбэрээр хамруулав. Үүнд:

Зураг 8. Судалгаанд хамрагдсан багшийн бүсийн төлөөлөл



Судалгаанд хамрагдсан бага боловсролын багш нарыг сургуулийн байршил ба өмчийн хэлбэрээр нь авч үзвэл (Хүснэгт 26.):


Хүснэгт 26. Судалгаанд хамрагдсан багш нарын сургуулийн байршил ба өмчийн хэлбэр

№	Сургуулийн байршил	Төрийн өмчийн		Төрийн өмчийн бус		Бүгд	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	Аймгийн төв	413	50.1	20	2.4	433	52.5
2.	Баг	53	6.4	2	0.2	55	6.7
3.	Сумын төв	202	24.5	6	0.7	208	25.2
4.	Улаанбаатар хот	106	12.9	22	2.7	128	15.5
	Нийт	774	94	50	6	824	100.0

Хүснэгт 26-аас харвал нийт судалгаанд хамрагдсан багшийн 82.7 хувь нь хөдөө орон нутгаас оролцсон ба 93.2 хувь нь төрийн өмчийн сургуулиудад ажиллаж байна. Эдгээр багшийн хүйсийн харьцаа 1:4 буюу нийт оролцогчдын 4.3 хувь нь эрэгтэй, 95,7 хувь нь эмэгтэй байна.


Судалгаанд хамрагдсан багш нарын насны бүлгийг авч үзвэл (хүснэгт 2) 30 хүртэлх насны 20.9 хувь, 30-39 насны 31.6 хувь, 40-49 насны 31.4 хувь, 50-59 насны 15.4 хувь, 60-аас дээш насны 0.6 хувь тус тус байгаа бөгөөд зүүн бүсээс 40-49 насны, баруун бүсээс 30-39 насны, төвийн бүсээс 30 хүртэлх насны багш нар бусад бүстэй харьцуулбал хамгийн олон оролцжээ.

Зураг 9. Судалгаанд хамрагдсан багш нарын насны бүлэг (багшийн тоо, эзлэх хувь)




Багш нарын боловсролын түвшинг авч үзвэл (Зураг 10) бакалавр зэрэгтэй багшийн нийт судалгаанд хамрагдсан багш нарт эзлэх хувь өндөр байгаа бөгөөд докторын зэрэгтэй багш байхгүй байна.

Зураг 10. Боловсролын түвшин



Мэргэжлийн зэргийн хувьд судалгаанд зөвлөх 15, тэргүүлэх 268, заах аргач 293, зэрэггүй 246 багш хамрагдсан байдлыг боловсролын түвшнээр авч үзье (Зураг 11).


Зураг 11. Багшийн мэргэжлийн зэрэг ба боловсролын түвшин (хувь)



Зураг 11-ээс боловсролын бусад түвшинтэй харьцуулбал бакалаврын түвшний заах аргач, тэргүүлэх зэрэгтэй болон зэрэггүй багшийн эзлэх хувь хамгийн өндөр, харин магистрын түвшний зэрэггүй багшийн нийт багшид эзлэх хувь бага боловч 2.8 хувьтай байгаа юм.



Зураг 12. Ажилласан жил



Багшийн ажилласан жилийн хувьд эхний жилийн багш бусдаас харьцангуй цөөн, харин 25-аас дээш жил ажиллаж байгаа багш нар хамгийн өндөр хувьтай хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан багш нараас “Багш, бага


боловсрол” мэргэжлээр сурч байхдаа ямар мэргэшлийн чиглэлийг сонгон суралцсан болохыг тодруулан асуусан ба нийт багшийн 33 хувь нь ямар нэг чиглэлээр мэргэшээгүй байна. Харин тодорхой мэргэшлийн чиглэл сонгосон багш нарын хувьд монгол хэл, математик чиглэлээр түлхүү мэргэшсэн гэжээ (Зураг 13).

Зураг 13. Багшийн мэргэшсэн чиглэл (давхардсан тоо ба судлагдахуунаар)



Дээрх асуулталтад “мэргэшээгүй” гэж хариулсан багш нараас цаашид ямар чиглэлээр мэргэших хэрэгцээ байгааг асуухад 59 хувь нь мэргэших хэрэгцээ, шаардлага байхгүй гэж, 30.9 хувь нь математик чиглэлээр мэргэших хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Мэргэших хэрэгцээ байхгүй гэж хариулсан багшийн ажилласан жилийг харвал 22 хувь нь 1-5 жил, 15 хувь нь 16-20 жил, 34 хувь нь 25-аас дээш жил багшилсан туршлагатай байна.

Зураг 14. Хичээл заадаг анги



Тус судалгаанд оролцсон нийт багшийн хичээл заадаг ангийг авч үзвэл (Зураг 14) I-У ангид жигд буюу ойролцоо хувьтай сонгогдсон байна.

Бага боловсролын багшийн ажлын ачааллын талаар мэдээлэл авахын тулд хичээл заадаг ангийн сурагчдын тоо (Хүснэгт 25) ба хэдэн ангид хичээл заадаг болохыг асууж тодруулав. Нийт багшийн 98 хувь нь даасан ангидаа л

хичээл заадаг бол үлдсэн 2 хувь нь багын 26 хүртэлх анги, бүлэгт хичээл заадаг байгаагаас үзэхэд эдгээр нь биеийн тамир, хөгжим зэрэг мэргэжлийн багш нар байгаа юм.

Хүснэгт 27. Сурагчдын тоо (ангиар багшийн эзлэх хувь)

№	Сурагчдын тоо	I анги	II анги	III анги	IV анги	V анги	Нийт
1	10 хүртэлх	3	1	2	1	1	8
2	11-20	2	13	10	12	9	46
3	21-30	40	43	50	41	33	207
4	31-40	108	98	99	102	103	510
5	41-50	1			1		2
6	50-60	4	8	6	10	7	35
	Нийт	158	163	167	167	153	<b>808</b>


Хүснэгт 27-оос харахад судалгааны асуулгад хариулсан нийт багшийн 207 буюу 25 хувь нь 21-30 сурагчтай, 510 буюу 63 хувь нь 31-40 сурагчтай, харин 37 буюу 4.5 хувь нь 41-ээс дээш-60 хүртэлх тооны сурагчтай (өндөр ачаалалтай) хичээллэдэг байна. Ялангуяа, 12 багш 50-иас дээш сурагчтай 1 ба 2-р ангитай байгаа юм.

### 3.2.2. Үндсэн асуулга

#### 3.2.2.1. Төгсөгчдийн сэтгэл ханамж

“Багш, бага боловсрол” мэргэжлээр сурч төгссөн төгсөгчийн хувьд судалгаанд хамрагдсан багш нараас “Бага ангийн багш мэргэжлээр сурч байх үедээ дараах зүйлд хэр сэтгэл хангалуун байсан бэ? гэсэн асуултыг асуусан ба хариултыг “сэтгэл хангалуун бус, хэлж мэдэхгүй байна, сэтгэл хангалуун” гэсэн 3 хувилбараар авсан (зураг 15).


Зураг 15. Багш мэргэжлээр төгсөгчийн сэтгэл ханамж (хувь)



Төгсөгчдийн хариултаас харахад сургалтын хэрэглэгдэхүүн, техник тоног төхөөрөмжийн хүртээмж, багш бэлтгэх сургалтын хөтөлбөр болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн уялдаа гэсэн сургуулийн 2 хүчин зүйлд 50-иас бага хувийн сэтгэл ханамжтай, бусад үзүүлэлтүүдэд 50 ба түүнээс дээш хувийн сэтгэл хангалуун байдгаа илэрхийлсэн байна. Харин бага хувийн сэтгэл ханамжтай гэж хариулсан дээрх 2 хүчин зүйлээс гадна сургалтын анги танхимын хүрэлцээ, тохижилт; сургалтын хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг чадвар ба ажлын байрны үндсэн чиг үүргийн нийцэл гэсэн хүчин зүйлийн нөлөөнд сэтгэл хангалуун бус байдаг гэжээ.

Судалгаанд хамрагдсан багш нараас багш, бага боловсролын хөтөлбөрт байдаг хичээлүүдээр олгогдсон мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхийг хүссэн ба дараах хариултыг (Зураг 16) өгсөн байна.

Зураг 16. Хичээлүүдээр олгосон мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээ




Зураг 16-д “дунд” ба “сайн” гэсэн үнэлгээтэй хариулт бусад үнэлгээнээс өндөр байгаа тул хариултын тоог дан тооллоор харууллаа. Багш нарын 53-аас 76 хувь нь хичээлүүдээр олгосон мэдлэг, чадвар, хандлагыг “сайн, маш сайн” гэжээ. Ялангуяа танилцах (71 хувь), туршин заах (72.1 хувь), багшлах дадлага (76.2 хувь)-ын хичээлүүдийг хамгийн өндөр хувьтай “сайн, маш сайн” гэж үнэлжээ. Эх хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухааны арга зүйн хичээлүүд нь онолын хичээлээс бага хэлбэлзэлтэй боловч доогуур үнэлэгдсэн, харин “дунд” гэсэн үнэлгээнд эзлэх хувиараа байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлүүд бусад хичээлээс өндөр хувьтай гарсан байна. Багш нарын “маш муу, муу гэсэн” үнэлгээ хамгийн ихдээ 11 хувь байгаа ба энд, байгалийн ухаан (онол, дадлага), нийгмийн ухааны (онол, дадлага) хичээлүүд орсон байна.

### 3.2.2.2. Багш, бага боловсролын сургалтын хөтөлбөр

Сургалтын хөтөлбөртэй холбоотой гэж үзэж болох дараах 2 асуулгыг асуусан:

1. Багш, бага боловсрол сургалтын хөтөлбөрт агуулгын ямар өөрчлөлт хийх шаардлагатай байна?

Зураг 17. Хөтөлбөрийн агуулгын өөрчлөлт (дан тоолол)



Сургалтын хөтөлбөрийн агуулгыг гүнзгийрүүлэх, хэвээр үлдээх, багасгах шинээр баяжуулах гэсэн хувилбараар хариултын нийт багшид эзлэх хувийг авч үзвэл гүнзгийрүүлэх шаардлагатай 8.9-15.5 хувь, агуулгыг хэвээр үлдээх 21.7-32.2 хувь, агуулгыг багасгах 18-39.1 хувь, шинэ агуулгаар баяжуулах 23-42 хувьтай, хичээл бүрт харилцан адилгүй байна. Иймд аль хичээлийн агуулгыг хэрхэн өөрчлөх талаар багш нарын өгсөн саналыг ихээс бага руу нь эрэмбэлж дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 28. Сургалтын хөтөлбөрийн агуулгын өөрчлөлт (эрэмбэ, хувь)


Агуулгыг гүнзгийрүүлэх		Агуулгыг хэвээр үлдээх	
Эх хэл, арга зүй	15.7	Багшлах дадлага	32.2
Багшлах дадлага	15.5	Эх хэл, онол	31.9
Математик, арга зүй	15.3	Сэтгэл судлал	30.8
Туршин заах дадлага	14.7	Байгалийн ухаан, арга зүй	30.5
Сэтгэл судлал	14.3	Математик, онол	28.6
Эх хэл, онол	14.2	Дүрслэх урлаг, технологи, онол	26.5
Байгалийн ухаан, арга зүй	13.8	Байгалийн ухаан, онол	25.7
Байгалийн ухаан, онол	13.3	Эх хэл, арга зүй	25.5
Танилцах дадлага	12.9	Нийгмийн ухаан, арга зүй	24.6
Математик, онол	12.7	Нийгмийн ухаан, онол	24.4
Дүрслэх урлаг, технологи, арга зүй	10.7	Математик, арга зүй	23.9
Боловсрол судлал	9.3	Туршин заах дадлага	23.7
Нийгмийн ухаан, арга зүй	9.1	Танилцах дадлага	23.2
Дүрслэх урлаг, технологи, онол	8.9	Дүрслэх урлаг, технологи, арга зүй	23.1
Нийгмийн ухаан, онол	8.4	Боловсрол судлал	21.7
Агуулгыг багасгах		Шинэ агуулгаар баяжуулах	
Математик, онол	39.1	Багшлах дадлага	42.5
Нийгмийн ухаан, онол	36.3	Туршин заах дадлага	40.0
Байгалийн ухаан, онол	35.9	Танилцах дадлага	37.9
Эх хэл, онол	33.0	Сэтгэл судлал	36.9
Боловсрол судлал	32.5	Математик, арга зүй	34.8
Нийгмийн ухаан, арга зүй	30.3		

<b>Байгалийн ухаан, арга зүй</b>	<b>30.0</b>	<b>Дүрслэх урлаг, технологи, арга зүй</b>	<b>33.5</b>
<b>Дүрслэх урлаг, технологи, онол</b>	<b>29.4</b>	<b>Байгалийн ухаан, арга зүй</b>	<b>32.5</b>
<b>Математик, арга зүй</b>	<b>28.2</b>	<b>Боловсрол судлал</b>	<b>31.7</b>
<b>Эх хэл, арга зүй</b>	<b>26.7</b>	<b>Нийгмийн ухаан, арга зүй</b>	<b>29.7</b>
<b>Дүрслэх урлаг, технологи, арга зүй</b>	<b>25.4</b>	<b>Дүрслэх урлаг, технологи, онол</b>	<b>29.6</b>
<b>Сэтгэл судлал</b>	<b>24.4</b>	<b>Эх хэл, онол</b>	<b>28.2</b>
<b>Танилцах дадлага</b>	<b>20.6</b>	<b>Байгалийн ухаан, онол</b>	<b>25.0</b>
<b>Туршин заах дадлага</b>	<b>19.8</b>	<b>Математик, онол</b>	<b>25.0</b>
<b>Багшлах дадлага</b>	<b>18.1</b>	<b>Эх хэл, арга зүй</b>	<b>24.9</b>
		<b>Нийгмийн ухаан, онол</b>	<b>23.4</b>

2. Таны заадаг хичээлүүдээс аль нь хамгийн хэцүү байдаг вэ? гэсэн асуултын хариултын хувилбаруудыг авч үзье (Зураг 18).

Багш нарын үзэж буйгаар заахад амархан, эсвэл дунд зэрэг гэсэн хариултын эзлэх хувь ойролцоо ба бусад хариултаас их байна. Хүн ба орчин, хүн ба байгаль, дуу хөгжим, биеийн тамир хичээлүүдийг заахад “хэцүү”, “маш хэцүү” гэсэн хариултын нийлбэр хувь нь бусад хичээлээс өндөр (24-45 хувь) байна.

Зураг 18. Заахад хүндрэлтэй хичээл (хувь)



Эдгээр хичээлийг заахад яагаад хэцүү, маш хэцүү байдаг шалтгааныг тодруулах үүднээс *Багш, бага ангийн боловсрол сургалтын хөтөлбөрт агуулгын ямар өөрчлөлт хийх шаардлагатай байна?* гэсэн өмнөх асуултын хариулттай (Зураг 17) харьцуулалт хийж үзэхэд нэг талаас,

- Дуу хөгжим, биеийн тамирын хичээлийн агуулга бага боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт огт байхгүй;
- Байгалийн ухаан, нийгмийн ухааны онолын агуулгыг багасгах, шинэ агуулгаар баяжуулах гэсэн хариултын хувь харьцангуй дээгүүр эрэмбэлэгдсэн байгаатай холбоотой байж болно.


Нөгөө талаар, бага боловсролын хүн ба орчин, хүн ба байгаль хичээлүүдийн бага боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн

агуулгуудын хоорондын уялдаа холбоо сул байж болох талтай юм. Иймд асуудлын энэ сул талыг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

### 3.2.2.3. Бага ангийн багшиуд тулгамдаж буй бэрхшээл

Энэхүү судалгаанд бага ангийн багшийн ажлын байранд тулгамдаж буй бэрхшээлүүдийг тодруулах асуулга тавьсан бөгөөд бага боловсролын багш нарын хариултын хувилбаруудыг авч үзье (Зураг 19).

Зураг 19. Багшийн ажлын байранд тулгамдаж буй бэрхшээл (хувь)




Судалгаанд хамрагдсан бага боловсролын багш нарын “маш их санал нийлж байна”, “санал нийлж байна” гэсэн хариултын хувилбаруудын нийлбэр дүнгээр,

1. Эцэг эх асран хамгаалагчидтай хамтрах ажиллах, ойлголцоход хүндрэлтэй (54.1 хувь)
2. Суралцагчдын сэтгэл зүй, хөгжлийн онцлогийг оношлох, хэрэглэх чадвар дутмаг (52.5 хувь)
3. Бага ангийн хүүхэдтэй ажиллахад хүндрэлтэй (52.3 хувь)
4. Заах арга зүйн ур чадвар дутмаг (50.6 хувь)
5. Суралцахуйн үнэлгээний арга зүйн чадвар дутмаг (48.4 хувь) гэсэн бэрхшээлүүдэд хамгийн өндөр хувьтай санал нийлж байгаа аж.

Дээрх нийтлэг бэрхшээлийн эзлэх хувь өндөр байгаа нь бага боловсролын багшийн ажлын ачаалал их байгаатай холбоотой гэж үзэж байна. Бага боловсролын багшийн ажлын ачаалал их байгааг тайлбарлах зөвхөн нэг шалтгааныг авч үзвэл: Бага, дунд боловсролын салбарын 2021-2022 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд бүлэг дүүргэлтийн дундаж 29.9 хувь, бага боловсролын хувьд 32.0 хувь байхад судалгаанд хамрагдсан багш нарын 63.0 хувь нь 31-40 сурагчтай, 4.5 хувь нь 41-ээс дээш сурагчтай (Хүснэгт 25-ыг харна уу) хичээллэж байгаа явдал юм. Үүнээс шалтгаалан бага боловсролын багш сургалтын арга зүй, бага ангийн суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогийг таньж мэдэх, суралцах, ажлын байранд өөрийгөө хөгжүүлэх цаг, зав хомс байж болох юм.

Эдгээр нийтлэг бэрхшээлээс гадна бага боловсролын багш өөрийн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад хамгийн их тулгардаг ямар бэрхшээлүүд байгааг асууж, хариултын хувилбаруудыг нэгтгэв (Зураг 20).

Зураг 20. Хичээл сургалт зохион байгуулахад тулгардаг бэрхшээл



Судалгаанд хамрагдсан багш нар дээрх бүх бэрхшээл “заримдаа тохиолддог” гэж 50-иас дээш хувьтай хариулсан бол хичээл зохион байгуулалт, сургалтын арга зүй, мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, чадвар зэрэг үзүүлэлт “бэрхшээлгүй” гэж 40-48.0 хувьтай, лаборатори, сургалтын тоноглогдсон кабинет, техник хэрэгсэл, интернэт, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамж, гадаад хэлний мэдлэг дутагдалтай байдаг нь сургалтын үйл ажиллагаа явуулахад “бэрхшээлтэй” гэж 22.9-39.0 хувьтай тус тус хариулсан байна.

Бид багшаас дээрх бэрхшээлийг ямар арга замаар даван туулах боломжтой вэ гэсэн нээлттэй санал ирүүлэхийг хүссэн бөгөөд үүнд дараах арга замуудыг санал болгосон. Үүнд,


- Баг, хамт олон, удирдлагын харилцан ойлголцол, багаар ажиллах;
- Бүлэг дүүргэлтийг багасгах;
- Хичээлийн агуулгыг багасгах;
- Бичиг цаасны ажлыг багасгах;
- Багшийн үндсэн ажилд зарцуулах цагаар хангах замаар ачааллыг багасгах;
- Туслах багштай болох;
- Гадны хүчин зүйлүүдэд (техник тоног төхөөрөмж, интернэтийн хурд, хүртээмж, анги лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг гэх мэт) төрөөс бодлогоор дэмжих;
- Багш мэргэжил сонгох хүүхдийг чанаржуулах;
- Багш идэвх санаачлагатай, мэргэжилдээ дуртай, хариуцлагатай байх;
- Ажлын байрандаа хөгжих, арга зүйгээ өөрчлөх;
- Сурагчид, эцэг эхийн идэвх оролцоог нэмэгдүүлэх;
- Багш нарыг чадавхжуулах;
- Сургуулийн менежер, удирдлагатайгаа зөвлөлдөх, асуудлыг шийдвэрлэх;
- Сургуулиас дэмжлэг үзүүлэх, багшийг бүх талаар дэмжих;

- Сургалтанд хамрагдах, ажлын байран дээрээ хөгжих;
- Үе тэнгийн багш нараасаа суралцах;
- Мэрэжлийн хүнээс зөвлөгөө авах;
- Гадаад хэл бие даан судлах;
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежменттэй байх;
- Өөрийн нөхцөл боломжийг ашиглах гэжээ.

### 3.2.2.4. Бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээ

Бага ангийн багшийн хөгжих хэрэгцээг тодорхойлохын тулд багш мэргэжлээр ажиллахад чухал гэж үзэж буй чадвар, хандлагыг багш нар хэрхэн үзэж байгаа талаар асуусан бөгөөд хариултыг хувь хүний (Зураг 21) болон мэргэжлийн чадвар ба хандлага гэж 2 ангилж үр дүнг нэгтгэв.

Зураг 21. Хувь хүний чадвар ба хандлага



Зураг 21-ээс харахад “багш мэргэжлээр ажиллахад чухал” гэж тодорхойлсон хувь хүний чадвар хандлагуудыг судалгаанд хамрагдсан багш нар “чухал, маш чухал” гэж 90 ба түүнээс дээш хувьтай хүлээн зөвшөөрч, санал нэгдсэн байна. Багшийн мэргэжилд чухал шаардлагатай мэргэжлийн чадвар, хандлагуудыг “чухал, маш чухал” гэж үзсэн багш нарын хариулт дээрх үр дүнтэй яг ижил буюу 89.8-аас дээш 94.0 хүртэл хувьтай байгааг эрэмбэлж, Зураг 22-т харууллаа.


Зураг 22. Мэргэжлийн чадвар ба хандлага





Судалгаанд хамрагдсан багш нараас санал болгож буй хөгжих хэрэгцээ бий эсэх, байгаа бол хэр чухал болохыг тодорхойлохыг хүссэн бөгөөд хариултын үр дүнг Зураг 23-т харууллаа.

Зураг 23. Багшийн хөгжих хэрэгцээ



Зураг 23-ын тайлбар: 1 - Судалгаа, шинжилгээний арга зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх; 2 - Сүүлийн үеийн ном, гарын авлага, зөвлөмжөөр хангагдах; 3 - Техник, тоног төхөөрөмж ашиглах заавар, зөвлөгөө авах; 4 - Лаборатори, компьютер ашиглах, интернэтийн орчинд ажиллах; 5 - Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх; 6 - Хууль эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх; 7 - Боловсрол судлал, багшлах арга зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх; 8 - Судалгаа, шинжилгээний арга зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх; 9 - Бага насны хүүхдийн сэтгэл зүй, оношлох мэдлэг, чадвараа дээшлүүлэх; 10 - Эрдэм шинжилгээний илтгэл бичих; Мэргэжлийн ном, сурах бичиг боловсруулах; 11 - Өгөгдөл болвсруулах; 12 - Мэргэжлийн дадлага, практикийн ажлыг төлөвлөх, удирдан зохион байгуулах.


Зураг 23-аас харахад, бага насны хүүхдийн сэтгэл зүйн мэдлэг чадвараа дээшлүүлэх, техник, тоног төхөөрөмж ашиглах заавар зөвлөгөө авах, лаборатори, компьютер ашиглах, интернэтийн орчинд ажиллах, судалгаа шинжилгээний арга зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх хэрэгцээ маш чухал байдаг гэж 52.4-65.6 хувьтай хариулжээ. Багшид үүсч буй эдгээр хөгжих хэрэгцээ нь багшийн ажлын байранд тулгардаг нийтлэг бэрхшээлүүдтэй ижил төстэй байгаа юм.

Танд үүссэн хэрэгцээг ямар арга замаар “байнга” шийдвэрлэдэг вэ? гэсэн асуултад холбогдох ном сурах бичиг, гарын авлага ашигладаг гэж 55.4 хувь, интернэт болон бусад мэдээллийн хэрэгслээс хэрэгтэй мэдээллээ хайж олдог гэж 54.4 хувь, өдөр тутмын ажлаасаа туршлага хуримтлуулж, асуудлыг шийдэх боловсруулалт, дүгнэлт гаргадаг гэж 51.9 хувь тус тус хариулсан нь нийт хариултад эзлэх хувиараа өндөр байна. Харин үүсч байгаа хэрэгцээгээ “заримдаа” шийдвэрлэдэг арга замуудад туршлагатай, мэргэшсэн багш нартай зөвлөлдөж, суралцдаг гэж 63.7 хувь, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах хүсэлтээ

сургуулийн удирдлагад мэдэгдэж шийдүүлэх гэж 62 хувь хариулсан нь хамгийн өндөр хувь эзэлж байна.

Эцэст нь бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих дурдсан үйл ажиллагаа хэр ач холбогдолтой болох талаар асуусан ба багш нарын хариултыг зураг 24-т харуулав.

Зураг 24. Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа



Зургийн тайлбар: 1 – Багш нарын мэргэжилдээ хандах хандлагыг сайжруулах; 2 – Сайн туршилагыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх; 3 – Багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх; 4 – Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын талаарх ерөнхий мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх; 5 – Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 6 – Багш нарт шинэ сэдэл, тэмүүлэл төрүүлэх; 7 – Сургалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах; 8 – Суралцагчдын сэтгэл зүй, зан төлөвийг судлах, зөвлөн туслах; 9 – Сургалтын шинэ техник технологи, багаж хэрэгслийг танилцуулах, тэдгээртэй ажиллах арга зүйд сургах; 10 – Бага боловсролын талаарх олон улсын чиг хандлага, туршилагг судлахад чиглүүлэх; 11 – Арга зүйн шинэ аргуудыг турших, хэрэгжүүлэх; 12 – Сургалтын шинэ технологиудыг цаг тухай бүр судлах, ашиглах, түгээн дэлгэрүүлэх; 13 – Суралцагчдын болон өөрийнхөө нас, сэтгэхүй, хувийн онцлогийг танин мэдэх, түүнийгээ сургалтад үр дүнтэй ашиглах

Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих дээр дурдсан бүхий л үйл ажиллагааг ач холбогдолтой гэж нийт багшийн 55-67 хувь үзсэн ба багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд хамгийн өндөр хувь (67)-иар ач холбогдолтой гэжээ. Харин зарим талаараа ач холбогдолтой гэж 35.8 хувьтай хариулсан ба энэ дотроос сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын талаарх ерөнхий мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, багш нарын мэргэжилдээ хандах хандлагыг сайжруулах үйл ажиллагаа хамгийн өндөр хувь эзэлж байна.

### Бүлгийн дүгнэлт

1. Бага боловсролын багш мэргэжил эзэмшин төгссөн төгсөгчид болох бага боловсролын нийт 819 багшаас тэдний хөгжих хэрэгцээг тодорхойлох зорилгоор авсан судалгаа нь бага боловсролын багш бэлтгэх хөтөлбөрийг сайжруулах, тэдний саналыг тусгах ач холбогдолтой болно.
2. Судалгаанд хамрагдсан багш нарын ерөнхий мэдээллээс үзвэл, бүсийн төлөөллийг жигд хангасан, хөдөө орон нутаг (аймаг, сум, баг)-ийн багш нарыг түлхүү хамруулсан, насны бүх бүлгийг оролцуулсан, бага боловсролын I-Ү ангиудад хичээл заадаг багш нар оролцсон байна.
3. Судалгаанд хамрагдсан багш нарын үзэж буйгаар төгссөн сургуулийн сургалтын орчин, анги танхимын хүрэлцээ, хангамж, сургалтын хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвар,

ажлын байрны үндсэн чиг үүргийн нийцэл гэсэн үзүүлэлтүүдэд сэтгэл ханамж дундуур байгаа нь харагдлаа.

4. Төгсөгчдийн хувьд “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр олгогдсон мэдлэг, чадвар, хандлагыг сайн гэж үнэлсэн ба ялангуяа багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын дадлагын хичээлүүдээс олж авсан мэдлэг, чадвар, хандлага төлөвшил маш сайн гэж үнэлжээ.
5. Төгсөгчдийн үзэж буйгаар одоо хэрэгжиж байгаа “Багш, бага боловсрол” хөтөлбөрийн агуулгад онолын хичээлүүдийн агуулгыг багасгах, шинэ онолоор баяжуулах, арга зүйн хичээлүүдийн агуулгыг гүнзгийрүүлж, баяжуулах шаардлагатай байна.
6. Ажлын байранд гарсны дараа багш нарт заахад хэцүү, маш хэцүү хичээлүүд байдаг ба эдгээр нь дуу хөгжим, биеийн тамир гэх мэт мэргэжил шаардсан хичээлүүд, мөн хүн ба орчин, хүн ба байгаль хичээлүүд байна.
7. Бага боловсролын багшийн ажлын байранд тулгардаг нийтлэг бэрхшээлийн талаар авч үзэхэд эцэг, эх, асран хамгаалагчидтай ажиллах, суралцагчийн сэтгэл зүй, хөгжлийн онцлогийг оношлох, үр дүнг практикт хэрэглэх чадвар дутмаг, багшлахуйн болон үнэлгээний арга зүй дутмаг байдаг байна.
8. Хичээл сургалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд хамгийн их тулгардаг бэрхшээлүүдэд лаборатори, сургалтын анги танхим, техник хэрэгслийн хүрэлцээгүй байдал, гадаад хэлний бэрхшээлийг дурдсан байна.
9. Бага боловсролын багш нарын хувд ажлын байранд болон хичээл сургалтын анги танхимд тулгардаг дээрх бэрхшээлүүдийг шийдэх боломжтой гэж үзэж тодорхой саналуудыг дэвшүүлсэн болно.
10. Багш нарын хөгжих хэрэгцээ нь тэдний ажлын байранд тулгардаг бэрхшээлүүдтэй ижил утгатай байна.
11. Багш нарын хувьд суралцагчдын сэтгэл зүйг оношлох, хэрэглэх мэдлэг чадвараа дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжтэй ажиллах, судалгаа шинжилгээний арга зүйгээ сайжруулах хэрэгцээ маш чухалд тооцогдож байна.
12. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг ач холбогдолтой гэж үзэж байгаа бөгөөд тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургууль, баг, ЗАН-ийн хамтын үйл ажиллагаа, бусад мэргэжлийн болон ахмад багш нараас суралцах, туршлага солилцох үйл ажиллагаа чухал байгааг онцолж байна.

### **3.4. Ажил олгогчийн (сургалтын менежер) сэтгэл ханамжийн судалгааны үр дүн**

#### **3.4.1. Ерөнхий мэдээлэл**

Судалгаанд хамрагдсан сургуулиудын байршлыг авч үзвэл 12.1 хувь нь багийн, 36.2 хувь нь сумын төв, 28,4 хувь нь аймгийн төв, 23,3 хувь нь Улаанбаатар хотод байршилтай байна. Судалгаанд хамрагдсан сургуулиудын бага боловсролын сургалтын менежерүүдийн

ажилладаг аймаг, дүүрэг тус бүрээр авч үзвэл Баянзүрх дүүрэг 31 (12.1 хувь), Сонгинохайрхан дүүрэг 29 (11.3 хувь) Баян-өлгий аймгаас 36 (14.0 хувь), Дархан-уул 23 (8.9 хувь), Орхон 14 (5.4 хувь), Дорнод 17 (6.6 хувь), Сэлэнгэ 34 (13.2 хувь), Ховд 25 (9.7 хувь), Хөвсгөл 28 (10.9 хувь), Хэнтий 20 (7.8 хувь) тус тус эзэлж байна.


Сургуулиудыг өмчийн хэлбэрээр авч үзвэл төрийн өмчийн сургуулиуд 245 (95.3 хувь), төрийн бус өмчийн сургууль 11 (4,7 хувь) байна. Эдгээр сургуулиудын 27 (10.5 хувь) нь 1 ээлжээр, 213 (82.9 хувь) нь 2 ээлжээр 13 (5.1 хувь) нь 3 ээлжээр хичээллэж байна.

Бага боловсролын сургалтын менежерүүдийг насны бүлгээр авч үзвэл, 30 хүртэл насныхан 5 (1.9 хувь), 30-39 насныхан 53 (20.6 хувь), 40-49 насныхан 116 (45.1 хувь), 50-59 насныхан 82 (31.9 хувь) , 60- ба түүнээс дээш насныхан 1 (0.4 хувь) тус тус эзэлж байна.

Боловсролын түвшингээр авч үзвэл, бакалаврын зэрэгтэй 120 (46.7 хувь), дипломын боловсролтой 16 (6.2 хувь), магистр ба түүнээс дээш зэрэгтэй 121 (47.1 хувь) тус тус эзэлж байна.

Мэргэжлийн зэргээр авч үзвэл, заах аргач - 47 (18.3 хувь), зөвлөх - 23 (8.9 хувь), тэргүүлэх - 180 (70.0 хувь), зэрэггүй - 6 (2.3 хувь) хувьтай байна. Бага ангийн сургалтын менежерээр ажилласан хугацааг авч үзвэл, 1-10 жил ажилласан - 191 (74.3 хувь), 11-20 жил - 48 (18.7 хувь), 20-оос дээш жил - 10 (3.9 хувь) байна.

Зураг 25. Мэргэшсэн чиглэл




Бага боловсролын сургалтын менежерүүдийн мэргэшсэн байдлыг авч үзвэл монгол хэл 36.0 хувь, математик 33.6 хувь, байгалийн ухаан 11.7 хувь, нийгмийн ухаан 8.9 хувь, дүрслэх урлаг технологи 7.7 хувь, биеийн тамир 2.4 хувь, дуу хөгжим 0.8 хувь, англи хэл 2.0 хувь, мэргэшээгүй 26.3 хувь байна.

### 3.4.2. Үндсэн асуулга

Сургалтын байгууллагуудын бага ангийн багшийг сонгож авдаг аргын талаар асуулгаар тодруулахад (Зураг 27) тэдний 69.1 хувь нь мэргэжлийн мэдлэг, 60.2 хувь нь мэргэжлийн ур чадвар (заах арга зүй), 57.1 хувь нь хувь хүний хандлага, 38.2 хувь нь ажлын туршлага, 24.7 хувь нь багш дутагдалтай байгаа тул сонгон шалгаруулалтгүйгээр, 15.8 хувь нь бусад аргаар сонгон шалгаруулж авдаг гэсэн хариултыг өгчээ.

Зураг 26. Бага ангийн багш нараа сонгож авдаг арга, хэрэгсэл



Бусад аргаар гэдгийг тодруулахад ярилцлага, монгол хэлний мэдлэгийн шалгалт авах, эссэ, эх бичүүлэх, Математик, Монгол хэл, Компьютер, Англи хэлний мэдлэгийг шалгах шалгалт авах, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулалт хийлгэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, бичгийн хэв зэргийг дурджээ. Түүнчлэн ур чадварын шалгалт, компьютерийн мэдлэг, урлаг спортын авьяас, ёс зүй, ажлын туршлага, хууль эрхзүйн мэдлэг, эх хэлний мэдлэгийг шалгаж авдаг бол зарим тохиолдолд ажилдаа дур сонирхолтой эсэх, хүүхдэд хайртай эсэх, багаар хамтарч ажиллах чадвар зэргийг нэмэлт шалгуур болгодог байна.


Хүснэгт 29. Бага боловсролын багшийн чадамжид өгсөн сургалтын менежерийн үнэлгээ (ажилласан жилээр)

Хүчин зүйлс	Үнэлгээний хэмжүүр	Эхний жилдээ	1-5	6-10	11-15	16-20	21-ээс дээш жил
Өгөгдөл боловсруулах, судалгаа хийх чадвар	маш сайн	2.4	7	16.3	23.9	27.4	28.4
	сайн	15.7	27	51	48.9	48.4	49
	дунд зэрэг	47	49	25.5	20.7	17.9	17.6
	муу	26.5	13	7.1	6.5	6.3	3.9
	маш муу	8.4	4	0	0	0	1
Гадаад хэлний мэдлэг	маш сайн	2.4	1	2	4.3	4.2	3.9
	сайн	25.3	30	29.6	26.1	16.8	13.7
	дунд зэрэг	41	42	44.9	38	45.3	43.1
	муу	20.5	20	17.3	26.1	26.3	27.5
	маш муу	10.8	7	6.1	5.4	7.4	11.8
Заах аргагүй	маш сайн	0	5	16.3	34.8	55.3	53.9
	сайн	10.8	30	58.2	48.9	41.5	38.2
	дунд зэрэг	47	51	20.4	14.1	3.2	6.9
	муу	27.7	10	5.1	2.2	0	1
	маш муу	14.5	4	0	0	0	0
Багшийн ёс зүй	маш сайн	27.8	34.2	44.7	38.2	39.4	39.6
	сайн	44.4	44.7	50	52.9	42.6	39.6
	дунд зэрэг	25	21.1	5.3	8.8	17	18.8
	муу	2.8	0	0	0	1.1	1
	маш муу	0	0	0	0	0	1
Багшийн харилцаа, хандлага	маш сайн	14.5	13	28.6	32.6	40	42.7
	сайн	39.8	58	59.2	54.3	45.3	37.9
	дунд зэрэг	31.3	24	10.2	10.9	13.7	16.5
	муу	10.8	2	2	2.2	1.1	2.9
	маш муу	3.6	3	0	0	0	0
Багшийн чадамж	маш сайн	0	2.6	17.9	36.4	50.5	48.5
	сайн	18.2	34.2	61.5	48.5	41.1	41.6

	дунд зэрэг	51.5	60.5	20.5	15.2	7.4	7.9
	муу	21.2	2.6	0	0	1.1	2
	маш муу	9.1	0	0	0	0	0
<b>Онолын мэдлэг</b>	маш сайн	9.1	5.3	17.9	29.4	35.8	44.6
	сайн	18.2	44.7	69.2	67.6	53.7	44.6
	дунд зэрэг	60.6	47.4	12.8	2.9	9.5	8.9
	муу	6.1	2.6	0	0	1.1	2
	маш муу	6.1	0	0	0	0	0


Хүснэгт 29-өөс харахад, ажил олгогч, сургалтын менежерүүд 6-аас дээш жил ажилласан бага боловсролын багшийн онолын мэдлэгийг “сайн”, “маш сайн” гэсэн үнэлгээ өгсөн байна. Харин эхний жилдээ болон 5 хүртэл жил ажилласан багш нарт онолын мэдлэг хангалтгүй гэсэн үнэлгээ 14.8 хувь эзэлж байна. “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр шинээр төгсөгчдийн онолын мэдлэгийг сайжруулах, бие даан суралцах, идэвх, сэдэл бий болгох чиглэлээр олон талт төрөл бүрийн үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ажил олгогчдын үнэлгээ багш нарын ажилласан хугацаатай урвуу хамааралтай байна. Эхний жилдээ болон 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын онолын мэдлэг, багшийн чадамж, өгөгдөл боловсруулж судалгаа хийх чадвар, багшийн харилцаа, хандлага, заах арга зүй зэрэг шалгууруудад харьцангуй сул гэсэн үнэлгээг өгчээ.

Зураг 27. Бага ангийн багш бэлтгэж байгаа сургалтын хөтөлбөрт хийх шаардлагатай агуулгын өөрчлөлт



Ажил олгогчдын үзэж байгаагаар бага ангийн багш бэлтгэж байгаа сэтгэл судлал, эх хэл, арга зүй, математик, арга зүй, байгалийн ухаан, арга зүй, танилцах дадлага, туршин заах дадлага, багшлах дадлагын агуулгыг гүнзгийрүүлэх болон шинэ агуулгаар баяжуулах, боловсрол судлал, дүрслэх урлаг, технологи, арга зүйг шинэ агуулгаар баяжуулах шаардлагатай гэж үзжээ.

Зураг 28. Бага ангийн багш бэлтгэж буй дээд боловсролын сургалтын хөтөлбөр болон “Бага боловсролын сургалтын хөтөлбөр”-ийн хоорондын холбоо хамаарал




Хүснэгт 30. Багш, бага боловсрол мэргэжлийн чадамж

Ажлын байрны шаардлагууд	Огт чухал бус	Чухал бус	Хэлж мэдэхгүй байна	Чухал	Маш чухал	Хувь
Гадаад хэл	3	23	62	145	26	66.0
Тогтвор суурьшилтай ажиллах	1	6	19	106	127	90.0
Тэгш хамруулалттай холбоотой мэдлэг, чадвар	2	4	17	149	87	91.1
Тэвчээр хатуужилтай байх	2	3	13	137	104	93.1
Боловсролын бодлого, чиг хандлага, сургалтын хөтөлбөрийн мэдлэг	1	5	12	132	109	93.1
Сургах зүйн онол, түүнийг сургалтад ашиглах	1	3	14	145	96	93.1
Хамт олон болон олон нийттэй хамтран ажиллах		3	15	139	102	93.1
Судлагдахууны мэдлэг	2	1	13	96	147	93.8
Суралцагчдын онцлогт тохирсон үнэлгээний зохистой аргыг сонгох	1	3	11	124	120	94.2
Анги удирдах мэдлэг, чадвар	2	2	11	90	154	94.2
Харилцааны чадвар	1	4	9	125	120	94.6
Нягт нямбай байх	1	4	9	125	120	94.6
Эцэг, эх, асран хамгаалагчидтай үр дүнтэй, тогтмол хамтран ажиллах	1	3	10	130	115	94.6
Сургалтыг төлөвлөх, зохион байгуулах мэдлэг, чадвар		3	11	100	145	94.6
Мэдээлэл харилцаа, холбооны технологийн мэдлэг	1	4	9	132	113	94.6
Санаачилгатай байх	1	4	8	104	142	95.0
Суралцагчдын хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээг оношлох, оношилгоонд тулгуурлан тохирох арга зүйг сонгон хэрэглэх чадвар	2	3	8	111	135	95.0
Асуудал шийдэх	2	5	5	127	120	95.4
Суралцах, мэргэжлээ дээшлүүлэх сонирхолтой байх	1	4	7	118	129	95.4
Сургалтын үйл явцад суралцагчдаа идэвхжүүлэх, сэдэлжүүлэх	1	3	8	128	119	95.4
Бие даан ажиллах	1	1	9	102	146	95.8
Ажлын ачаалал даах	2	2	7	99	149	95.8

Мэдээлэл харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах	1	3	7	116	132	95.8
Хувь хүний ур чадвар	1	3	6	109	140	96.1
Мэргэжилдээ сонирхолтой байх	1	3	6	55	194	96.1
Мэргэжлийн мэдлэг, ур чадвар	2	2	6	81	168	96.1
Заах арга зүйн мэдлэг, чадвар	1	3	6	81	168	96.1
Багаар ажиллах	1	2	6	78	172	96.5
Хариуцлагатай байх		4	5	58	192	96.5
Цаг баримтлах	2	3	4	62	188	96.5
Ажлаа амжилттай гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй байх	2	2	5	77	173	96.5
Хувийн зохион байгуулалттай байх	1	4	4	101	149	96.5
Ёс зүйн хэм хэмжээг баримтлах	3	2	3	85	166	96.9

Ажил олгогчдоос мэргэжлийн болон хувь хүний эдгээр чадварууд (Хүснэгт 30)-ыг бүгдийг нь чухал гэж үзсэн ба ёс зүйн хэм хэмжээг баримтлах, бие даан ажиллах, ажлын ачаалал даах, мэдээлэл харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, хувь хүний ур чадвар, мэргэжилдээ сонирхолтой байх, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, заах арга зүйн мэдлэг, чадвар, багаар ажиллах, хариуцлагатай байх, цаг баримтлах, ажлаа амжилттай гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй байх, хувийн зохион байгуулалттай байх зэрэг чадвар, хандлагыг тэдний олонх нь чухал гэж үзсэн байна.


Зураг 29. Бага ангийн багшийн ажлын байран дээр тулгамдаж бэрхшээл



Заах арга зүй, суралцагчдын сэтгэл зүй, хөгжлийн онцлогийг оношлох, хэрэглэх чадвар, суралцахуйн үнэлгээний арга зүй, цагийн менежмент, ачаалал даах, судалгаа, шинжилгээ хийх, өгөгдөл боловсруулах зэрэг чадварууд дутмаг, мэргэжлийн мэдлэг хомс, эцэг, эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах, ойлголцоход хүндрэлтэй зэрэг нь бага ангийн багшийн ажлын байран дээр тулгамддаг гол бэрхшээл гэж ажил олгогчид үзжээ.




Зураг 30. Бага ангийн багшийн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээл



Бага ангийн багшийн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээлээр лаборатори, сургалтын тоноглогдсон кабинетын хүрэлцээ, хангамж, Техник хэрэгсэл, интернэтийн хүрэлцээ, хангамж, сургалтын хэрэглэгдэхүүн (ном, сурах бичиг, гарын авлага, түүхий эд, үзүүлэн, тоног төхөөрөмж г.м)-ий хүртээмжийг нэрлэжээ.

Зураг 31. Бага ангийн багш нарын заахад хүндэрэлтэй хичээл




Бага боловсролын багшийн заахад амархан хичээлээр “Хүн ба орчин”, “Хүн ба нийгэм”, “Дүрслэх урлаг, технологи”, “Эрүүл мэнд”, “Иргэний ёс зүйн боловсрол”-ыг нэрлэсэн бол заахад хэцүү хичээлээр “Монгол хэл”, “Математик”, “Хүн ба байгаль”, “Дуу хөгжим”, “Биеийн тамир” зэрэг хичээлүүдийг нэрлэжээ.

Зураг 32. Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа




Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой үйл ажиллагаагаар сайн туршлагыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, арга зүйн шинэ аргуудыг сонгох турших, хэрэгжүүлэх зэргийг дурджээ.

Зураг 33. Бага ангийн багш нарын хөгжих нийтлэг хэрэгцээ



Бага ангийн багш нарын хөгжих нийтлэг хэрэгцээгээр лаборатори, компьютер ашиглах, интернэтийн орчинд ажиллах, бага насны хүүхдийн сэтгэл зүй, оношлох мэдлэг, чадвараа дээшлүүлэх, боловсрол судлал, сэтгэл судлал, багшлах арга зүйн мэдлэг чадвараа дээшлүүлэх, сүүлийн үеийн ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах, шинэчлэх, судалгаа, шинжилгээний арга зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх хэрэгцээг тус тус нэрлэсэн байна.

Зураг 34. Бага ангийн багш нарт үүссэн хөгжих хэрэгцээг шийдвэрлэдэг арга зам



Бага ангийн багш нарт үүссэн хөгжих хэрэгцээг хэрхэн шийдвэрлэдэг талаар өдөр тутмын ажлаасаа туршлага хуримтлуулж асуудлыг шийдэх боловсруулалт, дүгнэлт гаргах, холбогдох ном, сурах бичиг, гарын авлага ашиглах, интернэт болон бусад мэдээллийн хэрэгслээс хэрэгтэй мэдээллээ хайж олох, туршлагатай, мэргэшсэн багш нартай зөвлөлдөх, суралцах замаар шийдвэрлэдэг гэсэн хариултын хувилбар зонхилж байна. Харин төгссөн сургуулийн багш нараас асуух, тодруулах замаар шийдвэрлэдэг гэсэн хариулт хамгийн бага хувийг эзлэж байна.

Бага ангийн багш нарт үүссэн хөгжих хэрэгцээг шийдвэрлэдэг арга зам гэсэн асуултад "Бусад" гэсэн хариултыг сонгосон сургалтын менежерүүд дараах тайлбарыг өгчээ. Үүнд:

- Ажлын байранд хөгжих:
  - Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулдаг;
  - Хэрэгцээнд суурилсан сургалт зохион байгуулдаг, өөрөө үлгэрлэн, дагалдуулан сургадаг;
  - Ажлын байран дээр сургалт авах, ЗАН-ээр ажлаа хэлэлцэх, ганцаарчилж зөвлөн туслах;
  - 1-5 жил ажиллаж байгаа залуу багш нарт зөвлөн туслах үйл ажиллагааг тогтмол явуулдаг;
- Харилцаа, хамтын ажиллагаа, судалгааны хүрээнд:
  - Тэтгэвэрт буй ахмад багш нараас суралцах;
  - Өөрийн болон бусад сургуулийн багш нарын хичээлд сууж арга зүйгээ сайжруулах;
  - Ажлын байрандаа мэргэжлийн бүлгээр хамтран ажиллаж өөрийн сайн туршлагаа бусад багш нартай хуваалцах, сайжруулах;
  - Багш нарын дундын чат группээр мэдээлэл солилцдог;
  - Харилцан туршлага судлах онолын мэдлэгийг сайжруулах, судалгаанд суурилж асуудлыг шийдвэрлэж сурах;
  - Тухайн сургуулийн залуу багш нарын хэрэгцээг тодорхойлох бөгөөд түүндээ үндэслэн арга замаа тодорхойлох;

- Хичээлийн судалгаа явуулах;
- МХХТ-ийн хүрээнд:
  - Интернетээс мэдээлэл авах;
  - Ажлын ачааллыг багасгахын тулд олон төрлийн аппликейшн ашиглахыг зөвлөдөг;
  - Цахим платформ, мэргэжлийн болон мэргэшсэн багш нараас зөвлөгөө авах, зөвлөн туслах чиглэлээр хамтран ажиллаж суралцдаг.

*“Багш, бага боловсрол” хөтөлбөрт шинээр оруулах шаардлагатай ямар хичээл, агуулга байна вэ? Яагаад?* асуултаар тодруулахад бага боловсролын сургалтын менежерүүд:

- Сэтгэлзүй харилцаа, хандлага
  - Хүүхдийг ойлгох, хайрлах, сэтгэл зүйн сургалт
  - Сэтгэл зүйн боловсрол олгох
  - Сэтгэл судлалын хичээлийг илүү сайн үзэх шаардлагатай байна.
  - Илтгэх чадвар, бусдад өөрийгөө сайнаар ойлгуулах талаас нь сэтгэл судлал илүү олон цагаар оруулах
- Ёс суртахуун, харилцаа хандлага
  - Ёс суртахуун
  - Хүний эрх, хүүхдийн эрх, хүүхдэд ээлтэй орчин гэсэн агуулга оруулах
  - Ёс зүй, харилцаа, хариуцлага, үүргийн тухай агуулгыг сургалтын хөтөлбөрт нэмэх
- МХХТ ба гадаад хэл
  - Мэдээллийн технологи, нийгэм шаардаад байна
  - МХТ, ажил хөдөлмөрийн чиг баримжаа олгох
- Мэргэжлийн хөгжил, сэтгэл ханамж
  - Хандлага, багшийн мэргэжилд дурлуулах
  - Заах арга, дадлага хийх хугацааг нэмэх
  - Одоо байгаа хөтөлбөрөө чанаржуулах, хэрэгжүүлэхэд анхаарна уу? Төгсөгчид суурь онолын мэдлэг дутмаг байдаг. Тухайлбал: Яагаад 4 жилийн хугацаанд алдаагүй зөв бичдэг болгохгүй байгаа юм бол?
  - Хүүхдийг уншуулж, бичүүлж сургах арга зүйг судлуулж сургах
  - Дидактикийн хичээлийг илүү олон кердитээр тавих, мөн танилцах дадлагын цагийн багшлах дадлагын цаг дээр нэмэх, багшлах дадлагыг илүү олон цаг оруулах
  - Олон улсын боловсрол судлал
  - 1-5-р ангийн сурагчдад олгох мэргэжлийн онолын мэдлэгтэй байх
  - Одоогийн бага ангид суралцаж буй сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын шинэлэг арга зүйд суралцах
- Ялгаатай хүүхдийн онцлогт тохирсон хөтөлбөр, агуулга
  - Түвшин ялгаатай, хоцрогдолтой хүүхэдтэй ажиллах аргазүй, мэдлэг, ур чадвар олгох
  - Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй сурагчид маш их элсэн суралцаж байна. Энэ тал дээр онцгой анхаарч ажиллах. Жишээ нь: Багш нарт дохионы хэл заах аутизмтай сонсголын бэрхшээлтэй булчингийн хэт чангаралтай гэх мэт хүүхдүүдтэй ажиллахад ямар арга, барил, эв дүй, мэдлэг, ур чадвар шаардлагатай байдаг тал дээр илүү олон цагаар заах сургаж өгөх
- Мэргэжлийн онол, аргазүйн хөгжил

- Онол, заах арга зүйн мэдлэгийг голлон анхаарах. Маш оновчтой агуулгуудыг товч тодорхой цаг үетэй уялдуулан сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна
- Монгол хэлний зөв бичих чадварыг сайжруулах,
- Бага ангийн сурагчдын сэтгэл зүй, онцлогийг оношлох судлах арга зүйг илүү оруулж өгөх
- Сэтгэл судлалын онол арга зүйг сайтар эзэмшүүлэх
- Эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх аргад суралцах хөтөлбөр агуулга оруулах
- Багш бэлтгэх сургуульд багшийн харилцаа хандлага болон мэдээлэл технологи чадварыг олгох
- Интерактив хичээлийг боловсруулах арга зүйд сургах
- Математикийн хичээлийн арга зүйг илүү гүнзгийрүүлэх
- Дадлага
  - Сайжруулсан хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн агуулга, уялдаа холбоог сайжруулах.
  - Багш мэргэжлийн үнэлэмж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, багшийн ажилд дур сонирхолтой хүүхдийг багшийн сургуульд сонгон суралцахад онцгой анхаарах
  - Онолын мэдлэгийг цэгцтэй олгож, бага ангийн сурах бичгийг судлан ажиллах ,арга зүйг эзэмшүүлсэн байх.
  - Зөв хандлагатай багш бэлтгэх.
  - Хөтөлбөр сайжруулахаас илүү багш бэлтгэдэг сургуулиудын чанарыг сайжруулахад анхаарах
  - Практик дадлагын хугацааг уртасгах.
  - Дадлагыг урт хугацаагаар хийлгэх, бичиг баримт дээр ажиллах, боловсруулах, үнэлгээний даалгавар боловсруулах чадваруудыг сайн эзэмшүүлэх
  - Багш бэлтгэх хөтөлбөрийг сайжруулах багшлах дадлагын хугацааг урт болгох
  - Дадлага маш чанартай хийх
- Элсэлт, элсэгчийн чанар
  - Шилдэг сурагчдыг багшаар бэлтгэх
  - Багш болох сэтгэлтэй сурагчдыг сонгох
  - Сурлагаар сайн хүүхдийг багшаар сургах, багшлах дадлагыг чанартай гүйцэтгүүлэх
  - Элсэлтэн дээр онцгой анхаарах багш болох хүсэл сонирхолтой зөв төлөвшил харилцаа хандлагатай тодорхой авьяас чадвартай тийм хүнд л тухайн хөтөлбөрийг эзэмшүүлэх нь зөв.
  - ЭЕШ-ын өндөр оноотой хүүхэд элсүүлэх
  - Ажилдаа дуртай хүнийг л багш болгох. Мөн онолын мэдлэг сайтай байхад аяндаа заах арга зүй туршлагыг өөрөө бий болгоно
  - Багш болох шалгуурыг өндөрсгөх, хичээл сургалтын чанарыг сайжруулах
  - Хамгийн гол нь бага ангийн багш мэргэжилдээ дур сонирхолтой ачаалал даах чадвартай л болгох
  - Мэргэжлийн ур чадвар, сэтгэл хоёулаа маш чухал байна
- Сургалты чанар, үр өгөөж

- Үндэсний цөөнх гэгдэх казах хүүхэдтэй ажиллах багш, хүний нөөцийг бэлтгэх
- Багш бэлтгэдэг багш нар маань өөрсдөө заах арга ур чадвараа байнга дээшлүүлэх, өнөө цагийн шаардлага эрэлт хэрэгцээнд нийцсэн төгсөгч гаргахад түлхүү анхаарах хэрэгтэй байх
- Багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөр, чанарт анхаарах
- Бага боловсролын сурах бичгийн агуулга, дээд боловсролын онолын агуулгыг тулгаж харах шаардлагатай. Онолыг багасгаж, практик дадлага маш сайн хийлгэж, бодит байдлыг судлах тал дээр илүү анхаарах
- Багш бэлтгэж байгаа суруулиуд багшийн чанарт анхаарч чадварлаг багш бэлтгэх, урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж багшийн хөтөлбөрийг тогтвортой болгох
- Онолын мэдлэг сайтай байхаас гадна ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг байх
- Мэргэжлийн онол, арга зүйн сургалтыг чанарт анхаарах
- Сургалтын хөтөлбөрийг нэгдсэн нэг чиглэлтэй, багшийг сургуульд өндөр шалгуураар үнэ төлбөргүй бэлтгэх, мөн цалинг нэмж, ачааллыг бууруулах

## **Бүлгийн дүгнэлт**

Сургалтын байгууллагууд бага ангийн багш нараа сонгож авахдаа мэргэжлийн мэдлэг, ур чадвар (заах арга зүй), хувь хүний хандлага зэргийг гол шалгуураа болгож байна.

Бага ангийн багш бэлтгэж байгаа сургалтын хөтөлбөр дэх сэтгэл судлал, боловсрол судлал, эх хэл, математик, дүрслэх урлаг, байгалийн ухааны заах арга зүй, бүх хэлбэрийн дадлагуудыг агуулга, арга зүйн хувьд эрс шинэчлэл хийх, шинэ агуулгаар баяжуулах шаардлагатай байна гэж ажил олгогчдын зүгээс үзсэн байна.

Ажил олгогчдын үнэлгээ багш нарын ажилласан хугацаатай урвуу хамааралтай байна. “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгчийн чадамж, ажлын байрны шаардлагын хооронд үл нийцэл байна. Багш боловсролын багш бэлтгэж байгаа их, дээд сургуулиуд багшийн чадамж, онолын мэдлэг, өгөгдөл боловсруулалт, судалгааны ажил хийх чадвар, заах арга зүй, багшийн харилцаа, хандлага зэрэг чадамжид анхаарах, агуулга, арга зүйн шинэчлэл хийхэд анхаарах шаардлагатай нь харагдаж байна. Ажил олгогчдын олонх нь ёс зүйн хэм хэмжээг баримтлах, бие даан ажиллах, ажлын ачаалал даах, мэдээлэл харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, хувь хүний ур чадвар, мэргэжилдээ сонирхолтой байх, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, заах арга зүйн мэдлэг, чадвар, багаар ажиллах, хариуцлагатай байх, цаг баримтлах, ажлаа амжилттай гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй байх, хувийн зохион байгуулалттай байх зэрэг чадвар, хандлагыг чухал гэж үзсэн байна. Түүнчлэн заах арга зүй, суралцагчийн сэтгэл зүй, хөгжлийн онцлогийг оношлох, үр дүнг практикт хэрэглэх чадвар, суралцахуйн үнэлгээний арга зүй дутмаг байдал, эцэг, эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах, ойлголцоход хүндрэлтэй байх зэрэг нь бага ангийн багшийн ажлын байран дээр тулгамддаг гол бэрхшээл гэж ажил олгогчид үзжээ.

Бага ангийн багшийн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээлд лаборатори, сургалтын тоноглогдсон кабинетын хүрэлцээ, хангамж, техник хэрэгсэл, интернэтийн хүрэлцээ, хангамж, сургалтын хэрэглэгдэхүүн (ном, сурах бичиг, гарын авлага, түүхий эд, үзүүлэн, тоног төхөөрөмж г.м)-ий хүртээмжийг нэрлэжээ. Бага

боловсролын сургалтын байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд материаллаг орчны дэмжлэгийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Бага боловсролын багшийн заахад хэцүү хичээлээр “Монгол хэл”, “Математик”, “Хүн ба байгаль”, “Дуу хөгжим”, “Биеийн тамир” зэрэг хичээлүүдийг нэрлэжээ. Эдгээр хичээлүүдийн хөтөлбөрийн агуулга, арга зүйг шинэчлэн сайжруулах, энэ чиглэлээр суралцагчийн шинжлэх ухааны суурь ойлголт, мэдлэгийг бие даан гүнзгийрүүлэн судлах чадварыг хөгжүүлэх шаардлагатай байна. Иймд нас зүйн сэтгэц оношилгооны арга зүй, МХХТ-ийн ур чадвар олгох, судлагдахууны мэдлэгийг бага насны хүүхдэд хүргэх арга зүйн чадваруудыг олгох чиглэлээр хөтөлбөрийн агуулгыг баяжуулах, өргөсгөх, интеграцчилах хэрэгцээ шаардлага үүсч байна.

“Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгч, багш нарын хооронд эргэх холбоо сул байна. Багш бага ангийн боловсрол хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, бага боловсролын сургалтын байгууллага хоорондоо байнгын уялдаатай ажиллаж, багш солилцооны төрөл бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх, хөтөлбөрийн сайжруулалт, төгсөгчийн мэргэжлийн чадамж, ажлын байрны ур чадварыг зөрүүг арилгах чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **3.5. “Багш, бага боловсрол” хөтөлбөрөөр төгсөгч (багш) болон ажил олгогч (сургалтын менежер)-ийн асуулга судалгааны харьцуулсан үр дүн**


Тайлангийн энэ бүлэгт бид бага боловсролын багшийн болон сургалтын менежерийн асуулга судалгааны үр дүнд харьцуулсан шинжилгээ хийсэн бөгөөд үүнд, **хүчин зүйлийн** анализ, **....** коэффициентийг тооцож үзэв. Ингэхдээ түүврийн тоо харилцан адилгүй байгаа (824 багш, 259 сургалтын менежер) тул үр дүнг хувиар гарган, үзүүлэлтийг харьцуулсан болно.

#### ***Бага боловсролын багш, сургалтын менежерийн асуулгын харьцуулалт***

*Таны бодлоор Багш-бага ангийн боловсрол сургалтын хөтөлбөрт агуулгын ямар өөрчлөлт шаардлагатай вэ?* гэсэн асуултуудад хийсэн хүчин зүйлийн анализын үр дүнд,


- Эх хэл ба математикийн онол (зураг 36),
- Байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн онолын хичээлүүд (зураг 37),
- Эх хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн арга зүйн хичээлүүд (зураг 38),
- Танилцах, туршин заах, багшлах дадлагын бүх хичээлүүд (зураг 39) төгсөгч (багш) ба ажил олгогч (сургалтын менежер)-ийн хариултуудаар “харьцуулах боломжтой”, боловсрол судлал, сэтгэл судлал хичээлүүд “харьцуулах боломжгүй” үр дүн гарсан байна.

*Зураг 35. Эх хэл, онол ба математик, онол хичээлүүдийн харьцуулалт*



Зураг 35-аас харахад эх хэл ба математикийн онолын хичээлүүдийн агуулгыг гүнзгийрүүлэхийг сургалтын менежерүүд багш нараас илүүд (ялгаа нь 13.6 ба 15.9 хувь) үзэж байгаа бол эдгээр хичээлийн агуулгыг багасгах гэдэгт эсрэгээрээ (ялгаа нь 15.6 ба 14.8 хувь) бага хувийн саналтай байгаа юм. Харин эдгээр хичээлийн онолын агуулгыг хэвээр үлдээх, шинэ агуулгаар баяжуулах шаардлагатай гэдэгт багш, сургалтын менежерүүдийн хооронд саналын ялгаа бага, ойролцоо байна.


Зураг 36. Байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн онол хичээлүүдийн харьцуулалт



Зураг 36-оос харахад байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн онолын хичээлүүдийн агуулгыг гүнзгийрүүлэх, хэвээр үлдээх шаардлагатай гэдэгт сургалтын менежерүүд багшаас бага боловч илүү саналын хувьтай үзэж байгаа ба тэд агуулгыг хэвээр үлдээх гэдэгт бусад хариултын хувилбараас өндөр санал өгсөн байна. Дээрх хичээлүүдийн агуулгыг багасгах, шинэ агуулгаар баяжуулах гэдэгт багш нар сургалтын менежерүүдээс бага боловч илүү саналтай байна.

Зураг 37. Эх хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн арга зүйн хичээлүүдийн харьцуулалт (давхар тоолол)






Багш, бага боловсрол сургалтын хөтөлбөрийн эх хэл, математик, байгалийн ухаан, дүрслэх урлаг-технологийн арга зүйн хичээлүүдийн агуулгыг шинээр баяжуулах шаардлагатай гэж багш, сургалтын менежерүүд ойролцоо хувьтай үзсэн. Гэхдээ эх хэлний арга зүйн хичээлд өгсөн багш нарын санал хамгийн бага (24.9 хувь) байгаа бол сургалтын менежерүүд түүнээс 12.9 хувиар илүү саналаар дэмжсэн байна. Эдгээр хичээлийн агуулгыг хэвээр үлдээх гэдэгт багш, сургалтын менежерүүд мөн л ойролцоо хувьтай санал нийлж байна.

Эх хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг технологийн арга зүйн хичээлүүдийн агуулгыг багасгах шаардлагатай гэж багш нар 25.4-өөс 30.3 хувийн саналтай байгаа бол сургалтын менежерүүдийнх тэднээс бага (7.3-аас 14.6 хувь) байна. Харин арга зүйн хичээлүүдийн агуулгыг гүнзгийрүүлэх шаардлагатай гэж судлагдахуун бүрээр өгсөн багш нарын саналаас сургалтын менежерүүдийнх 11-17 хувиар илүү байна.

Зураг 38. Танилцах, туршин заах, багшлах дадлагуудын харьцуулалт



Зураг 38-аас харахад танилцах, туршин заах, багшлах дадлагуудын агуулгыг гүнзгийрүүлэхэд багш, сургалтын менежерүүдийн өгсөн саналын зөрүү бусад хариултын хувилбарууд (агуулгыг хэвээр үлдээх, багасгах, шинээр баяжуулах)-аас өндөр байна. Сургалтын менежерүүд 32-39.3 хувьтай агуулгыг гүнзгийрүүлэхийг дэмжиж байгаа бол багш нар 12.9-15.5 хувьтай байна. Эдгээр дадлагын хичээлүүдийн агуулгыг багасгах гэдэгт багш нарын өгсөн хариултын хувь сургалтын менежерүүдийнхээс 11-13 хувиар өндөр байна.


Багш нарын хувьд дадлагын хичээлүүдийн агуулгыг шинээр баяжуулах шаардлагатай гэж 38-42.5 хувьтай дэмжиж байгаа бөгөөд ялангуяа багшлах дадлагад түлхүү санал өгсөн байна. Дадлага хичээлүүдийн агуулгыг хэвээр үлдээх гэсэн хариултад багш, сургалтын менежерүүд ойролцоо (17.4-29.7) хувьтай хариулжээ.

- *Бага ангийн багш мэргэжлээр ажиллахад дараах чадвар, хандлага хэр чухал гэж Та үзэж байна вэ?* гэсэн асуултад төгсөгч, ажил олгогчдын хариулсан байдлыг харьцуулахдаа тус судалгааны багаас боловсруулж буй “Багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээ” (зураг 7)-ний 4 айд хамаатуулан чадвар, хандлагуудыг ангилсан.

Энэхүү судалгаанд мэдлэг, ойлголтоос илүүтэй чадвар, хандлагатай холбоотой асуулгууд орсон учраас мэдээлэл, харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах гэсэн чадвараас бусад нь “мэдлэг, ойлголт” айд хамааралгүй гэж үзэв. МХХТ-ийг сургалтад ашиглах чадварт багш, сургалтын менежерүүд 94.2, 95.7 хувьтай “чухал” гэдэгт санал нэгдсэн. Багшлахуй ба суралцахуй айн хүрээнд хамаарах чадвар, хандлагад “асуудал шийдвэрлэх”, “мэргэжилдээ сонирхолтой байх” гэсэн асуулгын хариултыг нэгтгэсэн ба сургалтын менежерүүд “мэргэжилдээ сонирхолтой байх” гэсэн асуулгын хувилбарыг багш нараас илүүтэй чухал гэж үзжээ. Асуудал шийдвэрлэх чадварт судалгаанд оролцогч талууд санал нэгтэй чухал гэж өндөр хувьтай хариулсан. Багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээнд 3 дахь буюу “Хамтын ажиллагаа” айн хүрээнд асуулгын “багаар ажиллах”, “харилцааны чадвар” гэсэн чадваруудыг үнэлүүлсэн бөгөөд багш, сургалтын менежерүүд мөн л 93-аас дээш хувьтай чухалд тооцож байна.

Судалгааны багаас боловсруулсан багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээний 4 дэх буюу “мэргэжлийн хөгжил, үнэт зүйл” айн хүрээнд өөрийгөө эргэцүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжил, мэргэжлийн дэмжлэг, үнэт зүйлс хандлага гэсэн 4 чадамж багтаж байгаа бөгөөд “өөрийгөө эргэцүүлэх”, “үнэт зүйлс хандлага”-тай холбоотой асуултууд багш, сургалтын менежерүүдэд нэлээн чухал байрыг эзэлж байна (зураг 39).

Зураг 39. Мэргэжлийн хөгжил, үнэт зүйл айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн




Зураг 39-өөс харахад багш, сургалтын менежерүүдийн аль аль нь багш мэргэжлийн хөгжлийн асуудлыг өндрөөр үнэлж, чухалд тооцож байгаа бөгөөд үүнд “ажлаа амжилттай гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй байх”, “суралцах, мэдлэгээ дээшлүүлэх сонирхолтой байх”, “ёс зүйн хэм хэмжээг баримтлах” гэсэн үнэт зүйл, хандлагын эерэг байдал ч хамаатай юм. Харин судалгаанд оролцсон багш, сургалтын менежерүүд гадаад хэлний мэдлэгтэй

холбоотой асуултад бусад асуултаас бага хувьтай “чухал” гэж хариулсан ба “хэлж мэдэхгүй” гэсэн хариултын эзлэх хувь бага зэрэг нэмэгдсэн байна.


- *Бага ангийн багшийн ажлын байранд тулгарч байгаа дараах бэрхшээлүүдтэй та санал нийлж байна уу?* гэсэн асуултын хариултын үр дүнг харьцуулахдаа судалгааны багаас боловсруулсан багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээний дагуу асуулгын хариултыг нэгтгэв (зураг 40, 41, 42, 43).

Зураг 40. Мэдлэг, ойлголт айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн




Судалгааны үр дүн (зураг 40)-ээс харахад мэдлэг, ойлголт айн хүрээнд багшийн мэргэжлийн мэдлэг хомс, судалгаа, шинжилгээ хийх, өгөгдөл боловсруулах чадвар дутмаг гэсэн бэрхшээлүүдтэй сургалтын менежерүүд 60-аас дээш хувьтай санал нийлж байгаа бол багш нарын “санал нийлж байна”, “санал нийлэхгүй” гэсэн байр суурийг илэрхийлсэн хариултын хувь төдийлөн бага биш (30-40-өөс дээш хувь), ойролцоо хувьтай байна.

Зураг 41. Багилахуй ба суралцахуй айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн




*Багилахуй ба суралцахуй айд төлөвлөлт, багилахуй, сурацлахуйг дэмжих, тэгш хамруулалт, үнэлгээтэй холбоотой чадамжуудыг багтаасан (зураг 7-г харна уу) ба эдгээр чадамжтай холбоотой багшийн ажлын байранд тулгардаг бэрхшээлүүдийн талаар багш нар 50 орчим хувь, сургалтын менежерүүд (бага ангийн хүүхэдтэй ажиллахад хүндрэлтэй гэсэн бэрхшээл бий гэж багш нартай ойролцоо хувьтай санал нийлснийг эс тооцвол) 70-80 хувьтай санал нийлж байгаа ажээ. Гэвч эдгээр бэрхшээл байгаатай санал нийлэхгүй гэж багш нарын 30 орчим хувь үзэж байна.*

Зураг 42. Хамтын ажиллагаа айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн



Энэхүү айн хүрээнд багш, сургалтын менежерүүдийн аль аль нь хамгийн өндөр хувьтай санал нийлж байгаа бэрхиээл бол эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах, ойлголцоход хүндрэлтэй байдаг явдал бөгөөд удаах бэрхиээлд сургуулийн удирдлага, хамт олонтой хамтран ажиллах, ойлголцоход хүндрэлтэй байдаг бэрхиээлүүд орж байна. Иймд эдгээр бэрхиээлийг бууруулах, багшийн эдгээр чадвар, чадамжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь анхаарах асуудлын нэг болж байна.

Зураг 43. Мэргэжлийн хөгжил, үнэт зүйл айн хүрээнд хамаарах асуулгын үр дүн



Мэргэжлийн хөгжил, үнэт зүйлийн айн хүрээнд сургалтын менежер буюу ажил олгогчийн үзэж буйгаар цагийн менежмент, ажлын ачаалал даах чадвар дутмаг гэсэн бэрхиээлийг онцолсон байх ба судалгаанд хамрагдсан нийт менежерийн 60-70 хувь нь бүрэн санал нийлсэн байна. Багш нар буюу төгсөгчийн хувьд эдгээр бэрхиээлүүдтэй ойролцоо (40 ба түүнээс дээш) хувьтай санал нийлж байгаагаа илэрхийлсэн бол санал нийлэхгүй гэж үзсэн багш нарын хувь санал нийлж буй багш нартай бараг адил хувьтай (бага зөрөөтэй) байна.


- Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад Танд хамгийн их тулгардаг бэрхиээлийг үнэлнэ үү? гэсэн асуултад багш, сургалтын менежерийн хариулсан байдлын ялгааг багшийн цогц чадамжийн агуулгын хүрээн 2 дахь ай буюу багшлахуй ба суралцахуйн айн хүрээнд авч үзэв (хүснэгт 31).

Хүснэгт 31. Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхиээл

Үйл ажиллагаа	Бэрхшээлгүй		Заримдаа		Бэрхшээлтэй	
	Багш	Сур. мен	Багш	Сур. мен	Багш	Сур. мен
Хичээлийн бэлтгэл	28.8	17.76	59.5	66.80	11.8	15.44
Хичээл зохион байгуулалт	48.1	38.61	46.5	52.51	5.5	8.88
Сургалтын арга зүй	40.5	18.92	51.2	58.30	8.3	22.78
Сургалтын баримт бичиг	26.1	21.62	51.0	52.51	22.9	25.87
Мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, чадвар	40.7	13.51	52.9	60.23	6.4	26.25
Суралцагчийн харилцаа, хандлага	35.0	23.94	50.0	54.83	15.0	21.24
Гадаад хэлний мэдлэг, хэрэглээ	20.5	14.67	56.4	55.21	23.1	30.12
Сургалтын хэрэглэгдэхүүн (ном, сурах бичиг, гарын авлага, түүхий эд, үзүүлэн, тоног төхөөрөмж г.м)-ий хүргээмж	20.5	16.60	49.8	45.17	29.7	38.22
Лаборатори, сургалтын тоноглогдсон кабинетын хүрэлцээ, хангамж	15.4	10.42	45.6	32.05	39.0	57.53
Техник хэрэгсэл, интернэтийн хүрэлцээ, хангамж	18.8	13.90	44.2	38.22	37.0	47.88
Үнэлж дүгнэх үйл ажиллагаа	25.1	15.44	54.7	66.02	20.1	18.53

Судалгаанд хамрагдсан багш нарын хичээлийн бэлтгэл, сургалтын арга зүй, мэргэжлийн онол, арга зүйн мэдлэгт бэрхшээлгүй гэж хариулсан хувиас сургалтын менежерүүдийн хариулт 11-27 хувиар бага хувьтай (энэ хэмжээгээр бэрхшээлтэй гэж) хариулсан. Мөн лаборатори, сургалтын тоноглогдсон кабинетын хүрэлцээ хангамжийг багш нар “бэрхшээлтэй” гэж үзсэн хувиас сургалтын менежерүүдийн хариулт 18.5 хувиар илүү байна.


Зураг 44. Бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээ



Багш болон сургалтын менежерүүд бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээг сүүлийн үеийн ном, гарын авлага, зөвлөмжөөр хангагдах, лаборатори, компьютер ашиглах,

интернэтийн орчинд ажиллах, боловсрол судлал, багшлах арга зүйн мэдлэг чадвараа дээшлүүлэх, бага насны хүүхдийн сэтгэл зүй, оношлох мэдлэг, чадвараа дээшлүүлэх зэргийг хамгийн чухал гэж авч үзсэн байна. Эрдэм шинжилгээний илтгэл бичих хэрэгцээг менежер болон багш огт чухал бус гэсэн хариултын хувилбар дээр санал нийлсэн байна.

Харин багш нар өгөгдөл боловсруулах, мэргэжлийн дадлага, практикийн ажлыг төлөвлөх, удирдан зохион байгуулахыг заримдаа чухал гэж үзсэн бол сургалтын менежерүүд хууль эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх хэрэгцээг заримдаа чухал гэж үзсэн байна.



Үүссэн хэрэгцээг шийдвэрлэдэг арга замын талаар тэдний хариултын хувилбар хоорондоо нийцтэй байна. Интернэт болон бусад мэдээллийн хэрэгслээс хэрэгтэй мэдээллээ хайж олох, холбогдох ном, сурах бичиг, гарын авлага ашиглах, өдөр тутмын ажлаасаа туршлага хуримтлуулж асуудлыг шийдэх боловсруулалт, дүгнэлт гаргах зэргийг байнга, туршлагатай, мэргэшсэн багш нартай зөвлөлдөх, суралцах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах хүсэлтээ сургуулийн удирдлагад мэдэгдэж, шийдүүлэх, төгссөн сургуулийн багш нараас асуух, тодруулах замаар заримдаа хөгжлийн хэрэгцээг шийдвэрлэдэг гэсэн ижил хариултыг өгсөн байна.


Хүснэгт 32. Заахад хүндрэлтэй хичээл (хувь)

Хичээл	Амархан		Дунд зэрэг		Хэцүү	
	Багш	Менежер	Багш	Менежер	Багш	Менежер
Монгол хэл	44.7	33.46	39.1	42.52	16.3	24.0
Математик	53.6	29.80	35.4	45.49	10.9	24.7
Хүн ба орчин	10.3	56.47	43.9	37.65	45.1	5.9
Хүн ба байгаль	31.9	23.74	43.9	41.25	24.2	35.0
Хүн ба нийгэм	49.9	50.00	40.9	42.58	9.2	7.4
Дүрслэх урлаг, технологи	49.0	41.18	39.3	41.96	11.7	16.9
Эрүүл мэнд	49.8	44.31	38.5	42.35	11.8	13.3
Иргэний ёс зүйн боловсрол	64.0	68.09	31.0	26.46	5.0	5.4

Дуу хөгжим	32.5	26.32	37.4	36.84	30.1	36.8
Биеийн тамир	35.0	37.60	38.1	35.20	26.9	27.2
Бусад	41.4	51.04	40.4	34.38	18.2	14.6

Багш, менежерийн бодлоор заахад амархан “Хүн ба нийгэм” “Иргэний ёс зүйн боловсрол”, “Эрүүл мэнд” зэрэг хичээл бол, багш нарынхаар “Математик”, “Дүрслэх урлаг, технологи” сургалтын менежерүүдийн бодлоор “Хүн ба орчин” гэсэн хариултыг сонгосон нь өөр хоорондоо ялгаатай байлаа. Харин заахад хэцүү хичээлээр тэд “Хүн ба байгаль”, “Дуу хөгжим”, “Биеийн тамир”-ын хичээлийг адилхан нэрлэсэн бол сургалтын менежерүүдийн амархан гэж үзсэн “Хүн ба орчин” хичээлийг багш нар заахад хэцүү гэж үзсэн байна. Мөн багш нарын заахад амархан гэж үзсэн математикийн хичээлийг сургалтын менежерүүд заахад хэцүү гэж үзсэн байна.

Зураг 45. Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа



Бага боловсролын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг сайн туршлагыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, арга зүйн шинэ аргуудыг сонгох турших, хэрэгжүүлэх эзргийг чухал ач холбогдолтой гэж багш, менежерүүд санал нийлсэн байна. Харин багш нарын мэргэжилдээ хандах хандлагыг сайжруулах ач холбогдолтой гэж менежерүүд үзсэн байгаа нь багш нараас ялгаатай байна.

## Бүлгийн дүгнэлт

Багш, бага боловсрол мэргэжлийн сургалтын хөтөлбөртэй холбоотой төгсөгч, ажил олгогчийг хамруулсан судалгааны үр дүнг харьцуулан авч үзэхэд,

- эх хэл, математикийн онолын хичээлүүдийн агуулгыг гүнзгийрүүлэх шаардлагатай гэж ажил олгогчид, харин агуулгыг багасгах шаардлагатай гэж төгсөгчид тус тус үзжээ.
- Байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн онолын хичээлүүдийн агуулгыг хэвээр үлдээх гэж сургалтын менежерүүд багш нараас илүү саналтай байгаа бол агуулгыг багасгаж, шинэ агуулгаар баяжуулах шаардлагатай гэдэгт төгсөгчид ажил олгогчоос илүү саналтай байна.
- Эх хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, дүрслэх урлаг-технологийн арга зүйн хичээлүүдийн хувьд агуулгыг шинээр баяжуулах шаардлагатай гэдэгт төгсөгч, ажил олгогчид санал нэгтэй байгаа юм.
- Сургалтын хөтөлбөрийн дадлагын хичээлүүдийн агуулгыг гүнзгийрүүлэх гэдэгт ажил олгогчид, агуулгыг шинээр баяжуулах гэдэгт төгсөгчид түлхүү саналтай дэмжсэн байна.

Бага боловсролын багш мэргэжилтний чадвар, хандлагын үр дүнг нэгтгэхдээ судалгааны багаас боловсруулсан багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээний 4 айн хүрээнд судалгааны асуулгуудыг ангилан авч үзсэн бөгөөд тус чадамжийн хүрээний “мэргэжлийн хөгжил, үнэт зүйлс-хандлага” гэсэн 4 дэх айн “өөрийгөө эргэцүүлэх”, “үнэт зүйлс, хандлага” гэсэн цогц чадамжтай холбоотой асуулга нь төгсөгч, ажил олгогчдод чухал байр эзэлж, хамгийн өндөр хувьтай санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн юм.

Бага боловсролын багшийн ажлын байранд тулгардаг бэрхшээлүүдийг мөн л дээрх цогц чадамжийн хүрээгээр ангилж үзэхэд,

- Мэдлэг, ойлголт гэсэн 1 дэх айн хүрээнд төгсөгчдийн МХХТ-ийг ашиглах чадвар дутагдалтай, судалгаа шинжилгээ хийх, өгөгдөл боловсруулах чадвар дутмаг гэж ажил олгогчид өндөр хувийн саналтай байгаа бол
- “Багшлахуй ба суралцахуй” айн хүрээнд багтах заах арга зүй, суралцахуйн үнэлгээний арга зүй, суралцагчдын сэтгэл зүй хөгжлийн онцлогийг оношлох, хэрэглэх чадвар, бага ангийн хүүхэдтэй ажиллах чадвар дутмаг бөгөөд ажлын байранд тулгардаг бэрхшээлүүд юм гэж ажил олгогчид өндөр хувьтай хариулсан.
- “Ххамтын ажиллагаа” гэсэн 3 дахь айн хүрээнд эцэг эх, асран хамгаалагчид болон сургуулийн удирдлага, хамт олонтой хамтран ажиллах, ойлголцоход хүндрэлтэй гэсэн бэрхшээлийг ажил олгогч, төгсөгчдийн аль аль нь хамгийн өндөр хувиар санал нэгтэй байгаа юм.
- Мэргэжлийн хөгжил, үнэт зүйлийн айн хүрээнд багш нарын цагийн менежмент, ажлын ачаалал даах чадвар дутмаг гэдэгтэй бүрэн санал нийлсэн хувь харьцангуй өндөр байна.

Хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээлүүдийг багшийн цогц чадамжийн агуулгын хүрээний 2 дахь айд багтах багшлахуй ба суралцахуйн чадамжтай холбон авч үзсэн бөгөөд ажил олгогчдын үзэж буйгаар багш нарын хичээлийн бэлтгэл, сургалтын арга зүй, мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг бэрхшээл үүсгэж буйг бусад хариултаас өндөр хувьтай хүлээн зөвшөөрсөн ба сургалтын орчинтой холбоотой лаборатори, сургалтын тоноглогдсон анги кабинет, техник хэрэгсэл, интернэтийн хүрэлцээгүй байдал бэрхшээлтэй гэж төгсөгч болон ажил олгогчид үзжээ.



- (n.d.). Retrieved from [https://wenku.baidu.com/view/db089e94050876323012121f.html?\\_wks](https://wenku.baidu.com/view/db089e94050876323012121f.html?_wks).
- (n.d.). Retrieved from [https://www oulu.fi/opinto-opaat/eng/OPINTO-OPAS-2200-FEdu\\_-\\_Primary\\_teacher\\_education,\\_BA\\_\(Education\)-2020-08-01-2021-07-31-2370-ENGLANTI.pdf?fbclid=IwAR0khzHPpfy-s-yyL6YKKpV9Sa2H5tdLypKT49a9GbNOBqp3LauuXCwrjZE](https://www oulu.fi/opinto-opaat/eng/OPINTO-OPAS-2200-FEdu_-_Primary_teacher_education,_BA_(Education)-2020-08-01-2021-07-31-2370-ENGLANTI.pdf?fbclid=IwAR0khzHPpfy-s-yyL6YKKpV9Sa2H5tdLypKT49a9GbNOBqp3LauuXCwrjZE)
- Abdulghani Alnoor, M. H. (2010). Yemenis Primary School Teacher Competency. *The Social Sciences*, 414-420.
- ACPA/NASPA. (2016). *Мэргэжлийн чадамжийн рубрик [ACPA/NASPA Professional Competency Rubrics]*.
- Anselm Strauss, J. M. (1990). *Basics of qualitative research: Grounded theory procedures and techniques*. Sage Publications.
- Bert Creemers, L. K. (2013). *Багшлах чанарыг дээшлүүлэх багшийн мэргэжлийн хөгжил [Teacher Professional Development for Improving Quality of Teaching]*. New-York: Springer Publishing.
- Commission, E. (2010). *Common European principles for teacher competences and qualifications*. European Commission.
- Commission, E. (2013). *Supporting teacher competence development for better learning outcomes*. European Commission.
- Jabareen, Y. (2008). A New Conceptual Framework for Sustainable Development. *Environment Development and Sustainability* 10(2), 179-192.
- Jabareen, Y. (2008). Building a Conceptual Framework: Philosophy, Definitions, and Procedure. *International Journal of Qualitative Methods*, 8(4), 49-62.
- Kunter, J. B. (2013). The COACTIV model of teachers' professional competence. In M. K. al., *Cognitive Activation in the Mathematics Classroom and Professional Competence of Teachers* (pp. 25-48). Springer.
- Kunter, J. B. (2013). The COACTIV Model of Teachers' Professional Competence. In *Cognitive Activation in the Mathematics Classroom and Professional Competence of Teachers* (pp. 25-48). New York: Springer Science+Business Media.
- OECD. (2017). *Pedagogical Knowledge and the Changing Nature of the Teaching Profession*. OECD.
- Selvi, K. (2012). Teachers' Competencies. *Cultura International Journal of Philosophy of Culture and Axiology*, 167-174.
- Thailand, T. C. (2018). *Southeast Asia Teachers Competency Framework (SEA-TCF)*. Teachers' Council of Thailand.
- TKCOM. (2018). *Global Teachers' Key Competence Framework*. TKCOM.
- UNESCO. (2019). *Teacher Policy Development Guide*. UNESCO.
- UNESCO, E. I. (2019). *Global framework of professional standards*. Educational International and UNESCO.

- Yu, A. A. (2010). Yemenis Primary School Teacher Competency. *The Social Scineces*, 414-420.
- Z.Nazeer-Ikeda, R. (2022). *Internationalization of Teacher Education and the Nation State: Rethinking Nationalization in Singapore*. Routledge.
- Zhang, Y. (2019). Learning to teach in Hong-Kong . In *Knowledge, Policy and Practice in Teacher Education: A Cross-National Study* (pp. 98-116). Bloomsbury Academic.
- Баруун Авсралийн Засгийн газрын Боловсрол, сургалтын хэлтэс. (2004). *Багшийн цогц чадамжийн хүрээ [Competency Framework for Teachers]*. Australia.
- МУБИС. (n.d.). *Ерөнхий боловсролын бодлогын зөвлөх багийн "Багшийн загвар боловсруулах" ажлын хэсгийн тайлан*. Монгол: МУБИС.
- ЭЗХАХБ. (2014). *Цогц чадамжийн хүрээ [Competency Framework]*. OECD.
- ЮНЕСКО. (2018). *ЮНЕСКО Багшийн МХТ-ийн чадамжийн хүрээ [UNESCO ICT Competency Framework for Teachers]*. Paris: UNESCO.

### Бага ангийн багш мэргэжлийн чадамж

		N		Mean	Median	Std. Deviation	Minimum	Maximum
		Valid	Missing					
Хувь хүний ур чадвар	багш	816	0	4.5	3	0.711	1	5
	менежер	257	0	2.37	3	1.495	1	5
Багаар ажиллах	багш	816	0	4.53	3	0.688	1	5
	менежер	257	0	1.98	3	1.402	1	5
Бие даан ажиллах	багш	816	0	4.5	3	0.701	1	5
	менежер	257	0	2.27	3	1.464	1	5
Ажлын ачаалал даах	багш	816	0	4.33	3	0.784	1	5
	менежер	257	0	2.24	3	1.466	1	5
Хариуцлагатай байх	багш	816	0	4.57	3	0.671	1	5
	менежер	257	0	1.75	3	1.295	1	5
Асуудал шийдэх	багш	816	0	4.41	3	0.692	1	5
	менежер	257	0	2.61	3	1.507	1	5
МХХТ-ийг сургалтад ашиглах	багш	816	0	4.47	3	0.704	1	5
	менежер	257	0	2.46	3	1.497	1	5
Гадаад хэл	багш	816	0	3.82	3	0.879	1	5
	менежер	257	0	3.53	3	1.019	1	5
Санаачилгатай байх	багш	816	0	4.45	3	0.678	1	5
	менежер	257	0	2.34	3	1.492	1	5
Тогтвор суурьшилтай ажиллах	багш	816	0	4.32	3	0.77	1	5
	менежер	257	0	2.48	3	1.482	1	5
Цаг баримтлах	багш	816	0	4.57	3	0.672	1	5
	менежер	257	0	1.8	3	1.328	1	5
Мэргэжилдээ сонирхолтой байх	багш	816	0	4.56	3	0.684	1	5
	менежер	257	0	1.74	3	1.292	1	5
Ажлаа амжилттай гүйцэтгэх хүсэл тэмүүлэлтэй байх	багш	816	0	4.47	3	0.703	1	5
	менежер	257	0	1.98	3	1.4	1	5
Суралцах, мэргэжлээ дээшлүүлэх сонирхолтой байх	багш	816	0	4.39	3	0.705	1	5
	менежер	257	0	2.49	3	1.503	1	5
Харилцааны чадвартай байх	багш	816	0	4.43	3	0.709	1	5
	менежер	257	0	2.03	3	1.421	1	5
Нягт нямбай байх	багш	816	0	4.42	3	0.713	1	5
	менежер	257	0	2.58	3	1.495	1	5
Хувийн зохион байгуулалттай байх	багш	816	0	4.48	3	0.7	1	5
	менежер	257	0	2.26	3	1.492	1	5
Ёс зүйн хэм хэмжээг баримтлах	багш	816	0	4.5	3	0.692	1	5
	менежер	257	0	2.05	3	1.427	1	5
Тэвчээр хатуужилтай байх	багш	816	0	4.32	3	0.751	1	5
	менежер	257	0	2.74	3	1.459	1	5
Мэргэжлийн мэдлэг, ур чадвар	багш	816	0	4.53	3	0.681	1	5
	менежер	257	0	2.03	3	1	1	5
Судлагдахууны мэдлэг	багш	816	0	4.47	3	0.684	1	5
	менежер	257	0	2.25	3	1.446	1	5
Заах арга зүйн мэдлэг, чадвар	багш	816	0	4.4	3		1	5
	менежер	257	0	2.04	3	1.429	1	5
Боловсролын бодлого, чиг хандлага, сургалтын хөтөлбөрийн мэдлэг	багш	816	0	4.39	3	0.684	1	5
	менежер	257	0	2.7	3	1.481	1	5
Суралцагчдын хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээг оношлох, тохирох арга зүйг сонгон хэрэглэх чадвар	багш	816	0	4.27	3	0.709	1	5
	менежер	257	0	2.4	3	1.489	1	5

Сургалтын үйл явцад суралцагчдаа идэвхжүүлэх, сэдэлжүүлэх	багш	816	0	4.36	3	0.69	1	5
	менежер	257	0	2.6	3		1	5
Сургах зүйн онол, түүнийг сургалтад ашиглах	багш	816	0	4.42	3	0.735	1	5
	менежер	257	0	2.84	3	1.439	1	5
Суралцагчдын онцлогт тохирсон үнэлгээний зохистой аргыг сонгох	багш	816	0	4.36	3	0.702	1	5
	менежер	257	0	2.57	3	1.486	1	5
Эцэг, эх, асран хамгаалагчтай үр дүнтэй, тогтмол хамтран ажиллах	багш	816	0		3	0.674	1	5
	менежер	257	0	2.63	3	1.484	1	5
Хамт олон болон олон нийттэй хамтран ажиллах	багш	816	0		3		1	5
	менежер	257	0	2.76	3	1.448	1	5
Сургалтыг төлөвлөх, зохион байгуулах мэдлэг, чадвар	багш	816	0		3		1	5
	менежер	257	0	2.26	3	1.455	1	5
Анги удирдах мэдлэг, чадвар	багш	816	0		3		1	5
	менежер	257	0	2.18	3	1.443	1	5
Тэгш хамруулалттай холбоотой мэдлэг, чадвар	багш	816	0		3		1	5
	менежер	257	0	2.93	3	1.41	1	5
Мэдээлэл харилцаа, холбооны технологийн мэдлэг	багш	816	0		3		1	5
	менежер	257	0	2.68	3	1.487	1	5

### Ажлын байранд тулгардаг бэрхшээл

		N		Mean	Median	Std. Deviation	Minimum	Maximum
		Valid	Missing					
Заах арга зүйн чадвар дутмаг	багш	816	0	3.23	3	1.127	1	5
	менежер	257	0	2.98	3	1.091	1	5
Мэргэжлийн мэдлэг хомс	багш	816	0	3.02	3	1.115	1	5
	менежер	257	0	3.18	3	1.173	1	5
Суралцагчдын сэтгэл зүй, хөгжлийн онцлогийг оношлох, хэрэглэх чадвар дутмаг	багш	816	0	3.28	3	1.055	1	5
	менежер	257	0	3.08	3	1.133	1	5
Суралцахуйн үнэлгээний арга зүй дутмаг	багш	816	0	3.21	3	1.07	1	5
	менежер	257	0	3.21	3	1.142	1	5
Цагийн менежмент, ачаалал даах чадвар дутмаг	багш	816	0	3.04	3	1.155	1	5
	менежер	257	0	3.09	3	1.181	1	5
Эцэг, эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах, ойлголцоход хүндрэлтэй	багш	816	0	3.32	3	1.178	1	5
	менежер	257	0	3.24	3	1.17	1	5
МХХТ-ыг ашиглах чадвар дутагдалтай	багш	816	0	3.07	3	1.117	1	5
	менежер	257	0	3.39	3	1.117	1	5
Судалгаа, шинжилгээ хийх, өгөгдөл боловсруулах чадвар дутмаг	багш	816	0	3.12	3	1.094	1	5
	менежер	257	0	3.19	3	1.155	1	5
Гадаад хэлний мэдлэг тааруу	багш	816	0	3.25	3	1.046	1	5
	менежер	257	0	3.36	3	1.236	1	5
Сургуулийн удирдлага, хамт олонтой хамтран ажиллах, ойлголцоход хүндрэлтэй	багш	816	0	3.04	3	1.142	1	5
	менежер	257	0	3.62	3	1.122	1	5
Мэргэжилдээ сонирхолгүй	багш	816	0	2.91	3	1.191	1	5
	менежер	257	0	3.73	4	1.223	1	5
Бага ангийн хүүхэдтэй ажиллахад хүндрэлтэй	багш	816	0	3.27	3	1.221	1	5
	менежер	257	0	3.38	3	1.143	1	5
Тогтвор суурьшилтай ажиллах сонирхол бага	багш	816	0	3.09	3	1.209	1	5
	менежер	257	0	3.46	3	1.212	1	5
	менежер	257	0	2.3	3	1.354	1	5

### Хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад тулгардаг бэрхшээл

		N		Mean	Median	Std. Deviation	Minimum	Maximum
		Valid	Missing					
Хичээлийн бэлтгэл	багш	816	0	2.17	2	0.614	1	3
	менежер	257	0	2.49	3	0.781	1	3
Хичээл зохион байгуулалт	багш	816	0	2.43	2	0.595	1	3
	менежер	257	0	2.13	3	0.947	1	3
Сургалтын арга зүй	багш	816	0	2.32	2	0.62	1	3
	менежер	257	0	2.39	3	0.788	1	3
Сургалтын баримт бичиг	багш	816	0	2.03	2	0.7	1	3
	менежер	257	0	2.3	3	0.806	1	3
Мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, чадвар	багш	816	0	2.34	2	0.595	1	3
	менежер	257	0	2.47	3	0.723	1	3
Суралцагчийн харилцаа, хандлага	багш	816	0	2.2	2	0.679	1	3
	менежер	257	0	2.3	3	0.835	1	3
Гадаад хэлний мэдлэг, хэрэглээ	багш	816	0	1.97	2	0.66	1	3
	менежер	257	0	2.4	3	0.734	1	3
Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж	багш	816	0	1.91	2	0.703	1	3
	менежер	257	0	2.28	2	0.735	1	3
Лаборатори, сургалтын тоноглогдсон кабинетын хүрэлцээ, хангамж	багш	816	0	1.76	2	0.699	1	3
	менежер	257	0	2.21	2	0.616	1	3
Техник хэрэгсэл, интернэтийн хүрэлцээ, хангамж	багш	816	0	1.82	2	0.725	1	3
	менежер	257	0	2.24	2	0.682	1	3
Үнэлж дүгнэх үйл ажиллагаа	багш	816	0	2.05	2	0.671	1	3
	менежер	257	0	2.5	3	0.751	1	3

### Бага боловсролын багшийн хөгжих хэрэгцээ

		N		Mean	Median	Std. Deviation	Minimum	Maximum
		Valid	Missing					
Сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглах, шинэчлэх	багш	814	2	2.5	2	0.549	1	3
	менежер	257	0	1.75	2	0.453	1	3
Сүүлийн үеийн ном, гарын авлага, зөвлөмжөөр хангагдах	багш	814	2	2.63	2	0.531	1	3
	менежер	257	0	1.76	2	0.455	1	3
Лаборатори, компьютер ашиглах, интернэтийн орчинд ажиллах	багш	814	2	2.6	2	0.576	1	3
	менежер	257	0	1.86	2	0.348	1	3
Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх	багш	814	2	2.36	2	0.561	1	3
	менежер	257	0	1.38	2	0.517	1	3
